



## ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

*Боловсруулсан: МБСТ, Мөнгөний бодлогын хэлтэс  
2010 он*

*Энэ судалгаанд дурдагдсан аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь  
зөвхөн судлаачийн хувийн байр суурийг илэрхийлэх бөгөөд  
Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй болно.*

## ОРШИЛ

Хүүний түвшин нь санхүүгийн бүтээгдэхүүний үнийг тодорхойлдоогоороо санхүүгийн эх үүсвэрийг илүүдэлтэй хэсгээс хомсдолтой хэсэгт чиглүүлж, эдийн засаг дахь хуримтлал, хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлж байдаг. Банк, санхүүгийн байгууллагууд нэг талаас харилцах, хадгаламж татаж хүү төлдөг бол нөгөө талдаа зээл олгох, үнэт цаас худалдан авах замаар хүүний орлого олж байдаг билээ. Зээлийн хүү нь зээлийн хэмжээг тодорхойлдоогоороо үйлдвэрлэл, инфляцийн аль алинд нь шууд нөлөөтэй төдийгүй ДНБ-ий хэлбэлзлийг бий болгодог үндсэн хүчин зүйлийн нэг юм. Энэ утгаараа зээл нь мөнгөний бодлогын шилжих механизмын чухал сувгийн нэг нь болдог ба Төв банкны хувьд зээлийн хүүний нэрлэсэн болон инфляциар засварласан бодит хүүний аль аль нь чухал үзүүлэлт юм. Тухайлбал, нэрлэсэн хүү нь мөнгөний урсгалаар дамжин, харин бодит хүү нь хөрөнгө оруулалтаар дамжин инфляцид нөлөөлж байдаг. Хэдий хүүний түвшинд олон хүчин зүйлс нөлөөлж байдаг ч инфляци, түүний хүлээлт өндөр байх нь эцсийн дүндээ нэрлэсэн хүүнд эрсдэлийн урамшуулал хэлбэрээр тусгалаа олж зээлийн хүү өндөр түвшинд тогтоход хүргэдгийг мартаж болохгүй. Энэхүү судалгааны ажлаар манай улсын хувьд зээлийн хүүгийн түвшинд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо.

Зээлийн хүү нь микро хүчин зүйлс болох банкуудын үйл ажиллагаа болон макро хүчин зүйлс болох санхүүгийн зах зээлийн хөгжил, макро эдийн засгийн болон эрх зүйн орчны хүчин зүйлсээр тодорхойлогдож байна. Манай улсын хувьд тогтворгүй инфляци, өндөр инфляцийн хүлээлт, хадгаламжийн зах зээл дээрх эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн болон өндөр зах зээлийн эрсдэл зэрэг хүчин зүйлсээс зээлийн хүү голлон хамаарч байна. Хэрэв зээлийн хүүг зах зээлийн эдгээр бодит нөхцөлийн эсрэг захиргааны аргаар бууруулбал зах зээлийн үндсэн нөхцөлүүдийг гажуудуулж, санхүүгийн тогтвортой үйл ажиллагааны эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын хямралт байдлыг өдөөх сөрөг нөлөөтэй. Зээл, хадгаламж, хөрөнгө оруулалт болон бусад бүх төрлийн санхүүгийн хэлцлийн дүнд тохиролцож байгаа хүү нь нэг талаас талуудын мөнгөний ирээдүйн үнэ цэнийг тогтоож байгаа үнэлгээ юм. Энэ үнэлгээ нь уг чанартаа санхүүгийн зах дээр үүсч болох эрсдэлүүдийн үнэлгээ билээ. Хэрэв эрсдэлүүдийг бууруулж чадвал чөлөөт сонголттой эдийн засгийн орчинд хэлцэл хийж байгаа этгээдүүдийн тохиролцох хүү бидний хүсээд буй бага түвшинд хүрч буурах болно.

Дотоодын зах зээл дээр зээлийн хүүг тодорхойлоход голлон нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах 5 бүлэгт хуваан авч үзлээ. Үүнд:

1. Макро эдийн засгийн суурь нөхцөлүүд
2. Санхүүгийн зуучлал ба шууд санхүүжилт

3. Дотоод ба гадаад эх үүсвэр
4. Банкны салбарын хөгжил
5. Санхүүгийн системийн дэд бүтцийн хөгжил

Эдгээр хүчин зүйлсийг дотор нь нарийвчлан задалж, зээлийн хүүнд хэрхэн нөлөөлж байгаа талаар доор товчлон танилцуулъя.

## **1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ НӨХЦӨЛҮҮД**

Макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах нь захын тогтвортой байдал, гол санхүүгийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа гэх мэтээр олон асуудлыг хамрах боловч банкны зээлийн хүү бууруулахад хамгийн гол нөлөөтэй хүчин зүйл нь нам тогтвортой инфляци үргэлжлэн хадгалагдах юм. Инфляци нам түвшинд тогтвортой нэлээд хугацаанд байвал банкнаас мөнгө зээлсэн, мөнгөө хадгалуулсан харилцагсад, мөн түүнчлэн банкууд өөрсдийн шийдвэр гаргалтад хоорондоо ялгаатай өөрчлөлт оруулна. Учир нь банкны өөрийн үйл ажиллагааны шийдвэр болон харилцагчийн мөнгөө хадгалах, зээл авч хөрөнгө оруулалт хийх шийдвэр макро эдийн засгийн суурь нөхцөлүүдээс хамаарч байдаг. Тухайлбал инфляцийн түвшин өндөр, дээр нь тогтворгүй байвал хадгаламжийн хүүний бодит орлого буурч, иргэд мөнгөө банкинд хадгалах сонирхол бага байна. Иймээс инфляци өндөр үед банк хадгаламж эзэмшигчдээ алдахгүйн тулд хүүгээ бууруулахгүй байх шаардлагатай болно. Манай орны хувьд макро эдийн засгийн суурь нөхцөлүүд дотроос нам, тогтвортой инфляци болон хөрөнгийн гадагшлах урсгал нь зээлийн хүүг бууруулах эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэхэд хамгийн чухал тодорхойлогч хүчин зүйл болдог тул доор дэлгэрэнгүйгээр авч үзлээ.

### **1.1 Инфляцийг нам, тогтвортой байлгах**


Банкуудын хувийн секторт олгосон зээлийн хүү 2002-2008 оны хооронд 15 нэгж хувиар буурч жилийн 20 хувьд хүрчээ. Харин энэ хугацаанд хадгаламжийн хүү төдийлөн буураагүй бөгөөд зарим тохиолдолд өсөх хандлагатай байж, зээлийн хүүний бууралт нь хүүний зөрүүний бууралтаар хангагдаж байв. Иймээс цаашид зээлийн хүүг бууруулахын тулд банкуудын эх үүсвэрийн зардал буюу хадгаламжийн хүүг бууруулах эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай юм.

Хүү нь хадгаламж болон хөрөнгө оруулалтын шийдвэрээр дамжин өнөөгийн болон ирээдүйн эдийн засгийн төлөвийг холбож байдаг чухал үзүүлэлт юм. Хадгаламж эзэмшигчид мөнгөн хадгаламж болон бусад хөрөнгө оруулалтын боломжуудын хооронд ирээдүйд олох орлогоо тооцоолон сонголт хийж шийдвэр гаргадаг. Мөнгөн хадгаламжийн ирээдүйн орлого, түүгээр худалдан

авах хэрэглээ энэ сонголтын шийдвэрлэх үүрэгтэй шалгуур юм. Тиймээс ирээдүйд олох инфляциас давсан хүүгийн орлогын хэмжээ мөнгөн хадгаламжаа нэмэгдүүлэх эсвэл хорогдуулах шийдвэрийн үндэс болно. Үүнийг ирээдүйн бодит хүү гэх бөгөөд түүнд банкуудын төлж байгаа нэрлэсэн хүү, инфляци гэсэн хоёр зүйл нөлөөлнө. Хэрэв инфляцийн түвшин буурахгүй, түүний хэлбэлзэл тогтворгүй байх хүлээлттэй бол банк хадгаламжийн хүүгээ бууруулах нөхцөл бүрдэхгүй буюу банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн өртөг өндөр тогтож, улмаар зээлийн хүү өндөр байх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс инфляцийг нам, тогтвортой байлгах нь зээлийн хүүг бууруулах эдийн засгийн хамгийн гол нөхцөл юм.

1998-2008 онуудад Дэлхийн банкны ангиллаар өндөр орлоготой гэж тооцогддог орнуудад үнийн өсөлт жилд дунджаар 2-3 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол бага орлоготой орнуудад 5-10 хувийн хооронд хэлбэлзэж байжээ.<sup>1</sup> Манай орны хувьд сүүлийн арван жилд үнийн өсөлт хэрхэн өөрчлөгдөж ирснийг Зураг 1.1-д харууллаа. Эндээс харахад манай оронд үнийн өсөлт маш тогтворгүй явж иржээ. Энэ хугацаанд үнийн жилийн дундаж өсөлт 9 хувьтай байсан нь маш өндөр үзүүлэлт бол түүний дундаж хэлбэлзэл 7.3 хувьтай байсан нь тогтворгүй үзүүлэлт болохыг харуулж байна. 1999-2007 онуудад (сүүлийн хоёр хямралын жилүүдийг хасаад тооцоход) үнийн жилийн дундаж өсөлт 7.3 хувьтай, дундаж хэлбэлзэл 4.4 хувьтай байгаа нь бас л өндөр, тогтворгүй үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хувьд харьцангуй тогтвортой жилүүдийг аваад үзэхэд хүртэл үнийн өсөлт өндөр, түүний хэлбэлзэл тогтворгүй байжээ. Үнийн өсөлт байнга өндөр түвшинд байгаа нь үнийн өсөлт бий болно гэсэн иргэдийн хүлээлттэй холбоотой.

**Зураг 1.1: Жилийн инфляци, хувиар**



Эх сурвалж: Монголбанкны сарын бюллетень

<sup>1</sup> World Development Indicators мэдээллийн сан

Цалингийн өсөлт, төсөв, мөнгөний тэлэх бодлого, бодит эдийн засгийн хэт идэвхжил, үйлдвэрлэлийн зарлагын өсөлт зэрэг олон хүчин зүйлс үнийн өсөлтийг бий болгох боломжтойг олон тооны судалгаанууд харуулсан ч манай орны хувьд үнийн өсөлтийг маш их хэлбэлзэлтэй болгосон хоёр гол хүчин зүйл байгаа гэж үзэж байна. Нэгдүгээрт, сүүлийн жилүүдэд сангийн болон мөнгөний тэлэх бодлогыг эдийн засгийн өндөр өсөлттэй үед авч хэрэгжүүлсэн нь үнийн өндөр өсөлт бий болоход нөлөөлсөн, хоёрдугаарт инфляцийн хэлбэлзэл тогтворжихгүй байгаагаас инфляцийн хүлээлт буурахгүй байгаа бөгөөд үүнээс үүдэн мөнгөний бодлого тэр болгон үнийн өсөлтийг бүрэн хяналтандаа авч чадахгүй байгаа. Иймээс зээлийн хүү буурах эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэхийн тулд инфляцийг бууруулах, түүний хэлбэлзэл буюу хүлээлтийг тогтворжуулах шаардлагатай болоод байна. Энэ нь мөнгөний бодлогын үндсэн зорилт бөгөөд Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д жил бүр тодорхой зорилт тавьж түүнийгээ хангахын төлөө ажиллаж ирсэн. Гэсэн хэдий ч мөнгөний бодлого үндсэн зорилтоо бүрэн хангаж, инфляцийг нам түвшинд тогтворжуулж чадахгүй байгаа билээ. Энэ байдлыг арилгахын тулд дараах ажлуудыг цаашид хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

*Мөнгөний бодлогын хүрээнд:*

1. Мөнгөний бодлогын бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үүнд гол нь үйл ажиллагааны бие даасан байдлыг нэмэгдүүлэх
2. Инфляцийн хүлээлт тогтворжих хүртэл бодлогын альтернатив сонголтуудаас зөвхөн үндсэн зорилтоо хангахад чиглэсэн бодлогын сонголтыг тууштай барих, тэрхүү сонголт нь олон нийтэд ил тод байх
3. Монголбанк мөнгөний бодлогын үндсэн зорилтоо олон нийтэд тодорхой, ойлгомжтой болгох, мөнгөний бодлогын хэрэгжих хэлбэр, авах бодлогын алхмуудын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх замаар иргэдийн инфляцийн хүлээлтийг удирдах боломжоо нэмэгдүүлэх
4. Ханшийн бодлогыг хэрхэн явуулахаа олон нийтэд Монголбанк тодорхой болгох, ханшийн болон мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах бодлогын уялдааг тодорхойлох

*Төсвийн бодлогын хүрээнд:*

5. Хавтгайруулсан нийгмийн халамжийн бодлогыг хязгаарлах
6. Төсвийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх
7. ДНБ-д эзлэх Засгийн газрын төсвийн зардлыг 1-ээс дээш хувиар нэмэгдүүлэх талаар төсвийн тухай хуулийн төсөлд тусгах тохиолдолд Монголбанкнаас санал авах
8. Төсвийн тэлэх бодлого нь Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд заах зорилтод инфляцийн түвшинг

хангахад эрсдэл учруулахаар бол Монголбанк төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байх хүсэлтээ, үндэслэлийн хамт гарган Засгийн газар болон Улсын Их Хуралд хүргүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгох


9. Хөрөнгийн урсгал болон макро эдийн засгийн гадаад шокийн нөлөөг цаг алдалгүй, оновчтой удирдах зохистой бодлогыг хэрэгжүүлэх

## **1.2 Хөрөнгийн гадагшлах цэвэр урсгалын нөлөө**

Хөрөнгийн урсгал нь эдийн засгийн төрөл бүрийн сувгаар дамжин мөнгөний болон санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлдөг. Хөрөнгийн дотогшлох урсгал нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт болон зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг хэдий ч нөгөө талаас инфляцийг нэмэгдүүлэх, ханшийг чангаруулах болон гадаад өрийг нэмэгдүүлж, тогтворгүйжүүлэх сөрөг нөлөөг эдийн засагт үзүүлдэг. Энэ чиглэлээр хийгдсэн ихэнх судалгаануудад хэрэв тухайн улсын эдийн засгийн үндсэн нөхцөлүүд сайн бол хөрөнгийн дотогшлох урсгалын эдийн засагт үзүүлэх нөлөө эерэг, түүний үр өгөөж нь их байдаг гэж тодорхойлжээ.

Харин хөрөнгийн гадагшлах урсгал нь дотоод эдийн засгийн бодит болон санхүүгийн секторт сөрөг нөлөө үзүүлдэг. Эхний ээлжинд гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн сулрах дарамтыг бий болгон, гадаад валютын захыг тогтворгүйжүүлэн, Төв банк валютын захад оролцох тохиолдолд гадаад валютын нөөцийг бууруулахад хүргэдэг. Мөн нөгөө талаас Төв банк хөрөнгийн гадагшлах урсгалыг бүрэн хэмжээнд стерилизаци хийх тохиолдолд ч дотоодын санхүүгийн зах дээр дотоодын хөрөнгийн эрэлт буурч, хүүг өсгөх нөхцөлийг бий болгодог. Харин Төв банк стерилизаци хийхгүй тохиолдолд мөнгөний нийлүүлэлт буурч улмаар хүү улам ихээр өсөх нөхцөл болдог. Ийнхүү хөрөнгийн гадагшлах урсгал нь гадаад валютын болон мөнгөний захиудыг тогтворгүй болгон санхүүгийн хөрөнгийн нийлүүлэлтийг бууруулж, төлбөрийн тэнцлийг алдагдалд оруулж улмаар дотоод хүүг нэмэгдүүлэх нөхцөлийг богино хугацаанд бүрдүүлдэг. Энэ нь хүү, хөрөнгийн үнэ болон зээлийн сувгуудаар дамжин бодит секторт сөрөг нөлөөг үзүүлдэг. Иймд хөрөнгийн гадагшлах томоохон урсгал эсвэл хөрөнгийн орох урсгал зогсох нь зээлийн хүү буурах нэг гол нөхцөл юм.

Зураг 1.2. Хөрөнгийн цэвэр урсгал, түүний бүтэц, сая.ам доллар



Эх сурвалж: Монголбанк

Сүүлийн арван таван жилд хөрөнгийн цэвэр урсгал 2004 оноос бусад онуудад эерэг гарч байв (Зураг 1.2). 2006 он хүртэл хөрөнгийн цэвэр урсгалын хэмжээ нь урсгал дансны тэнцлээс бага хэмжээтэй, мөн үндэсний үйлдвэрлэл болон дотоодын санхүүгийн хөрөнгийн эх үүсвэртэй харьцуулахад харьцангуй бага дүнтэй байжээ. Иймээс түүний эдийн засагт үзүүлэх нөлөө бага байснаас макро эдийн засгийн бодлогыг тодорхойлохдоо төдийлөн анхаарч авч үздэггүй байв. Харин хөрөнгийн цэвэр урсгалын хэмжээ гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр сүүлийн 3-н жилд огцом өсч байгаагаас түүний эдийн засагт үзүүлэх нөлөө ч нэмэгдсээр байгаа тул хөрөнгийн томоохон урсгалыг зохистой удирдах асуудал зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн бодлого хөрөнгийн урсгалын хэмжээ болон огцом өөрчлөлтүүдийн нөлөөг урьдчилан тодорхойлж, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, тухайлбал зээлийн хүү өсөх сөрөг нөлөөг бууруулах бодлогын алхмуудыг авах шаардлагатай болдог.

Хөрөнгийн гадагшлах урсгалын нөлөөг оновчтой удирдахын тулд түүнийг бий болгодог эдийн засгийн дотоод хүчин зүйлсийг судлах, тэдгээрийг тогтвортой байлгахад анхаарах шаардлагатай юм. Үүнд:

- Дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадвар болон макро эдийн засгийн суурь нөхцөлүүдийг сайжруулж, тогтворжуулах (Үүнд ханш, хүү гэх мэт)
- Санхүүгийн зах зээлүүд, тэдгээрийн дэд бүтцийг хөгжүүлэх, санхүүгийн системийг гүнзгийрүүлэх
- Дотоодын эдийн засгийн гадаад эгзоген шокоос хамааралтай байдлыг бууруулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Урт хугацаатай гадаадын хөрөнгө оруулалтыг илүүтэй татах эдийн засгийн болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүнийг бүртгэх, хянах эдийн засгийн тогтолцоог бий болгох


- Богино хугацаатай хөрөнгийн дотогшлох урсгалд тодорхой шалгуур тавих замаар гадаад гэнэтийн шокоос шалтгаалсан хөрөнгийн гадагшлах урсгалын эрсдэлийг бууруулах
- Хөрөнгийн орох, гарах урсгалын тоон мэдээллийг богино хугацааны давтамжтайгаар (сар болон улирлаар) бүртгэх, нэгтгэх тогтолцоог улс орны хэмжээнд бий болгох, түүнийг бодлого боловсруулахад байнга анхаарч үзэх

## 2. САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ БА ШУУД САНХҮҮЖИЛТ

### 2.1. Хөрөнгийн захын хөгжил, түүний нөлөө

Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай, эдийн засгийн өсөлт харьцангуй бага, эсхүл тогтвортой бус байгаагийн гол шалтгааныг сүүлийн үеийн судалгаануудад эдгээр орнуудын санхүүгийн системийн хөгжил султай холбон тайлбарладаг. Мөнгөний бодлого нь санхүүгийн захаар буюу мөнгөний бодлогын сувгуудаар дамжин хэрэгждэг тул санхүүгийн зах зээлийн бүтэц, хөгжил нь мөнгөний бодлого амжилттай хэрэгжих үндэс болох төдийгүй бодит эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь хүчтэй эсвэл сул байхыг тодорхойлдог.

Зураг 2.1 Санхүүгийн захын хөгжил



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн зах дээрх зээлийн хүүний, зээлийн, валютын ханшийн, баялгийн, хүлээлтийн суваг гэсэн үндсэн таван сувгуудаар дамжин мөнгөний бодлого хэрэгждэг бөгөөд амжилттай эсэх нь эдгээр сувгуудын бодит эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хүчээс хамаарч байдаг. Улс бүрийн хувьд эдгээр сувгуудын нөлөөлөл нь харилцан адилгүй байдаг бөгөөд тухайн орны санхүүгийн захын бүтэц, хөгжлийн түвшнээр тодорхойлогддог. Харин санхүүгийн захын хөгжил нь Зураг 2.1-т схемчлэн үзүүлсэнчлэн олон хүчин зүйлсээс хамаарч байдаг.

Уг схемээс харахад санхүүгийн захын бүтэц, хөгжлийн түвшин нь мөнгөний бодлогын арга, хэлбэр, хууль эрх зүйн орчин, санхүүгийн системийн гүнзгийрэл, санхүүгийн эрх чөлөө, санхүүгийн бэхжилт, санхүүгийн шинэчлэл, төлбөр тооцооны дэвшил зэрэг хүчин зүйлсээс хамаарч байна. Үүнээс санхүүгийн системийн гүнзгийрэл нь хөрөнгийн захын хөгжил, зээлийн захын төгс бус байдлын бууралт, санхүүгийн эс зуучлал, бичил санхүүгийн хөгжлийн түвшинтэй уялдаж байдаг. Эдгээр хүчин зүйлс дундаас хөрөнгийн захын хөгжил нь санхүүгийн эс зуучлал, санхүүгийн шинэчлэл, санхүүгийн эрх чөлөө, мөнгөний бодлогын арга хэлбэр зэрэг хүчин зүйлс шууд болон шууд бус байдлаар нөлөөлж байдаг. Иймд санхүүгийн захын хөгжилд хөрөнгийн захын бүтцийг сайжруулж, хөгжлийн түвшинг нь нэмэгдүүлэх замаар нөлөөлөх боломж өндөр юм.

Сүүлийн үеийн эмпирик судалгаануудын үр дүнгээс харахад санхүүгийн захын хөгжил, тэр дундаа хөрөнгийн захын хөгжил нь бизнесийн санхүүжилтийн эх үүсвэрийн өртөгт дараах байдлаар нөлөөлдөг гэж үзэж байна. Үүнд:

*Санхүүгийн эс зуучлал нэмэгдэнэ:* Хөрөнгийн захын хөгжил нь санхүүгийн эс зуучлалыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Санхүүгийн системд арилжааны банкууд давамгайлж, зээлийн хүүний түвшин харьцангуй өндөр түвшинд тогтоход нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг гэж энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудад онцолсон. Ингэхдээ хөрөнгийн захын хөгжил сул байхад зээлийн хүүний хэлбэлзэл харьцангуй тогтвортой байх бөгөөд хөгжлийг даган уян хатан байдал нэмэгддэг болохыг харуулсан байна. Зээлдэгч, зээлдүүлэгчтэй холбоотой мэдээллийг боловсруулах, эдгээрээс үүдэлтэй асуудлууд болох тэгш бус мэдээлэл (asymmetric information), ёс зүйн гажуудал (moral hazard) зэргийг шийдвэрлэх тал дээр банкууд бусад санхүүгийн захын оролцогчдоос илүү туршлагажсан, илүү чадвартай санхүүгийн зуучлагч байж чаддаг. Харин хөрөнгийн захын хөгжил санхүүгийн эс зуучлалыг нэмэгдүүлэхэд зээлдэгчдийн дан ганц банкны сектороос хамааралтай байдлыг бууруулдаг. Хөрөнгийн зах хөгжих тусам санхүүгийн эс зуучлал нэмэгдэж, хөрөнгө оруулагчид, хадгаламж эзэмшигчид, болон зээлдэгчдэд илүү олон төрлийн сонголт бий болж, санхүүжилтийн хөрөнгө банкны сектороос хөрөнгийн зах руу шилжих боломж нэмэгддэг. Тухайлбал, иргэд болон аж ахуй нэгж, пүүс, компаниудад

хувьцаа, олон төрлийн бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг худалдах, худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх, санхүүжилт авах өргөн сонголтыг олгодог. Улмаар шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгддэг.

Сүүлийн жилүүдэд ихэнх орнуудад, хувийн секторын эзэмшиж буй үнэт цаас, хувьцааны хэмжээ нь банкны зээл олголтын хэмжээнээс илүү хурдацтайгаар өсч байна. Энэ нь дэлхий даяар банкны секторын эс зуучлалын хэмжээ нэмэгдэж буй хандлагыг илэрхийлж байна. Гэсэн хэдий ч зарим улс орнуудын хувьд банкны зээл санхүүжилтийн чухал эх үүсвэр хэвээр байсаар байна. Учир нь жижиг аж ахуй нэгжүүдийн хувьд хөрөнгийн захад оролцох боломж хязгаарлагдмал байдаг тул арилжааны банк жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд гол зээл олгогч хэвээр үлддэг.

*Санхүүжилтийн эх сурвалж олиширно:* Санхүүгийн эс зуучлал нэмэгдэх тусам урт хугацаат, хямд эх үүсвэр татах санхүүгийн хэрэгслүүд олширч, улмаар зээлийн захын өрсөлдөөн нэмэгдэж, банкны системийн давамгайлал буурч, улмаар хадгаламж, зээлийн хүүг бууруулдаг. Ингэснээр эх үүсвэрийн зардал буурч, өгөөж болон эрсдэл багатай хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх боломж бүрддэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн захын хөгжил санхүүгийн захын хөрөнгийн хуваарилалтын үр ашгийг сайжруулдаг.

Хөрөнгийн захын хөгжил арилжааны банкуудын харилцах, хадгаламж татан, зээл гаргадаг, хүүний орлогод түшиглэсэн уламжлалт бизнесийн үйл ажиллагааг шимтгэлд суурилсан үйлчилгээ рүү чиглүүлдэг. Хамгийн чухал нь хөрөнгийн захын хөгжилд арилжааны банкуудад санхүүжилтийн өөр нэг эх үүсвэр болж, зээлжих эх үүсвэрийн хязгаарлалтыг бууруулах нөлөөтэй. Хөрөнгийн захын хөгжил нэмэгдэх тусам арилжааны банкууд, болон бизнес эрхлэгчдэд урт хугацаат, хямд санхүүгийн эх үүсвэр татах орчин бүрдэж, улмаар зээлийн хүү буурах нэг нөхцөл бий болдог. Ингэснээр эх үүсвэрийн зардал буурч, өгөөж болон эрсдэл багатай хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжилт авах боломж нэмэгдэж, санхүүгийн захын хөрөнгийн хуваарилалтын үр ашгийг сайжруулдаг.

*Санхүүгийн шинэчлэлүүд үүснэ:* Хөрөнгийн захын хөгжил нь санхүүгийн шинэчлэл, тэр дундаа үүсмэл (уламжлагдсан) захын хэрэгслүүдийг санхүүгийн захад нэвтрүүлэх суурийг тавьснаар эдийн засгийн агентууд тодорхой бус байдлаас үүдэх эрсдэлийн зардлуудаа бууруулж, улмаар зээлийн хүү буурах бас нэгэн хүчин зүйл болдог.

Хөрөнгийн захын хөгжлийг даган санхүүгийн захын шинэчлэл явагдаж байдаг. Өргөн утгаараа санхүүгийн шинэчлэл нь бүтээгдэхүүний шинэчлэл, үйл ажиллагааны шинэчлэл гэсэн хоёр төрөлд хуваагддаг. Бүтээгдэхүүний шинэчлэлд компанийн бонд, уламжлагдсан (үүсмэл) захын хэрэгслүүд зэрэг багтдаг бол үйл ажиллагааны шинэчлэл нь үнэт цаасны захын өргөжилт,

шилжүүлэг, төлбөр тооцооны технологийн дэвшил зэргээр илэрч байдаг. Үнэт цаасжих/цаасжуулах болон үүсмэл захын хэрэгслүүд нь сүүлийн гучаад жилд хөгжиж ирсэн бөгөөд энэхүү захын хэмжээ томорч, улам боловсронгуй болсоор байна. Үнэт цаасжих үйл ажиллагаа нь хөрвөх чадвар муутай санхүүгийн хөрөнгийг хөрвөх чадвар сайтай, зах зээлд гаргах боломжтой хөрөнгө болгох боломжийг олгодог. Энэхүү боломжийн дагуу санхүүгийн байгууллагууд зээлийн багцаа бонд болгох замаар зээлийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж, зах зээлийн нөхцөл байдалтайгаа илүү зохицож ажилладаг. Улмаар банкуудын үнэт цаасжуулах, бонд шинээр гаргах зэрэг шимтгэлд түшиглэсэн үйл ажиллагаа нь санхүүгийн бус байгууллагуудын хүүний өглөгийг зах зээлийн хүүтэй нягт хамааралтай, мэдрэмжтэй болгодог. Энэ бодлогын хүүний нөлөөллийг нэмэгдүүлэх давуу талыг авчирдаг.

Хөрөнгийн захын хөгжил нь эдийн засгийн агентуудыг үүсмэл захын хэрэгслүүдийг ашиглан тодорхой эрсдэлийг хаах, эсвэл шилжүүлэх замаар капиталын зардлыг бууруулдаг. Мөн үүсмэл захын хэрэгслүүдийн хэрэглээ нэмэгдсэнээр нэгдүгээрт, бодлогын хүүний нөлөөг нэмэгдүүлдэг. Тухайлбал засгийн газрын болон компанийн бондын захын хоорондын хамаарлыг нягтруулж, улмаар богино болон урт хугацааны хүүний хамаарлыг сайжруулдаг. Хоёрдугаарт, үүсмэл захын хэрэгсэл богино хугацаат орлого, зардлын гэнэтийн өөрчлөлтөөс хамгаалахад зориулагдсан тул мөнгөний бодлогын өөрчлөлтөд үзүүлэх санхүүгийн захын хариу үйлдэл нь харьцангуй тогтвортой байж чаддаг.

*Бодлогын хүүний нөлөөлөл сайжирна:* Санхүүгийн захын хөгжил, тэр дундаа хөрөнгийн захын хөгжил нь мөнгөний бодлогын хэрэгсэл болох бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүд үзүүлэх дамжих нөлөө (transmission)-ний хүчийг нэмэгдүүлж, нөлөөлөл илрэх хугацааг нь богиносгодог.

Бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүд болон богино, урт хугацаат үнэт цаасны хүүд үзүүлэх дамжих нөлөө нь мөнгөний бодлогын шилжих механизмын чухал шинж болдог. Үүгээр мөнгөний бодлогын нийт эрэлт болон инфляцид нөлөөлөх чадварыг тодорхойлдог. Хэрэв дамжих нөлөө хүчтэй бөгөөд хурдан явагддаг бол мөнгөний бодлогын эх үүсвэрийн зардалд нөлөөлөх чадвар хүчтэй байх бөгөөд нийт эрэлт болон инфляцид нөлөөлөх чадавх өндөр байдаг.


Санхүүжилтийн эх үүсвэр татах боломж хязгаарлагдмал орнуудын хувьд зээлдэгчид банкнаас санхүүжилт авахаас өөр сонголтгүй болж, зээлийн хүү бодлогын хүүгээс харьцангуй мэдрэмж муутай байдаг. Энэ тохиолдолд арилжааны банкуудын эх үүсвэр татах өрсөлдөөн өндөр байж, тэр хэмжээгээр хадгаламжийн хүү, зээлийн хүү өндөр байх нэг шалтгаан болдог. Эмпирик судалгааны үр дүнгээс харахад бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүд үзүүлэх дамжих нөлөө санхүүгийн захын хэмжээ, бүтэц, өрсөлдөөний түвшинтэй

эрэг хамааралтай нь нотлогддог. Санхүүгийн захын өрсөлдөөний түвшин өндөрсөх, санхүүгийн захын хэмжээ томрох, бондын болон үнэт цаасны захын санхүүгийн захад эзлэх хувийн жин нэмэгдэх тусам бодлогын хүүний хадгаламжийн хүү болон зээлийн хүүд үзүүлэх дамжих нөлөө нэмэгдэж, мөнгөний бодлогын нөлөө илрэх хугацаа богиносч, мөнгөний бодлого үр ашигтай хэрэгжих боломжтой болдог.

### Монголын хөрөнгийн захын өнөөгийн байдал

Монголын санхүүгийн зах хөгжиж байгаа ч арилжааны банкууд давамгайлсан хэвээр байна. Санхүүгийн захын нийт активын 90-ээс дээш хувь нь арилжааны банкуудын активаар бүрддэг. 2009 оны эцсийн байдлаар санхүүжилтийн эх үүсвэрийн бүтцийг авч үзвэл банкуудын олгосон зээлийн хэмжээ нийт эх үүсвэрийн 90 гаруй хувийг бүрдүүлж байна. Хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудад банкны секторын санхүүжилт давамгайлах үүрэгтэй байдаг ч, хөрөнгийн захын хөгжлийг даган буурдаг. Харин Монгол улсын санхүүгийн захад банкны секторын давамгайллыг эс тооцвол бусад захын хөгжил, ялангуяа бонд, үнэт цаасны захын хөгжил маш сул байна. Иймд хөрөнгийн захын хөгжлийг түргэтгэж, хөгжлийн шинэ шатанд авчирч санхүүгийн захын өрсөлдөөн, үр ашгийг нэмэгдүүлэх нь нэн чухлаар тавигдаад байна.

Зураг 2.2. Санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Монгол улсын Засгийн газраас банк бус санхүүгийн секторыг хөгжүүлэх тал дээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч, энэхүү секторын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үүрэг хязгаарлагдмал хэвээр байсаар байна. Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн сектор, тэр дундаа хөрөнгийн захын нөхцөл байдал сайжирч байгаа боловч хууль эрх зүйн орчин сул, зохицуулалт, хяналт

шалгалт хангалттай бус, засаглалын тогтолцоо муу, хөрөнгө оруулагчдын итгэл сул зэрэг нь саад болсоор байна. Иймд банк бус санхүүгийн секторын активын хэмжээ санхүүгийн захын нийт активын ердөө 5 хүрэхгүй хувийг бүрдүүлдэг.

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) 2006 онд банк бус санхүүгийн захын зохицуулалтыг хийх үүрэгтэйгээр байгуулагдсан. СЗХ банк бус санхүүгийн байгууллагуудын хууль эрх зүйн орчин, зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсээр байгаа боловч, энэ салбарын дэд бүтэц хөгжил, боловсон хүчний мэдлэг боловсрол, удирдлагын чадвар сул байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

Монголын хөрөнгийн бирж (МХБ) 1991 онд улсын өмчийг хувьчлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор анх байгуулагдсан. 1992 оноос үнэт цаасны анхдагч зах зээлийг нээж, 1995 он хүртэл нийт улсын өмчийн 475 компанийн хувьчилсан. 1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа явагдаж эхэлсэн. Гэвч өнөөдрийн байдлаар МХБ хувийн аж ахуй нэгжүүд, санхүүгийн байгууллагууд урт хугацаат эх үүсвэр татдаг, хөрөнгө босгодог орчин үеийн хөрөнгийн бирж болон төлөвшиж чадаагүй байна.

**Зураг 2.3. Зах зээлийн үнэлгээ ба Үнэт цаасны бүртгэлтэй компаниуд**




Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгийн зах дээр МХБ нь цор ганц арилжаа эрхлэх байгууллага бөгөөд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага нэг, брокер, дилерийн 48 компани үйл ажиллагаагаа явуулж байна. 1995 онд МХБ дээр нийт 475 хувьцаат компанийн үнэт цаас бүртгэлтэй байсан бол 2009 оны эцсийн байдлаар нийтэд үнэт цаасаа санал болгон гаргасан 368 хувьцаат компани болж буураад байна. Эдгээр 368 хувьцаат компанийн 23 нь 100 хувь төрийн өмчит, 28 нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани байгаа бөгөөд үлдсэн бүрэн хувьчлагдсан 317 хувьцаат компанийн нэлээд хэсэг нь үнэн хэрэгтээ дампуурч, ямар ч хөрөнгөгүй болсон, бараг тал нь дөнгөж зардлаа нөхөх төдий хэмжээнд үйл


ажиллагаа явуулдаг, идэвхтэй арилжигддаг үнэт цаасны тоо цөөн байгаа нь зах зээлийн хөрвөх чадвар сул байгааг илтгэж байна (Зураг 2.3.).

**Зураг 2.4. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ болон арилжаа эргэлтийн тархалт**

**Зах зээлийн үнэлгээний тархалт**




**Арилжааны хуваарилалт**



Эх сурвалж: Монголбанк

Хамгийн том 10 компани нийт зах зээлийн үнэлгээний 67 хувийг, 20 компани 71 хувийг бүрдүүлдэг. Үлдсэн 344 хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээ нэг сая төгрөгөөс бага байна. Нийт арилжаа эргэлтийн 74 хувийг ТОП-20-н арилжаатай холбоотой байна (Зураг 2.4.). Компаниудын хувьд компанийн засаглалын ёс зүйн дүрмийг бараг дагадаггүй нь олон нийтийн хөрөнгийн захад итгэх итгэлийг нэмэгдүүлж чадахгүй байна. Тухайлбал, нийт 368 хувьцаат компаниас зөвхөн 144 компани нийтэд санхүүгийн тайлангаа мэдээлдэг боловч аудитын байгууллагуудын үнэлгээнд бүрэн итгэх бараг боломжгүй байдаг. Үүнээс манай үнэт цаасны зах цөөн хэдхэн хувьцаат компаниудын үйл ажиллагаанаас маш хүчтэй хамааралтай байгаа нь харагдаж байна.

Зах зээлийн үнэлгээний динамикаас харахад 1990 оноос тасралтгүй буурч байсан идэвхтэй арилжаалагддаг үнэт цаасны тоо 2006 оноос эдийн засгийн өсөлт, эдийн засгийн халалттай холбоотойгоор эргэн идэвхжиж, улмаар зах зээлийн үнэлгээ түүхэндээ байгаагүй түвшинд буюу 900 тэрбумд хүрсэн. Энэ нь 2000 оны түвшинтэй харьцуулбал бараг 30 дахин их юм. Гэвч 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр үнэт цаасны арилжааны идэвх суларч, 2009 оны эцсийн зах зээлийн үнэлгээ 600 тэрбум байна. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ хэдий өсч байгаа хэдий ч, 2009 оны эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээг ДНБ-тэй харьцуулахад 12 хувь байгаа нь ХонКонг (707%), Сингапур (643%), Малайз (400%), Өмнөд Солонгос (295%) зэрэг орнуудтай харьцуулахад тун бага үзүүлэлт (Зураг 2.5.) тул цаашид үнэт цаасны арилжааг улам идэвхжүүлж, хөрөнгийн зах зээлд оролцогчдыг нэмэгдүүлэх шаардлагатай юм.


**Зураг 2.5. ДНБ-д эзлэх зах зээлийн үнэлгээний хувь**

Эх сурвалж: Монголбанк

Үйлдвэр эрхлэгчид, санхүүгийн байгууллагууд хөрөнгийн захаар дамжуулан эх үүсвэр татах боломжийг хангалттай ашиглахгүй байсаар байна. 2005 онд хөрөнгийн захад анхны удаа Монгол Шилтгээн ХК-ний хувьцаа олон нийтэд санал болгох замаар арилжаалагдсан. Өөрөөр хэлбэл Монгол улсын хамгийн анхны IPO байсан. Түүнээс хойш нийт 14 удаагийн үнэт цаасыг олон нийтэд шинээр санал болгон арилжаалж, 56 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг татан төвлөрүүлжээ (Зураг 2.6.). Үүнээс 22.31 тэрбум орчим төгрөг Анод банк болон Зоос банктэй холбоотой бөгөөд бусад байгууллагуудын ихэнх нь үйл ажиллагаагаа эхлээгүй, өөрсдийн төслүүдээ хэрэгжүүлэхэд хүндрэл учраад байгаа, эсвэл бараа, үйлчилгээгээ борлуулж чадахгүй, хариуцлагагүй удирдлагууд, үүсгэн байгуулагчтай зэрэг асуудлуудтай тулгараад байгаа талаар дурдагджээ.

Мөн түүнчлэн бусад арилжааны банкууд хөрөнгийн захын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй, засгийн газрын болон компанийнн бондын захын хоёрдогч захын үйл ажиллагаа бараг явагддаггүй. Үүнд засгийн газрын болон компанийнн бондуудыг арилжааны банкууд худалдаж аваад эргэн төлөгдөх хугацаа хүртэл хоёрдогч захын арилжаанд огт оролцдоггүй байдал нөлөөлдөг. Үүний сацуу институционал хөрөнгө оруулагчид, зэрэглэл тогтоогч байгууллага, өгөөжийн муруй байгуулдаггүй, засгийн газрын үнэт цаасын арилжаа тогтмол явагддаггүй зэрэг нь хоёрдогч захын хөгжлийг хойш нь татсаар байна (Зураг 2.6.).

Зураг 2.6. Нийтэд шинээр санал болгосон хувьцаанууд



Эх сурвалж: Монголбанк

## 2.2. Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд Монголбанкны оролцоо

Хөрөнгийн захыг хөгжүүлэхийн тулд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо, Сангийн яам, Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо, Монголбанкны хамтын үйл ажиллагаа, нэгдсэн бодлого авч хэрэгжүүлэх нь зайлшгүй болоод байна. Монголбанкны зүгээс энэхүү захын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд үзүүлэх нөлөөлөл харьцангуй хязгаарлагдмал ч дараах байдлаар оролцох боломжтой. Үүнд:

1. Үнийн түвшний тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, улмаар хөрөнгө оруулагчдад эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж өгөх.
2. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах замаар санхүүгийн захын тогтвортой байдалд нөлөөлж, цаашид хөгжүүлэх чиглэлд хөтлөх.
3. Мөнгөний захын үйл ажиллагааг сайжруулах замаар, хөрөнгийн анхдагч болон хоёрдогч захын хөгжлийг дэмжих.
4. Өгөөжийн муруйг байгуулахад Засгийн газартай хамтран ажиллах, Монголбанкны зүгээс шаардлагатай мэдээллээр тогтмол хангаж байх.
5. Зэрэглэл тогтоох агентлагуудад зээлийн мэдээллийн сангаар хангах.

### Үнийн түвшний тогтвортой байдлыг хангах

Санхүүгийн захын хөгжил, түүн дээр гарч буй өөрчлөлтүүд нь мөнгөний бодлогын шилжих механизмд нөлөөлж байдаг тул мөнгөний бодлогын арга хэлбэрийг эргэн харах шаардлагатай болдог. Тиймээс үр ашигтай, жигд, тасралтгүй үйл ажиллагаатай санхүүгийн зах нь мөнгөний бодлогын нөлөөг

тодорхой, тогтвортой байхын үндэс болох учир санхүүгийн захын гүнзгийрэл, интеграци нь бодлого тодорхойлогчид, тэр дундаа төв банкны байнга анхаарч, нягталж байх чухал асуудлуудын нэг юм.

Санхүүгийн захын үйл ажиллагаа, интеграцийн жигд, тасралтгүй, тогтвортой байдлыг хангаж, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихэд төв банкны оруулж чадах хамгийн сайн хувь нэмэр нь дунд хугацааны үнийн тогтвортой түвшинг хангах явдал юм. Энэхүү бодлого нь инфляцийн сөрөг нөлөөг багасгаж, өндөр инфляциас үүдэх тодорхой бус байдлыг арилгах ач тустай. Үнийн түвшний тогтвортой байдал нь дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн таатай орчин бий болгохоос гадна эдийн засгийн агентуудын дунд инфляцийн зардал жигд бус хуваарилагдсанаас үүдсэн нийгэм эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулдаг. Мөн инфляцийн хүлээлт нам түвшинд байна гэсэн хүлээлт үүссэнээр инфляцийн эрсдэлийн хувь хэмжээ буурч, улмаар санхүүгийн үнэ тогтоолтод үзүүлэх нөлөө нь багасдаг. Үүний үр дүнд зээлийн эрсдэл зэрэг бусад хүчин зүйлс санхүүгийн захын үнэ тогтоолтод (хадгаламжийн хүү, зээлийн хүү гэх мэт) илүү чухал байр суурийг эзэлж, улмаар санхүүгийн нөөцийн үр ашигтай хуваарилалт явагддаг.

### **Санхүүгийн захын тогтвортой байдлыг хангах**

Санхүүгийн зах тогтвортой буюу олон нийтэд итгэлтэй байх нь эх үүсвэрийн зардал буурах, хөрөнгө оруулалтын өсөлтөөр эдийн засгийг дэмжих орчныг улам нэмэгдүүлдэг. Санхүүгийн захын зохистой зохицуулалт эдийн засгийн өсөлтөд чухал үүрэгтэй болохыг 2008 онд нүүрлэсэн санхүү, эдийн засгийн хямрал улам тодотгож өгсөн билээ. Банкны системийн хяналт шалгалт санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах, хөрвөх чадварын гэнэтийн цочролыг уусган арилгах зэрэг санхүүгийн системийн чадавхыг тодорхойлогч бөгөөд санхүүгийн тогтвортой байдлын хамгаалагч болж байдаг. Санхүүгийн хямрал эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэйг зарим улс орнуудад бий болсон санхүүгийн системийн тогтворгүй байдал харуулсаар байна. Санхүүгийн захын тэр дундаа банкны системийн зохистой хяналт шалгалтыг сайжруулах нь дараах хоёр чиглэлээр эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Үүнд: нэгдүгээрт, санхүүгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх үүднээс зохистой хяналт шалгалт тасралтгүй, төгс төгөлдөр байх ёстой. Хоёрдугаарт, хямрал нүүрлэсэн тохиолдолд шат дараатай, түргэн шуурхай, оновчтой шийдвэр гаргалтад мөн хяналт шалгалтын үүрэг нэн чухал. Хянан шалгагчдын үүрэг системийг бүхэлд нь халдварлуулах аюул, түүний үр дагаврыг урьдчилан илрүүлэхэд оршдог. Иймд санхүүгийн байгууллагуудын, ялангуяа банкуудын аюулгүй, найдвартай байдлыг илэрхийлэх микро-зохистой байдлын мэдээлэл, системийн эрсдэлийн хэмжээг хянах, макро эдийн засаг эсвэл санхүүгийн хөгжлөөс урган гарах санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюулыг урьдчилан

тодорхойлох үйл ажиллагаа болох макро-зохистой дүн шинжилгээтэй холбох чадвартай байх нь нэн чухал юм.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах уламжлалт болон макро-зохистой шинжилгээ хийх тал дээр нэгэнт мэргэшсэн байдал нь төв банкны хяналт шалгалтын үүргийг улам өндөрсгөдөг. Мөн түүнчлэн төв банк арилжааны банкуудын микро-зохистой мэдээллийг тасралтгүй, жигд ашиглалтыг сайжруулах, дүн шинжилгээг сайтар хийж, болзошгүй системийн эрсдэлээс урьдчилан сэргийлж байх үүрэгтэй. Энэхүү үүргийн дагуу Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах ажлын хүрээнд 2010 онд дараах зорилтуудыг дэвшүүлээд байгаа билээ. Үүнд:

- Банкны өөрийн хөрөнгийн хүндрэлийг арилгах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг Засгийн газартай хамтран олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- Иргэд, бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдаас банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах зорилгоор банкны хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтран нэвтрүүлнэ. Мөн хадгаламжийн даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- Банкны системд бүтцийн өөрчлөлт хийж, эрсдэл даах чадвартай, удирдлагын сайн засаглалын зарчимд тулгуурласан, санхүүгийн зуучлалыг үр өгөөжтэй явуулахуйц банкны тогтолцоог бий болгох дунд хугацааны хөтөлбөр Засгийн газартай хамтран боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.
- Эрсдэлд суурилсан банкны зохистой харьцааны үзүүлэлтийг хангуулан, санхүүгийн сахилга батыг чангатгаж, банкны санхүүгийн тайлагнал болон өмчлөлийн байдлыг олон нийтэд нээлттэй ил тод болгон, санхүүгийн салбарт компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлнэ.

### **Мөнгөний захын үйл ажиллагааг сайжруулах**

Хөрөнгийн анхдагч, хоёрдогч, мөн бондын захыг хөгжүүлэхийн тулд мөнгөний зах сайн хөгжсөн байх нь зайлшгүй бөгөөд чухал үүргийг гүйцэтгэж байдаг. Үүнд:

- Зах зээлд суурилсан мөнгөний бодлогын хэрэгслүүдээр дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх
- Богино хугацааны өгөөжийн муруйг байгуулах
- Гадаад валютын захын хөгжлийг дэмжих

- Зээлийн хүү болон богино хугацааны өгөөжийн муруйгаар илэрхийлэгдэх эдийн засгийн хүлээлтийг бий болгох
- Арилжааны банкууд болон тэдгээрийн харилцагчдын хөрвөх чадварын удирдлагыг сайжруулах, санхүүгийн зуучлал дахь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх

Харин богино хугацаатай ЗГ-ын бондын арилжааг идэвхжүүлэх нь урт хугацаатай компанийн бондын зах хөгжих эхний алхам болно. Мөнгөний захын үр ашигтай үйл ажиллагаа нь богино хугацаат өрийн хэрэгслүүдийг ихэвчлэн ашигладаг манай ЗГ-ын санхүүжилтийн зардлыг бууруулах боломжтой.

Үр ашигтай мөнгөний захын хөгжил нь дараах гурван нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Төв банк арилжааны банкуудын хөрвөх чадварыг шууд хангадаг мөнгөний бодлогын хэрэгслээс татгалзах эсвэл бууруулах замаар зах зээлд суурилсан арга хэрэгсэлд шилжих,
- Банкны системийн нэгдсэн болон Засгийн газрын нөөцийн удирдлагыг сайжруулах, таамаглалыг оновчтой хийдэг болох
- Банк болон бусад санхүүгийн байгууллагуудын хөрвөх чадварын болон эрсдэлийн удирдлагыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх зэрэг болно.

Банк хоорондын зах сайн хөгжөөгүй манайх шиг орны хувьд мөнгөний бодлогыг заавал байх нөөцийн хувь хэмжээ, аль нэг эдийн засгийн салбарт хүчээр зээл гаргах зэрэг шууд зохицуулалтаар хийдэг бөгөөд энэ тохиолдолд хөрвөх чадварын удирдлагыг оновчтой хийхэд хүндрэл учирдаг.

Мөн жижиг, сул банкууд банк хоорондын захын идэвхтэй үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байдаг. Нөөцийн илүүдэлтэй банкууд нөөцийн хомсдолтой банкуудад зээл олгох нь эрсдэлтэй болон өрсөлдөөний улмаас тэднийг дэмжих сонирхолгүй байх талтай. Монголбанк өмнө нь 7, 14, 28, 84 болон 180 хоногийн хугацаатай ТБҮЦ гаргаж хүүн дээр дээд хязгаар тогтоож байсан нь өгөөжийн муруйны утга санаатай харшилдаж байв. Учир нь өгөөжийн муруйг зах зээл биш Монголбанк тодорхойлж байсан бөгөөд арилжааны жигнэсэн дундаж хүү нь хүүний дээд хязгаартай маш ойр тогтож байв.

Ийм учраас 2007 онд Монголбанк зөвхөн 7 ба 28 долоо хоногтой үнэт цаасыг авч үлдсэн бөгөөд 28 долоо хоногтой ТБҮЦ-ны хэмжээг хязгаарлан хүүгээр өрсөлдүүлэн 4 долоо хоногийн давтамжтай зохион байгуулах болсон билээ. 6, 5, 4, 3, 2 болон 1 сарын үлдэгдэлтэй ТБҮЦ эргэлдэх болсон нь мөнгөний захын өгөөжийн муруйг захаар өөрөөр нь тодорхойлуулах анхны оролдлого байсан юм.

Иймээс өрсөлдөөнийг хөхүүлэх үүднээс 2009 оны 3 дугаар сараас 28 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг зогсоож, 12 долоо хоногтой үнэт цаас руу

шилжүүлэн банкуудад арилжаалах болсон билээ. Ингэснээр ТБҮЦ-ны хугацаа банкуудын эх үүсвэрийн дундаж хугацаатай ойртож арилжаанд оролцогсдын тоо нэмэгдэхээр хүлээгдэж байв.

Харамсалтай нь ТБҮЦ-ны хугацааг богиносгосон энэхүү арга хэмжээ өнөөгийн санхүүгийн хямрал, зээлийн тасалдлаас болоод өрсөлдөөний үр ашгийг нэмэгдүүлсэн гэж үзэх боломжийг олгохгүй байна.

### **Өгөөжийн муруйг байгуулахад ЗГ-тай хамтран ажиллах, Монголбанкны зүгээс шаардлагатай мэдээллээр тогтмол хангаж байх**

Олон улсын туршлагаас харахад хөрөнгийн захын үйл ажиллагаанд Сангийн яам манлайлах үүрэгтэйгээр оролцох учиртай. Арилжаалж буй үнэт цаасны хугацаанаас шалтгаалан мөнгөний (1 хүртэл жилийн) болон хөрөнгийн (1 жилээс дээш) гэсэн 2 төрлийн санхүүгийн зах байдаг. Ингэснээр өгөөжийн муруй нь мөнгөний болон хөрөнгийн захын хэрэгслүүдийн хүү хугацаанаасаа хэрхэн хамаарч буйг харуулах маш чухал дохио болдог. Тэгвэл Төв банк өгөөжийн муруйн хамгийн эхний цэг буюу маш богинохон хэсэг дээр үйл ажиллагаагаа явуулж байдаг. Тухайлбал, хөгжингүй орны Төв банк овернайт хүүг тодорхойлон ажилладаг бол Засгийн газар муруйн үлдсэн хэсэг дээр үнэт цаас гаргадаг байна. АНУ-ын ХНБ овернайт хүүг онилдог бол Засгийн газар 3, 6 сарын, 1, 2, 5, 10, 30 жилийн хугацаатай үнэт цаас гаргадаг байна. Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) төсвийн алдагдлыг санхүүжүүлэх хэрэгсэл болдог төдийгүй хөрвөх чадвар өндөртэй санхүүгийн хэрэгсэл гэдэг утгаараа өгөөжийн муруйг гаргаж авах үндсэн эх сурвалж болно. Хөрөнгө оруулагчид өгөөжийн муруйн жишиг хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглах замаар шийдвэрээ гаргаж байдаг. Өгөөжийн муруй тасрахгүй буюу ширгэхгүй байх нь (өөрөөр хэлбэл, үнэт цаас байнга арилжаалагдаж байх) хамгийн чухал бөгөөд зөвхөн ингэж чадсан нөхцөлд санхүүгийн хэрэгслийн хөрвөх чадвар хангагдаж хоёрдогч зах байнгын ажиллагаатай болох боломжтой. Зарим засгийн газар хангалттай хэмжээний хуримтлалтай хэр нь үнэт цаас гаргаж байдаг нь үүний жишээ юм.

Эндээс харахад Монголбанк өгөөжийн муруйн зөвхөн эхний цэгийг буюу 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүг, харин Засгийн газар өгөөжийн муруйн үлдсэн хэсгийг хариуцан ажиллах учиртай юм. Харин өгөөжийн муруй бий болоход Монголбанк инфляцийг бага түвшинд тогтворжуулах нь маш чухал юм. Инфляцийг тогтвортой бага түвшинд байлгахгүй бол хүүний савлагаа арилахгүй бөгөөд улмаар урт хугацаат өрийн зах зээлийн хөгжил саатсаар байх болно.

Монгол улсын Засгийн газар үнэт цаасыг зөвхөн төсвийн цоорхой нөхөх төдий түвшинд ойлгож, хааяа нэг тохиолдлын шинжтэйгээр арилжаалж ирсэн нь өрийн зах үр хөврөлийн шатанд байхад хүргэж байна. Нэгэнт Засгийн газар

зардал гаргахаас эмээж үнэт цаас гаргахгүй ирсэн тул (тэр тусмаа төсөв ашигтай байх үед) мөнгөний захын өгөөжийн муруйг 7 хоногоос цааш сунгах гэсэн Монголбанкны оролдлого төдийлөн үр дүнтэй байсангүй. Учир нь 7 хоногоос урт хугацаатай үнэт цаас арилжаалах нь эдийн засгаас мөнгө татах, банкуудыг эрсдэлгүй хөрвөх чадвар сайтай санхүүгийн хэрэгслээр хангах зорилгоор ашиглагдаж байсан болохоос биш өгөөжийн муруйг бий болгоход анхнаасаа чиглэгдээгүй юм. Тийм шаардлага ч Монголбанкны хувьд байхгүй билээ. Тэгвэл яагаад урт хугацаатай ТБҮЦ-ыг Монголбанк Хөрөнгийн биржээр дамжуулан гаргах шаардлагатай вэ? Энэ нь 6 болон 3 сартай ТБҮЦ-ны арилжааны өрсөлдөөн сул, хүүний хөдөлгөөн нь инфляциас төдийлөн хамааралгүй, цөөн банк давуу эрх эдэлж байгаа, хүүний сувгийг илүү мэдрэмтгий болгох шаардлагатай холбоотой юм. Иймд мөнгөний захыг хөгжүүлэхэд засгийн газрын оролцоо буюу засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай бөгөөд 1-5 жилийн хугацаатай үнэт цаасыг тогтмолжуулах нь зүйтэй юм.

ТБҮЦ-ны анхдагч арилжаанд цөөн хэдэн банк давамгайлж байгаа нь мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг сулруулж байна. Иймээс мөнгөний захын оролцогсдыг банк бус байгууллагуудаар өргөжүүлэх боломжийг судлах шаардлагатай байна. ЗГҮЦ болон ТБҮЦ-ны арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулан Нийгмийн даатгалын сан, даатгалын 17 компани, томоохон корпорациудыг хамруулах замаар анхдагч захыг өргөжүүлэх боломж бий. Ингэснээр өрсөлдөөн мэдэгдэхүйц нэмэгдэх төдийгүй хүү илүү зах зээлийн зарчимд нийцтэй байдлаар тогтохоор хүлээгдэх юм. Үүний сацуу хөрөнгө оруулагчдын суурийг өргөтгөх, институциональ хөрөнгө оруулагчдыг бий болгон төлөвшүүлэхэд энэхүү алхам чухал хувь нэмэр оруулах болно.

Арилжааг Хөрөнгийн биржээр дамжуулан зохион байгуулсан тохиолдолд төлбөр тооцооны эрсдэлийг Монголбанк хүлээхгүй ч үйл ажиллагааны болоод нэр төрийн эрсдэлийг хянах боломжгүй сул талтай юм. Хэдийгээр ТБҮЦ-ны зардал арилжааны шимтгэл хэлбэрээр нэмэгдэх ч хүүний бууралтаар үүнийг нөхөх бүрэн боломжтой юм. Мөн арилжааны банкууд ТБҮЦ болон ЗГҮЦ-ны арилжаанд идэвхтэй оролцох үүднээс брокер, дилерийн компаниудтай хамтран ажиллах, эсхүл хөрөнгийн биржид өөрсдийн суудалтай болох шаардлагатай тулгарна. Энэ нь арилжааны банкуудыг хөрөнгийн захын үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх боломжтой юм.

### **3. ДОТООД БА ГАДААД ЭХ ҮҮСВЭР**

Банкуудын татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн дийлэнхийг хадгаламж бүрдүүлж байгаа нь хадгаламжийн хүү, улмаар зээлийн хүү буурахгүй байх нөхцөл болсоор байна. Иймд банкны эх үүсвэрийн зардлыг бууруулах, төрлийг олшруулахын


тулд гадаадын томоохон банкныг дотоодын банкны салбарт нэвтрэх, хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, мөн дотоод эх үүсвэрийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд банкны өргөжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлэх болон банк хоорондын захыг хөгжүүлэх асуудлуудыг энэ бүлэгт товчлон танилцуулж байна.

### 3.1 Банкны өргөжилт

#### Зээл, хадгаламжийн хүүний хөгжил

Ихэнх хөгжиж буй орны адил манай орны санхүүгийн гол зуучлагч нь арилжааны банкууд байсаар байна. Банкны зуучлалын үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгө илүүдэлтэй байгаа зээлдүүлэгчээс шаардлагатай байгаа зээлдэгчид хөрөнгийг шилжүүлэх, эдийн засаг дахь хязгаарлагдмал эх үүсвэрийг үр өгөөжтэй байдлаар эргэлтэд оруулахад чиглэдэг. Банкныг хадгаламж, зээл гэсэн үндсэн 2 бүтээгдэхүүнтэй гэвэл үйл ажиллагааны зардал, эрсдэлийн үнэ, ашгийн хувь зэрэг нь зээл болон хадгаламжийн хүүний зөрүүнд шингэдэг. Иймд банкны хүүний зөрүү бага байх нь банкны зуучлал илүү үр өгөөжтэй байгааг илэрхийлдэг. Харин банк хадгаламжийн хүүгээ үйл ажиллагааны орлого, зардал болон зах зээл, макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд суурилан тодорхойлдог.

Зураг 3.1. Зээл, хадгаламжийн хүү болон хүүний зөрүүний динамик хандлага<sup>2</sup>



Эх сурвалж: Банкны салбарын баланс болон орлого, зарлагын тайланд үндэслэсэн судлаачийн тооцоо

Сүүлийн жилүүдэд арилжааны банкны зээл болон хадгаламжийн хүүний зөрүү буурч байгаа хэдий ч хадгаламжийн хүү дорвитой буурахгүй байгаа. Сүүлийн 7 жилд зээлийн хүү 18 нэгжээр буурахад хадгаламжийн хүүнээс илүүтэй хүүний

<sup>2</sup> Энэхүү танилцуулганд зээл, хадгаламжийн хүүг “ex-post” аргаар тооцов. Банкны салбарын зээл, хадгаламжийн хүүг 2002-2009 оны хооронд тооцож Зураг 1-т үзүүлэв.

зөрүүний бууралт гол үүрэг гүйцэтгэжээ. Зах зээлийн эдийн засгийн шилжилт эхэлснээс хойш манай орны зээл, хадгаламжийн хүү Төв болон Зүүн Европ, Балтын 3 улс, Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөл (ТУХН)-ийн гишүүн орнууд болон Азийн зарим хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад хавьгүй өндөр түвшинд байна.

Бодитоор төлөгдсөн зээлийн хүү сүүлийн 7 жилийн хугацаанд 2 дахин буурсан боловч 2008 оны эцэст 18.2 хувь байсан бол 2009 эцэст 19.4 хувь болсон байна. Энэхүү зээлийн хүүний сүүлийн 2 жилийн өсөлтөд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр зах зээлийн болон зээлийн эрсдэл өссөн нь голлон нөлөөллөө (Зураг 3.2).

**Зураг 3.2. Зээлийн хүү болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**



Эх сурвалж: Банкны салбарын баланс болон орлого, зарлагын тайланд үндэслэсэн судлаачийн тооцоо

Харин хадгаламжийн хүүний хувьд өнгөрөгч онуудад ерөнхийдөө харьцангуй тогтвортой байсан хэдий ч эдийн засгийн хямралаас шалтгаалсан банкуудын эх үүсвэрийн бууралт, өндөр инфляци зэргээс үүдэн 2008 оны эхний 3 улиралд нэлээд өссөн. 2008 оны эцэст хадгаламжийн хүү эргэн буурсан нь инфляцийн бууралт, зээлийн тасалдал зэргээс голлон шалтгаалсан байна (Зураг 3.1).

Олон улсын санхүүгийн байгууллагын судалгаагаар манай орны зээлийн хүү харьцангуй өндөр байгаа ч хүүний зөрүү 2007 оноос эхлэн бусад шилжилтийн эдийн засагтай орнуудын түвшнээс бага болж байгааг онцолсон. Хүүний зөрүү улс орнуудын хувьд ялгаатай байх нь санхүүгийн салбарын дэд бүтцийн үр ашиг, санхүүгийн салбар дахь хууль эрх зүйн орчны ялгаатай байдал, макро эдийн засгийн тогтвортой байдал болон зах зээлийн бүтэц зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг. Манай орны хувьд банкны салбарын либералчлал, макро эдийн

засгийн тогтвортой байдал зэрэг нь банкны салбарын үр ашгийг нэмэгдүүлж хүү буурах бололцоог бүрдүүлсэн гэж үзэж болно.

Монголбанкны 2006 онд хийсэн судалгаагаар хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад манай орны **зээлийн хүү** харьцангуй өндөр байгаа нь хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотой гэж дүгнэсэн бөгөөд энэ байдалд банкууд хоорондын болон банк, хадгаламж зээлийн хоршоодын хоорондын эх үүсвэрийн төлөөх үр ашиггүй өрсөлдөөн нөлөөлж байгааг онцолсон байдаг<sup>3</sup>.

Манай орны хувьд зээлийн хүүнд **валютын ханш, БХЗ-ийн хүүний хэлбэлзэл болон зээлийн эрсдэл** зэрэг нь тусгалаа олж байгаа бол хадгаламжийн хүүнд **инфляци, валютын ханшийн сулралт болон БХЗ-ын хүү, хадгаламжийн зах зээлийн бүтэц, өрсөлдөөн** зэрэг хүчин зүйлс нөлөөлж байгааг дээрх эмпирик судалгаагаар нотолсон. Хэдийгээр өрсөлдөөн нь зээлийн хүү буурахад чухал хүчин зүйл мэт ойлгогддог боловч нөгөө талдаа хэт их өрсөлдөөн нь хадгаламжийн хүүг өндөр байлгах бас нэг хүчин зүйл болсоор байгааг анхаарах хэрэгтэй юм.

### **Банкны өргөжилт (Banking consolidation) болон зээл, хадгаламжийн хүү, хүүний зөрүү**

1980-аад оны дундаас дэлхий даяар банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд нийлж, нэгдэх үзэгдэл ихээр дэлгэрч санхүүгийн системийн бүтцийн өөрчлөлт болон нэгдэл идэвхтэй явагдаж эхэлсэн. Харин Азийн орнуудад 1990-ээд он хүртэл санхүүгийн байгууллагуудын тоо нэмэгдэж байсан бол 1997 оны хямралын дараагаас санхүүгийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлт болон нэгдэл олширч өрсөлдөөнийг идэвхжүүлэх түвшинд зах зээлийн төвлөрлийг бий болгосон.

Банкны өргөжилт, зах зээлийн өрсөлдөөний хэлбэр болон төвлөрөл нь санхүүгийн бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, түүн дотроо зээл, хадгаламжийн хүү тогтоход чухал нөлөөтэй байдаг. Онолын хувьд өргөжилт нь хадгаламжийн хүү, хүүний зөрүү болон зээлийн хүүг бууруулах чиглэлд нөлөөлдөг гэж үздэг. Учир нь банкууд хэлцлийн давуу эрхээ хадгаламжийн зах зээл дээр илүү эдлэх боломжтой байдаг бөгөөд улмаар хадгаламжийн хүү буурдаг байна. Мөн түүнчлэн том банкууд зардлаа бууруулж, хүүний бус орлогоо нэмэгдүүлэх, эрсдэлийг илүү сайн удирдсанаар өндөр үр ашигтай ажиллах боломжтой байдаг. Дээрх шинж чанараас хамааран том банкууд бага хүү санал болгосон ч хадгаламж эзэмшигчид хадгаламжаа байршуулах сонирхол өндөр байдаг байна.

---


<sup>3</sup> Д.Ган-Очир (2009) “Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны ажлаас дэлгэрэнгүй харах боломжтой.

Иймд зах зээлд өрсөлдөөн суларч, төвлөрөл нэмэгдэх нь хадгаламжийн хүүгээ бууруулах боломжийг том банкуудад олгодог. Нөгөө талаас банк томорсноор олон төрлийн эх үүсвэрээс хөрөнгө татах бололцоо нэмэгддэг бөгөөд энэ нь харьцангуй бага хүүгээр хадгаламж татах бололцоог том банкуудад олгодог юм.

Өргөжилт нь хадгаламжийн хүүнд дээрх байдлаар нөлөөлдөг бол хүүний зөрүү болон зээлийн хүүнд дараах байдлаар нөлөөлдөг гэж үздэг. Банкууд нэгдэн, нийлж томорсноор үйл ажиллагааны нэгжийн зардал буурч, ашгаа нэмэгдүүлэх боломжтой болж улмаар өргөжилтийн үр өгөөж ажиглагддаг (economies of scale). Үйл ажиллагааны нэгжийн зардал буурснаар хүүний зөрүү буурч, улмаар банк зээлийн зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хүүгээ бууруулдаг байна.

Гэхдээ банк өргөжсөнөөр хадгаламжийн хүү буурч, улмаар хүүний зөрүү болон зээлийн хүү шууд буурна гэж ойлгож бас болохгүй бөгөөд банкууд хадгаламжийн хүүгээ бууруулсан ч хүүний зөрүүгээ нэмэгдүүлэх замаар зээлийн хүүг бууруулахгүй байх эрсдэл учирч болох юм. Хэдийгээр банк зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх түвшинд өргөжиж, томрох нь зээлийн хүү буурахад чухал хүчин зүйл мэт ойлгогддог боловч нөгөө талдаа хэт их өрсөлдөөн нь хадгаламжийн хүүг өндөр байлгах бас нэг хүчин зүйл болсоор байгааг анхаарах хэрэгтэй юм (Зураг 3.3). Мөн банк томорсноор зах зээлд хэт монополь шинж чанартай оролцож, зах зээлийн өрсөлдөөнийг бууруулах эрсдэлтэй тул үүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг эргэн харж, сайжруулах шаардлагатай байдаг. Сүүлийн жилүүдэд манай банкны салбар төвлөрлийн өндөр зэрэгтэй байгааг хадгаламжийн зах зээлийн  $\frac{3}{4}$ -ийг, зээлийн зах зээлийн  $\frac{3}{5}$ -ийг томоохон 3 банк эзэлж буйгаас харж болно (Зураг 3.3 & 3.4). Төвлөрөл нь эрсдэл даах чадавхтай, олон төрлийн үйлчилгээтэй санхүүгийн салбарыг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

**Зураг 3.3. Хадгаламж, зээлийн зах зээл**




Эх сурвалж: Монголбанкны сарын бюллетень

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 56.8 хувийг 3 том банк (ХААН, Голomt, ХХБ), 28.6 хувийг дунд хэмжээний 5 банк (МШ, УБ, Зоос, Анод болон Төрийн банк),

14.5 хувийг бусад жижиг банкууд эзэлж байгаа бөгөөд энэ харьцаа өнгөрсөн хугацаанд маш тогтвортой явж ирсэн байна. Мөн дээрх зургаас сүүлийн жилүүдэд хадгаламжийн зах зээл дээр төвлөрөл нэмэгдсэн ч хадгаламжийн хүү өсч байгааг харж болно. Эдийн засгийн хямралаас шалтгаалан манай эдийн засгаас хөрөнгө зугтах үзэгдэлтэй холбоотой юм. Мөн манай орны хадгаламжийн хүү бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр түвшинд байсаар байгаа нь хадгаламжийг даллаж байгааг илэрхийлнэ. Үүнийг гадаадад ажиллагсдын мөнгөн гуйвуулга банкинд байршиж буй хадгаламжийн хүү өндөр байгаагаас гадаадын иргэд дотоодын банкуудад байршуулж буйгаас харж болно. Ийнхүү банкны хадгаламж өсч, зах зээлд эзлэх хувь банкны нэр хүнд, харилцагчдын итгэл болон зар сурталчилгаанаас хамааран нэмэгдэх болсон нь цаашид банк хадгаламжийн хүүгээ бууруулах боломж байгааг нотолж байна. Нөгөө талаас тухайн банкны зах зээлд эзлэх хувь нэмэгдэхийн хэрээр эрсдэл даах чадвар нэмэгдэж байгаа нь харьцангуй бага хүүгээр хадгаламж татах бололцоог том банкуудад олгож байна. Тухайлбал, судалгаанаас үзэхэд 4 том банкны зах зээлд эзлэх хувь 2002-2008 оны хооронд 9 нэгж хувиар өссөн нь хадгаламжийн хүүг 1.0 нэгж хувиар буурахад нөлөөлсөн<sup>4</sup> байна. Түүнчлэн энэхүү үр дүн нь хөрөнгийн зах зээлийн хөгжил харьцангуй сул байгаа өнөө үед хадгаламжийн хүүний бууралт нь хадгаламжийн нийлүүлэлтийг бууруулах эрсдэл бага байхыг илтгэнэ. 2008 оны эхэн хүртэл том банкуудын хүүний зөрүү системийн дунджаас бага байсан бол 2008 оны 2 дугаар улирлаас 2009 эхний хагас хүртэл дунджаас дээгүүр болсон (зураг 3.4). Учир нь эдийн засгийн хямралаас шалтгаалан том 3 банк хадгаламжийн хүүгээ бууруулах бус харин хүүний зөрүүгээ нэмэгдүүлсэн байна. Тэдгээр банкууд хямралын үед эх үүсвэрийн дутагдалд ороогүй бөгөөд харин эх үүсвэрийн бус зардал нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

**Зураг 3.4. Банкны системийн болон 3 том банкны бодитоор төлөгдсөн зээл, хадгаламжийн хүүний зөрүү**



Эх сурвалж: Орлого, зарлагын тайлан

Төвлөрөл нь өрсөлдөөнийг үлэмж хумьж, шударга бус байдлыг бий болгож, магадгүй сөрөг ч үр дагавар бас авчирч болохыг дээрхээс харж болохоор

<sup>4</sup> Д.Ган-Очир (2009) “Арилжааны банкуудын зээл болон хадгаламжийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс” судалгааны ажлаас дэлгэрэнгүй харах боломжтой.

байна. Иймд банкны өргөжилтийг өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мөнгөний бодлогын хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхээргүй зах зээлийн зохистой төвлөрлийг бий болгох нь зүйтэй юм. Үүний зэрэгцээ банк томорсноор зах зээлд хэт монополь шинж чанартай оролцож, зах зээлийн өрсөлдөөнийг бууруулах эрсдэлтэй тул үүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг эргэн харж, сайжруулах шаардлагатай байдаг. Мөн зээл, хадгаламжийн зах зээлд 3 том банк ноёрхож, олигополь шинж чанартай үйл ажиллагаа явуулж байгаа ба жижиг банкууд хоорондоо нэгдэн, нийлж дээрх банкуудтай өрсөлдөхүйц том банк бий болсноор зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх зорилгоор хүүг бууруулах нь зүйтэй юм.

### **Банкны өргөжилт (Banking consolidation)-ийн мөнгөний бодлогын хэрэгжилтэд үзүүлэх нөлөө**

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн глобалчлал, хөрөнгө оруулалтын өсөлт болон технологийн дэвшлээс шалтгаалсан санхүүгийн байгууллагууд, түүн дотроо банкуудын нэгдэл олширч байна. Ялангуяа Азийн хямралын дараа Зүүн Азийн зарим орнууд, түүн дотроо Солонгос, Вьетнам зэрэг орнуудад санхүүгийн зах зээлд оролцогчдын өрсөлдөөнийг идэвхжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтворжуулах зорилгоор банкуудад бүтцийн өөрчлөлт хийн, үйл ажиллагааг нь өргөжүүлэх байдал маш тод ажиглагдсан. Санхүүгийн байгууллагууд нэгдэн, нийлж хүчирхэгжих нь мөнгөний бодлогын хэрэгжилтэд эерэг, сөрөг нөлөөтэй байдаг.

Мөнгөний бодлогын хүү, зээл болон банкны балансын сувгуудад голчлон нөлөөлдөг гэж үздэг (Хүснэгт 3.1). Тухайлбал, монополь шинж чанартай том банкууд бий болсноор улс орны санхүүгийн зах зээлийн байдал, макро эдийн засгийн орчноос үл хамааран хадгаламжийн хүүг бага, зээлийн хүүг өндөр тогтоох сонирхол ажиглагддаг. Жишээ нь, бодлогын хүүний аливаа өөрчлөлтөд том банкууд монополь ашгаа хадгалах зорилгоор хангалттай хариу үйлдэл үзүүлдэггүй гэсэн үг юм. Үүний зэрэгцээ санхүүгийн байгууллагууд томорсноор дотоод болон гадаад зах зээлийн хоорондох хамаарал нэмэгддэг бөгөөд энэ нь гадаад эдийн засгийн аливаа шокын дотоод эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлдэг.

Ингэснээр дотоодын зах зээл дэх тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, системийн эрсдэлийг өсгөн, мөнгөний бодлогын аливаа шийдвэрт санхүүгийн зах зээлийн үзүүлэх хариу үйлдлийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлдэг байна. Гэсэн хэдий ч том банкууд эрсдэлээ сайн удирддаг бөгөөд энэ нь аливаа сөрөг шокоос шалтгаалсан эрсдэлийг шингээх чадвар нь сайжирдаг сайн талтай.

**Хүснэгт 3.1. Санхүүгийн байгууллагын өргөжилтийн мөнгөний бодлогын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөлөл**

| Санхүүгийн зах зээлийн хөгжил                    | Санхүүгийн зах зээлд гарах үр дагавар                                         | Мөнгөний бодлогын дамжих сувгууд дээрх нөлөө                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Хүүний суваг дээрх нөлөө                                                                                                                                                                                             |
|--------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Санхүүгийн байгууллагуудын өргөжилт болон нэгдэл | Зах зээлд оролцогчдын тоог бууруулснаар төвлөрөл нэмэгдэж, өрсөлдөөн буурдаг. | Том болон шинээр нэгдсэн банкууд эх үүсвэр татах боломж нэмэгддэг учир банкны зээлийн сувгийн нөлөөг сулруулдаг. Мөн том банкууд зээлийн эсдлийг илүү сайн удирддаг бөгөөд зээлдэгчээс шаардагдах барьцаа хөрөнгө буурч, улмаар мөнгөний бодлогын балансын сувгийг нөлөөг сулруулдаг. Харин тухайн орон нутгийн жижиг банкыг гадны том банк өөртөө нэгтгэсэн тохиолдолд орон нутгийн зээлдэгчдийн талаарх мэдээлэл хомс байдгаас шалтгаалан барьцаа хөрөнгийг нэмэгдүүлдэг бөгөөд энэ тохиолдолд балансын сувгийн нөлөө сайжирдаг. | Зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх түвшинд банк томорсноор хүүний сувгийн нөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Харин зах зээл хэт төвлөрсөнөөр банк хоорондын захын хөрвөх чадвар буурч хүүний сувгийн нөлөөг сулруулдаг. |

**Санал, зөвлөмж**

Өнөөгийн банкны системийн хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд банкуудыг нэгтгэх, салбарын бүтцийн өөрчлөлт хийх асуудал үр ашигтай болж байна. Банкууд нэгдсэнээр **өргөжилтийн үр өгөөж ажиглагдан, улмаар зээл хадгаламжийн хүү буурах** боломжтой юм. Гэхдээ хэт төвлөрөл нь өрсөлдөөнийг үлэмж хумьж, шударга бус байдлыг бий болгодог сөрөг үр дагавартай. Иймд банкны бүтцийн өөрчлөлт болон нэгдлийг зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мөнгөний бодлогын хэрэгжилтэд аливаа сөрөг нөлөө үзүүлэхээргүй зах зээлийн зохистой төвлөрөл бий болгохоор хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүний зэрэгцээ банк томорсноор зах зээлд хэт монополь шинж чанартай оролцож, зах зээлийн өрсөлдөөнийг бууруулах эрсдэлтэй тул үүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг эргэн харж, сайжруулах шаардлагатай.

Мөн зах зээлийн төвлөрөл болон хэт өргөжилтөөс шалтгаалан системийн эрсдэл нэмэгдсэнээр банк дампуурахад хэт эрсдэлтэй байх асуудлыг **(too-big-to-fail)** бий болгодог тул **хяналт шалгалтыг давхар чангаруулах** шаардлагатай. Дээрх эрсдэлээс сэргийлэхийн зэрэгцээ банкны системийн бүтцийн өөрчлөлт, нэгдлийг

амжилттай хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Банкны өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.
- Нэг өмчлөлтэй банкуудыг нэгтгэх, нийлүүлэх байдлаар томсгох.
- Банкны ил тод байдлыг нэмэгдүүлэх (Сайн засаглалыг бий болгох).
- Нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх.
- Хадгаламж эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах үүднээс гадны урт хугацаатай хөрөнгө оруулалтыг татах.
- Төв банкны хяналт шалгалтыг сайжруулах.
- Боловсон хүчнийг бэхжүүлэх.
- Төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох.
- Банкны үр ашигтай үйл ажиллагаатай холбогдох зарим хууль, журмын хэрэгжилтийг сайжруулах (тухайлбал, банкны холбогдогч этгээдийн үүрэг хариуцлагыг нарийн тодорхойлох, түүнийг нарийн хуульчлах).

Зарим орнуудад иргэд банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх санал гомдлоо Төв банкны ерөнхийлөгчид цахим хэлбэрээр илгээдэг бөгөөд энэ туршлагыг өөрийн орондоо нэвтрүүлэх.

### **3.2 Банкны салбарт гадаадын банк нэвтэрснээр зээлийн хүүнд үзүүлэх нөлөө**

#### **Олон улсын туршлага**

Зээлийн хүүг бууруулахад дотоодын зээлийн зах зээл дээр гадаадын банкууд орж ирэх нь эергээр нөлөөлдөг гэдгийг олон эмпирик ажил нотолсон байна<sup>5</sup>. Ийм эерэг нөлөө байсаар байтал зарим хөгжиж буй орнууд гадаадын банкуудыг зах зээл рүүгээ оруулахаас эмээдэг нь банкны салбарыг либералчлахдаа бодлого боловсруулагчид банкны секторт гадаадын банкны орж ирэхэд бий болох эерэг, сөрөг үр дагаврыг харьцуулан шинжилдэгтэй холбоотой. Нэг талаас, гадаадын банкууд технологийн давуу талтай байдгаас зээлдэгчдийн сайныг нь шилж зээл олгож, дотоодын банкууд муу зээлтэй багцтай үлдэнэ гэж санаа зовдог. Нөгөө талаас, гадаадын банкуудын илүү сайн технологиос суралцах, дам нөлөөгөөр дамжин дотоодын банкны зах зээл сайжрах боломжтой. Мөн банкны салбарын өрсөлдөөн идэвхжсэнээр зээлийн хүү бууран дотоодын эдийн засагт эерэг нөлөөтэй.

Хөгжиж буй орнуудад гадаадын банк нь дотоодын банкнаас илүү ашиг олохоор (profitable) мөн үр ашигтай (efficient) байдаг. Иймд дотоодын зах зээлд гадаадын банкууд орж ирснээр зээлжих чадвартай пүүсийн зээл авах боломжийг нэмэгдүүлдэг. Тухайлбал Зүүн Европт гадаадын банкууд орж ирснээр өрсөлдөөнийг нэмэгдүүлж, жижиг дунд аж ахуйн нэгжүүд болон жижиглэнгийн

<sup>5</sup> Тухайлбал Claeys and Hainz (2006) нь Зүүн Европын улсуудын хувьд нийт зээлд гадаадын банкуудын хувь их байс тусам дундаж зээлийн хүү буурдагыг эмперик судалгаагаар харуулсан байна.

худалдааны зах зээлд олгох зээлийн хэмжээ нэмэгдсэн зэргээр зээлийн технологийг сайжруулсан (De Haas and Naaborg, 2005).

Бодлого боловсруулагчид банкны салбарын либералчлалыг хийхдээ зөвхөн гадаадын банк орж ирэх эсэх талаар шийд гаргаад зогсохгүй, түүнчлэн гадаадын банкны дотоодын зах зээлд нэвтрэх хэлбэрийн талаар шийдэх хэрэгтэй болдог. Гадаадын банк нь шинээр банк байгуулан хөрөнгө оруулалт хийх замаар эсвэл дотоодын банкийг худалдан авах замаар дотоодын банкны салбарт нэвтрэх боломжтой. Гэхдээ гадаадын шинээр байгуулагдсан банк нь дотоодын банкийг худалдан авах замаар байгуулагдсан гадаадын банктai харьцуулахад илүү ашиг олж, үр ашигтай байдаг гэдгийг судалгаагаар харуулсан (Martinez Peria and Mody, 2004, Majnoni et al., 2003).

Дотоодын банк нь харилцагчдын талаар хувийн мэдээлэлтэй байдгаараа давуу талтай бол гадаадын банкууд нь илүү сайн үнэлгээ хийх чадвартай байдаг байна. Нэгэнт зах зээлд гадаадын банк орсны дараа хуучин болон шинэ пүүсүүдийн зээлжих чадварын талаарх мэдээлэл дотоод, гадаадын банкуудад жигд тархдаг. Өнгөрсөн хугацаанд нэгэнт харилцаа тогтоочихсон байсан пүүсүүдийнхээ мэдээлэлд дотоодын банк хандах боломжтой байдаг нь дотоодын банкинд эдгээр хуучин пүүсүүдийнхээ зээлжих чадварын талаарх мэдээллийн давуу талыг олгодог. Хөгжиж буй орны хувьд, гадаадын банкууд илүү өндөр технологитой байдгаас дотоодын банкуудаас сайн үнэлгээ хийх чадвартай байдаг. Иймд гадаадын банк нь зээл хүсч буй шинэ пүүсийн талаар зээлийн үнэлгээнийхээ дагуу илүү сайн мэдээллийг авдаг. Энэхүү шинэ зээлдэгчийн мэдээллийн давуу тал нь шинэ зээлдэгчдэд гадаадын банк дотоодын банкнаас бага зээлийн хүү санал болгох боломжийг олгодог. Мөн түүнчлэн шинэ зээлдэгчдийн үнэлгээ нь илүү нарийн хийгддэгээс гадаадын банкийг эхний удаа зээл авч байгаа пүүсүүдээс авах шимтгэлээ бууруулах боломжийг бий болгодог. Үүний үр дүнд гадаадын банк орж ирснээр тухайн оронд шинээр олгогдож буй зээлийн дундаж хүү буурдаг.

Гэхдээ энэхүү эерэг үр дүн нь гадаадын банкны зах зээлд нэвтэрсэн хэлбэрээс шалтгаална. Учир нь дотоодын банкийг худалдан авсан гадаадын банк нь харилцагч пүүсүүдийнхээ чанарын талаарх мэдээллийг багтаасан зээлийн багцыг бас шилжүүлэн авдгаас мэдээллийн давуу талтай болж, зээл гаргах өрсөлдөөнд хүүгээ бууруулах сонирхол гадаадын шинээр байгуулагдсан банктai харьцуулахад бага байдаг. Түүнчлэн Claeys and Hainz (2006) эмпирик судалгаагаар гадаадын шинэ банкуудын зах зээлд эзлэх хувь гадаадын худалдаж авсан банкуудынхаас их байх тусам дотоодын банкны зээлийн дундаж хүү илүү ихээр буурч байгааг харуулсан байна.

## **Монголын банкны салбар дахь гадаадын банк**

Одоогийн байдлаар Монголын банкны салбарт гадаадын шинээр байгуулагдсан банк байхгүй бөгөөд дотоодын банкныг худалдаж авсан гадаадын 100 хувийн эзэмшилтэй 2 банк байна. Мөн нийт эзэмшлийнх нь 50-иас дээш хувийг гадаадын харьяат эзэмшиж буй 3 банк байна. Гадаадын эзэмшилтэй хоёр банкны олгосон зээлийн хэмжээ нь маш бага, мөн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулаагүй байна. Харин гадаадын эзэмшил нь 60 хувиас дээш 2 банкны хувьд зээлийн үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж байгаа бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан зээл болон хэрэглээний зээлийг түлхүү олгож байна.

## **Цаашид авах арга хэмжээ**

Банкны салбарт гадаадын банк шинээр үйл ажиллагаа явуулах нь гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын банкныг худалдан авахаас илүүгээр өрсөлдөөнийг нэмэгдүүлж, улмаар зээлийн хүүний бууралтад хурдан хугацаанд эергээр нөлөөлөх боломжтойг өмнө дурдсан. Иймд зээлийн хүүг бууруулахад олон улсын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын нэр хүнд бүхий банкны салбарыг дотоодын зах зээлд оруулахыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн ажлыг Монголбанкнаас зохион байгуулж ажиллах шаардлагатай байна. Ингэхдээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Гадаадын банк дотоодоос татан төвлөрүүлсэн хөрөнгийг эрсдэлд оруулахгүй байхаар хууль эрх зүйн актад тусгах,
- Зах зээлд хэт ашиг хонжоо хайсан мөнгө орж ирэхээс сэргийлсэн хязгаарлалтуудыг хууль эрх зүйн актуудад тусгах,
- Гадаадын банкны орж ирэх үйл ажиллагаа банкны салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх.

## **3.3 Банк хоорондын захын хөгжил**


Санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн улс орнуудад мөнгөний зах, банк хоорондын зах, хөрөнгийн зах нь тус тусдаа бие даан хөгжсөн байдаг. Мөнгөний зах дээр ЗГ, том корпораци, санхүүгийн байгууллагуудын 1 жил хүртэл хугацаатай гаргасан, маш бага эрсдэлтэй, хөрвөх чадвар өндөртэй харьцангуй өгөөж багатай богино хугацаат өрийн бичиг арилжаалагддаг. Харин манай улсын хувьд зөвхөн банк хоорондын зах л ажиллаж байна.

## **Банк хоорондын захын хөгжлийн сул дорой байдал зээлийн хүүд нөлөөлөх нь**

Банк хоорондын захаас татсан банкуудын богино хугацаат эх үүсвэрийн хэмжээ 2006 оноос 80 гаруй тэрбум төгрөгөөр өсч, 2008 оны эхээр 100 тэрбум төгрөгт буюу нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 3 хувьд хүрсэн. 2009 онд

банк хоорондын захаас татсан эх үүсвэр 85-100 тэрбум төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 2-2.5 хувьд хэлбэлзэж байгаа нь банк хоорондын зах идэвхжихгүй байгааг харуулж байна.

**Зураг 3.5. Банк хоорондын зах, мөнгөний захын хэрэгслээр татсан эх үүсвэрийн нийт пассивт эзлэх хувь**



Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын зах (мөнгөний зах)-ын хөгжил нь Төв банкны мөнгөний бодлогын шилжих механизмын хүүний сувгийн нөлөөлөх хүчийг нэмэгдүүлдэг. Санхүүгийн зах зээл, мөнгөний зах өндөр хөгжсөн орнуудад иргэд, компани, банк, хөрөнгө оруулагчид зэрэг эдийн засгийн агентууд мөнгөний зах дээрээс богино хугацааны эх үүсвэр татаж, мөнгөн хөрөнгийн урсгалын зөрүүгээ нөхөх нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэх түгээмэл хэрэгсэл юм. Харин мөнгөн хөрөнгийн илүүдэл нөөцтэй хөрөнгө оруулагчид уг зах дээрээс богино хугацаат өрийн бичиг худалдаж аван хөрөнгийн портфейлээ өөрчилж, хөрөнгийн өгөөжөө нэмэгдүүлдэг. Банк хоорондын зах (мөнгөний зах) хөгжиж эдийн засгийн агентууд ийм байдлаар ажиллах нь Төв банкны мөнгөний бодлогын чиглэл (stance) өөрчлөгдөх үеийн орлогын болон баялгийн нөлөөг нэмэгдүүлж, мөнгөний бодлогын нөлөөлөх чадварыг сайжруулдаг.

Манай улсын банк хоорондын захын<sup>6</sup> хөгжлийн сул дорой байдал нь дараах байдлаар зээлийн хүүд нөлөөлж байна. Үүнд:

*Активын өгөөжийн бага түвшин.* Банк хоорондын зах дээрээс богино хугацаанд эх үүсвэр олох санхүүгийн хэрэгслүүд түгээмэл биш хэрэглэгддэг, илүүдэл нөөцөө байршуулах хөрвөх чадвар өндөртэй бонд, үнэт цаас гэх мэт санхүүгийн активууд байхгүй байгаа нь банкууд их хэмжээний илүүдэл нөөцийг бэлэн мөнгө хэлбэрээр барьж байна. Энэ нь банкуудын алдагдсан боломжийн зардлыг нэмэгдүүлснээр өгөөж өгдөг үндсэн актив болох зээлийн хүүг өндөр түвшинд тогтох нөхцөлийг бүрдүүлж байна.

<sup>6</sup> Банк хоорондын зах гэдэгт төгрөгийн болон гадаад валютын банк хоорондын захыг бүхэлд нь ойлгоно.

*Эрсдэлийн үнэ өндөр (risk premium).* Банк хоорондын зах дээр эрсдэлийг удирдах forward, futures, option гэм мэт эрсдэлийн удирдлагын гэрээнүүд хийгдэж, ашиглагдахгүй байгаа нь зээлийн хүүд шингэж буй эрсдэлийн үнийг (risk premium) нэмэгдүүлж байна.

### **Банк хоорондын захын хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлс**

Дэлхий нийтэд банк хоорондын зах (мөнгөний зах) дээрээс банк, санхүүгийн болон бусад томоохон байгууллагууд нь хамгийн бага зардалтайгаар, хамгийн түргэн хугацаанд богино хугацааны эх үүсвэр олдог. Манай улсын банк хоорондын захын хөгжил сул дорой байгаа нь дараах хүчин зүйлстэй холбоотой байна. Тухайлбал:

*Мөнгөний зах дээр ашиглагддаг түгээмэл хэрэгслүүд манай банк хоорондын зах дээр нэвтрээгүй байна.* Санхүүгийн систем өндөр үр ашигтай ажилладаг хөгжингүй орнуудад ЗГ-ын богино хугацаат үнэт цаас, Хадгаламжийн сертификат, Commercial paper, Banker's acceptance, Eurodollars, репо зэрэг хэрэгслүүд мөнгөний зах дээр хамгийн түгээмэл ашиглагддаг. Эрсдэл багатай, богино хугацаатай, хөрвөх чадвар өндөртэй эдгээр хэрэгслүүд нь захад оролцогчдын активын өгөөжийг нэмэгдүүлээд зогсохгүй богино хугацаанд, зардал багатайгаар богино хугацааны эх үүсвэр татах боломжийг бүрдүүлдэг. Манай улсын хувьд эдгээр хэрэгслүүдээс нэг нь ч банк хоорондын зах дээр нэвтрүүлээгүй бөгөөд ЗГ-ын богино хугацаат үнэт цаасны үүргийг ТБҮЦ гүйцэтгэж байна. Арилжааны 16 банкнаас зөвхөн ХААН, Капитал банкууд хадгаламжийн сертификат гаргасан ч түгээмэл ашиглагдах санхүүгийн бүтээгдэхүүн болж чадаагүй.

*Мөнгөний захад оролцогчид хязгаарлагдмал.* Өнөөгийн байдлаар манай мөнгөний захыг зөвхөн банкууд оролцдог банк хоорондын зах тодорхойлж байгаа тул хөрөнгө оруулалтын сангууд, том компаниуд, бусад санхүүгийн байгууллагууд богино хугацаат өрийн бичиг гаргаж арилжаалах замаар богино хугацаат эх үүсвэр татах, хөрөнгө оруулалт хийх боломжгүй байгаа нь цаашдын мөнгөний захын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

*Мэдлэг, туршлага бага.* Манай улсын банк, санхүүгийн байгууллагууд, Засгийн газар, томоохон аж ахуйн нэгжүүдэд мөнгөний захад хөрөнгө оруулалт хийх, захаас богино хугацааны эх үүсвэр татах туршлага, мэдлэг хомс байна.

*Мөнгөний захын хэрэгслүүд нэвтэрсэн хэдий ч тэдгээр хэрэгслүүдийг арилжаалах зах зээлийн дэд бүтэц байхгүй байна.* Тухайлбал, зарим банкуудын хадгаламжийн сертификатыг эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж бэлэн мөнгө хэрэгтэй болсон үед хэнд, яаж зарах вэ? гэдэг нь тодорхой бус байгаа тул уг санхүүгийн бүтээгдэхүүний хөрвөх чадварт муугаар нөлөөлж байна.

*Хэлцэл хийхэд ашиглагдах жишиг (benchmark) хүү байхгүй.* Манай улсад ЗГ-ын үнэт цаасыг зөвхөн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор гаргаж байгаа нь өрийн зах зээл (debt market) хөгжих, улмаар банк хоорондын захын (мөнгөний захын) төгрөгийн өгөөжийн муруй бий болох нөхцөл бүрдэхгүй байна. Энэ нь форвард зах хөгжих боломжийг хязгаарлаж байна.

*Барьцаа хөрөнгийн хомсдол.* Банк хоорондын зах дээр харьцангуй урт хугацаатай (3 сараас 1 жил хүртэл) хэлцэл хийхэд барьцаа болж ашиглагдах ЗГ-ын үнэт цаас байхгүй байна. Банк хоорондын зах дээр ашиглагдах харьцангуй урт хугацаат үнэт цаас ЗГ гаргахгүй бол 4 долоо хоног (1 сар), 28 долоо хоног (6 сар), 56 долоо хоног (1 жил)-ийн хугацаатай ТБҮЦ гаргаж арилжаалах шаардлагатай байна.

*Харилцагчийн эрсдэл (counterparty risk) өндөр.* Мөнгөний захыг банк хоорондын захаар тодорхойлж байгаа манай улсын хувьд харилцагчийн эрсдэл нь банкуудын эрсдэлээр тодорхойлогдоно. Томоохон банкуудын хувьд хэлцэл хийх боломжтой банкуудын жагсаалтыг гаргасан байдаг нь банк хоорондын зах дээр харилцагчийн эрсдэл ямар өндөр байдгийг харуулж байна. Захад оролцогчдын хувьд харилцагч банкны талаарх үнэн зөв, бодит мэдээлэл байхгүй байгаа нь хэлцлийн үнийг өсгөх, судлах шаардлагын үүднээс хэлцлийн хурдан шуурхай байдлыг алдагдуулж, үр ашгийг бууруулах зэргээр захын хөгжлийг удаашруулж байна.

### **Банк хоорондын захыг хөгжүүлэхэд хийгдэх шаардлагатай ажил**

Мөнгөний зах болон банк хоорондын захыг хөгжүүлэхийн тулд дараах зүйлсийг эхний ээлжид хийх шаардлагатай байна. Үүнд:

- Арилжаа хийх, мэдээлэл авах, түгээх програм хангамжийг боловсронгуй болгох.
- Банкууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдээ хэрхэн хангаж байгаа талаар нийтэд мэдээлдэг болох замаар банк хоорондын зах дээрх харилцагчийн эрсдэлийг бууруулах,
- Банк хоорондын зах дээр хүүний болон валютын форвард, своп хэрэгслүүд нэвтрүүлэхэд шаардагдах жишиг хүү болох өгөөжийн муруйг бий болгох. Үүний тулд ЗГ-аас урт болон богино хугацаат бондыг гаргах,
- Шаардлагатай бол банк хоорондын захын арилжааны тайланг боловсронгуй болгож, мэдээллийн хүртээмжийг сайжруулах,
- Банкны сургалтын төвөөс санхүүгийн зах зээлийн хэрэгслүүдийн талаар банкууд болон аж ахуйн нэгжүүдэд сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг нэн тэргүүнд хийх шаардлагатай байна.

## 4. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ

Зээлийн хүү өндөр тогтоход нөлөөлж буй банкны салбарын хөгжил болон байгууллагын засаглалтай холбоотой хүчин зүйлсийг энэ хэсэгт авч үзлээ. Үүнд: хадгаламжийн зах зээлийн өрсөлдөөн, хууль эрх зүйн эрсдэл, шударга бус зээлжүүлэлт болон банкны байгууллагын зохистой удирдлагыг бэхжүүлэх нь зээлийн хүүг бууруулахад хэрхэн нөлөөлөхийг энд танилцуулав.

### 4.1 Хадгаламжийн захын өрсөлдөөн

Зах зээлийн эдийн засагт шилжсэн эхэн үед Монголд хадгаламж болоод зээлийн хүү бусад ижил шинж чанар бүхий улс орнуудаас хэт өндөр байв. Ихэнх шилжилтийн эдийн засагтай орнуудыг харахад 1990-д оны хямралын дараа инфляцийн түвшнээ бууруулснаар өндөр хүүний түвшин дагаж буурсан боловч харамсалтай нь Монголд энэ зүй тогтол ажиглагдсангүй.

Инфляци нэг оронтой тоо руу орж ирсэн ч хүү дорвитой буурсангүй. Учир нь банкууд 2006-2007 оны үед хэт өндөр хүү амлаж, огцом олширч эхэлсэн хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-той эх үүсвэрийн төлөө өрсөлдөж өндөр хүү амлаж эхэлсэн байна. Гэтэл амласан хүү нь хэт хийсвэр байснаас олон ХЗХоршоод дампуурсан ч зарим сул банк хэт өндөр хүү амласан хэвээр байсан нь олон улсын санхүүгийн зах зээлд гарцгүй, дотоодын иргэд, аж ахуйн нэгжээс хадгаламж, харилцах татах нь цорын ганц эх үүсвэр болсон бусад банкуудын хувьд хүүгээрээ өрсөлдөхөөс өөр аргагүйд хүргэсэн байна. Тиймээс одоо ч хүүний түвшин өндөр хэвээр байсаар байна.

2009 оны 12 дугаар сарын байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 12.9 хувь байгаа бол зээлийн хүү 20.8 хувьтай байна. Нөгөө талаас, инфляци тогтвортой буурч, сүүлийн хэдэн сард дефляци бий болсонтой холбоотойгоор бодит хүүний түвшин өссөн нь төгрөгийн хадгаламжийг өсгөсөөр байна. 2009 оны эцсийн байдлаар нийт хадгаламжийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар өссөн байна. Тэгвэл одоо хүүний түвшин яагаад буурахгүй байна вэ?

Банкуудын хүүнд нөлөөлөгч томоохон институциональ хүчин зүйлсийн нэг бол өрсөлдөөн. Банкуудын татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн дийлэнхийг хадгаламж эзэлж байгаа нь манайх шиг жижиг зах зээлд олон тооны банк эх үүсвэр татахын тулд шударга бус өрсөлдөөн гаргахад хүргэдэг. Энэ нь хадгаламжийн хүү, улмаар зээлийн хүү буурахгүй байх шалтгаан болж байна.

Нэгэнт зээл, хадгаламж нь санхүүгийн бүтээгдэхүүн болохын хувьд түүнд тохирсон үнэ гэж байх ёстой. Энэхүү үнэ нь зах зээлийн зарчмаар тогтох учиртай боловч зах зээлийн шинж чанар, өрсөлдөөн зэргээс болоод давамгайлагч том банкууд хоорондоо хуйвалдах, хадгаламжийн хэмжээгээр том боловч,

эзэмшигчдийн тоогоороо цөөхөн харилцагчдыг банкууд өөртөө татахын тулд зах зээлийн бус өндөр хүү амлах, жижиг банкууд хурдан томрохын тулд хүүгээ өндрөөр тогтоож урт хугацаанд эрсдэлтэй үйлдэл хийж байгаа нь хүү буурахгүй байх томоохон шалтгаан болж байна.

Монголбанкнаас явуулсан хадгаламжийн хүүний судалгаагаар судалгаанд хамрагдсан 12 банкны 78.6 хувь нь том хадгаламж эзэмшигчдээ бусад банкинд алдахгүйн тулд харьцангуй өндөр хүү амлаж байсан гэж хариулсан байна. Энэ нь хадгаламжийн хүүг хөөрөгдөж, улмаар уг зардлаа нөхөхийн тулд зээлийн хүүг өндрөөр тогтоох шалтгаан болж байна.

2009 оны эцсийн байдлаар банкуудын зах зээлийн төвлөрлийг тооцож үзэхэд том 4 банкны нийт зах зээл дэх төвлөрлийн харьцаа  $CR_4=73.3$ , хадгаламжийн зах зээл дэх төвлөрлийн харьцаа  $CR_4=82.0$  байгаа нь хадгаламж нэлээд төвлөрч байгааг харуулж байна. Мөн том 8 банкны хувьд нийт зах зээл дэх төвлөрлийн харьцаа  $CR_8=89.0$ , хадгаламжийн зах зээл дэх төвлөрлийн харьцаа  $CR_8=95.9$  байна.


Зах зээлийн төвлөрөл бий болох нь нэг талаас эрсдэлийг бууруулдаг. Санхүүгийн орчин тогтворгүй үед банкинд итгэх итгэл сул байдаг учир харилцагчид банкинд богино хугацаагаар мөнгөө хадгалуулдаг. Энэ нь хадгаламжийн дундаж хугацаа бага байгаагийн гол шалтгаан бөгөөд банкууд урт хугацаатай эх үүсвэр татахын тулд өндөр хүү амлаж, урт хугацаанд эрсдэлтэй үйлдэл хийдэг. Энэ нь эргээд банкуудыг хэрхэн сөхрүүлдэг болохыг бид Анод, Зоос банкуудын жишээнээс харж болно. Чухамхүү ийм үйлдэл л хүүний түвшин буурахгүй байгаагийн шалтгаан болдог байна. Харин том эрсдэл багатай, хангалттай хэмжээний хадгаламж төвлөрүүлсэн банк зах зээлийн бус өндөр хүү амлах замаар харилцагчдыг татах шаардлагагүй байдаг. Өөрөөр хэлбэл, өргөжилтийн үр өгөөж нь зардлыг багасгаснаар хүүг бууруулах үндэс болно гэсэн үг.

Банкуудын хэмжээ томрохын хэрээр тэдний өрсөлдөөн илүү хуйвалдааны шинжтэй (олигополь зах зээл) болж байна гэсэн хардлага зарим хүмүүст байдаг. Дээрх мэдээлэлд тулгуурлан банкуудын өрсөлдөөний хэлбэр ямар байгааг Herfindahl-Hirschman index-ээр тооцож үзэхэд  $HHI=1620.1$  буюу манай банкны систем монополист өрсөлдөөнт зах зээл<sup>7</sup>-ийн шинжийг агуулж байна (Зураг 4.1). Ийм төрлийн зах зээлийн гол шинж нь үнийн өрсөлдөөн буюу бүтээгдэхүүний ялгаварлал байдаг. Тиймээс банкууд зээл болон хадгаламжийн бүтээгдэхүүний ялгаварлал дээр өрсөлддөг гэсэн үг.

Энэ нь хадгаламжийн шинэ төрлийн бүтээгдэхүүнийг бий болгож, иргэд, аж ахуйн нэгжүүдэд хэрэгцээнд нь тохирсон хадгаламжийн бүтээгдэхүүнийг бий болгоход эерэг нөлөөтэй байдаг.

<sup>7</sup> Америкийн шудрага бус өрсөлдөөнтэй тэмцэх газраас гаргасан ангилалаар

**Зураг 4.1: Herfindahl-Hirschman index-ээр тооцсон нийт зах зээлийн болон хадгаламжийн зах зээлийн өрсөлдөөн**



Эх сурвалж: Монголбанк

Гэвч төвлөрөл дандаа сайн байдаггүй гэдгийг санах хэрэгтэй. Гагцхүү хяналт шалгалт, хууль эрх зүйн тодорхой орчин, нийгмийн ухамсар, итгэлцэл үүнийг зөв тийш нь чиглүүлэх учиртай.

Түүнчлэн инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах замаар зах зээлийн эрсдэлийг бууруулах, банкуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь хадгаламж, зээлийн хүүг бууруулахад нэлээд чухал нөлөөтэй байна.

Банкны системийн хадгаламжийн дүн нэмэгдсэн, нөгөө талаас хадгаламжийн зах зээлийн төвлөрөл өсч байгаа нь иргэдийн зарим банкуудад итгэх итгэл нэмэгдсэнийг харуулж байна. Энэ нь олон нийтийн зүгээс эрсдэлд тулгуурлан банкуудаа сонгодог болсны маш чухал дохио юм. Энэ нь хүү цаашид буурах таатай орчинг бүрдүүлж байна. Тиймээс цаашид ч өндөр хүү, өндөр эрсдэлийг дагуулдаг гэдгийг олон нийтэд байнга таниулж байх нь чухал байна. Мөн олон банкууд зөвхөн дотоодоос хадгаламж татахаас өөр эх үүсвэргүй байгаа нь тэдний хүү өндөр байхад нөлөөлж байгааг дээр дурдсан судалгааны дүн харуулсан. Хэрвээ гадны хямд эх үүсвэрийг банкууд жигд татдаг болвол хүү буурна гэдэгтэй ихэнх банкууд санал нийлж байна.

#### Авах арга, хэмжээ

- Банкуудын талаарх үнэн бодит мэдээллийг нийтэд мэдээлдэг болж, хадгаламж эзэмшигчид эрсдэлгүй өгөөж өндөртэй банкныг сонгох боломжийг бүрдүүлэх,
- Банкны бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, банкуудын зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,

- Хэдэн банк манай улсын банкны салбарт үйл ажиллагаа явуулах нь салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх талаар судалгаа хийх зэрэг ажлуудыг нэн тэргүүнд хийх шаардлагатай байна.

## 4.2 Хууль эрх зүйн эрсдэл

Банкны эрсдэлийн зардлын нэг хэсэг нь эрх зүйн эрсдэлтэй холбоотой зардал юм. Эрх зүйн эрсдэл нь хууль, Монголбанкны журам, бусад байгууллагуудаас тавигдах эрх зүйн шаардлагын дагуу нэмэлт зардал гарах, эсвэл төлөвлөсөн хугацаа хойшилсноос олох орлогоо алдах зэргээр илэрнэ. Уг зардлыг урьдчилан төлөвлөх боломжгүй тул энэ хэмжээгээр тодорхой бус байдал нэмэгдэж, банкууд энэхүү зардлыг зээлийн хүүндээ шингээн нэмэх замаар уг зардлыг нөхдөг. Тухайлбал, банк төлөвлөж байсан орлогоо алдахад хүрвэл зээлийн хүүгийн орлогоо нэмэгдүүлэх шаардлага тулгарна. Тийм учраас эрх зүйн орчны тодорхой бус байдал, хууль, журмын зөрчилдсөн зохицуулалт нь санхүүгийн зуучлалын өртгийг нэмэгдүүлж байдаг. Үүнд зээлдэгчийн эрхийг хэт хамгаалсан болон зээл олгогчид давуу эрх эдлүүлсэн зохицуулалт аль аль нь хамаарна.

УИХ-аас 2009 онд “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”, Монголбанкнаас 2008 онд “Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан орон сууцны зээлийн үйл ажиллагааны журам” зэргийг батлан гаргасан нь зээлийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чухал алхам болсон билээ. Дээрх хуулийн дагуу үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээр хангуулахдаа шүүхийн бус журмыг хэрэглэх болсон нь хугацаа хэмнэсэн чухал арга хэмжээ болсон. Харин шүүхийн журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагаа ихээхэн хугацаа зарсан, зардал ихтэй ажил байсаар байна.

Банкны хувьд хууль тогтоомж, журам, заавар, Засгийн газрын байгууллагуудтай холбоотой хүндрэл бэрхшээлүүд үүсч байгаа нь банкны эрсдэлийг нэмэгдүүлж, энэхүү эрсдэлийг нөхөх үүднээс банк бүтээгдэхүүнээ өндөр үнэлэх нөхцөл байдлыг бий болгох талтай юм. Тийм учраас Хууль зүйн яам, Монголбанк, банкууд, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх, Цагдаагийн байгууллагууд хоорондын үйл ажиллагаагаа уялдуулан, хууль эрх зүйн зохистой орчинг бүрдүүлэх, хууль, журмын уялдаа, тэдгээрийн хэрэгжилтийг хангах тал дээр хамтран ажиллах шаардлагатай юм.

Банкны хувьд зээлийн чанарт гол анхаарлаа хандуулж, зөвхөн барьцаа хөрөнгийн боломжоор зээлдэгчийг үнэлэх бус тухайн зээлдэгчийн хэрэгжүүлэх гэж буй төслийн үр ашиг болон зээлдэгчийн зээлжих чадварыг зөв тодорхойлох нь чухал юм. Ингэхийн тулд үнэн зөв, бодитой мэдээллээр хангагдах ёстой. Хамгийн чухал нь зээлдэгчийн санхүүгийн тайлан мэдээний үнэн зөв, бодитой байдал бөгөөд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлага хангасан,

аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан мэдээнд үндэслэн шийдвэр гаргах явдал юм.

### **Шүүхийн журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахад шаардагдах хугацаа**

Үүргийн гүйцэтгэл хангуулах талаар шүүхийн шийдвэр гарснаас хойш уг шийдвэрийг гүйцэтгэх хугацааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, журамд тодорхой заагаагүй байдаг бөгөөд энэ үйл ажиллагаа дунджаар 18 сар үргэлжилдэг байна. Үүнд:

- Зээлийн хугацаа дууссан өдрөөс зээлдэгч төлөлт хийхийг хүлээж 1-6 сар,
- Шүүхэд өгөх материал бүрдүүлэх, шүүх хүлээж авах, иргэний хэрэг үүсгэхэд 1 сар,
- Хариуцагч хаягандаа байхгүй бол хугацаа хойшлох,
- Шүүх хянаж, шийдвэрлэхэд 2-6 сар (Үндсэн хугацаа 60 хоног, сунгахад 30 хоног, шүүгч амарсан, солигдсон шалтгаанаар 30 хоног, өмгөөлөгч авах, өмгөөлөгчид ажил гарах, гачигдал гарах шалтгаанаар 60 хоног хүртэл гэх мэт)
- Давж заалдах, хяналтын шатны шүүхээр дамжвал 2-4 сар хүртэл
- Шүүхийн шийдвэр гарсны дараа шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа эхлэх шийдвэр гаргал 1-3 сар (Шийдвэр бичгээр гарах 7 хоног, давж заалдах, хяналтын гомдол гаргах хугацаа 30 хоног, гүйцэтгэх хуудас бичүүлэх, албадан гүйцэтгэх захирамж гаргуулах 7-30 хоног, шийдвэр гүйцэтгэл хүлээн авах, гүйцэтгэгчид хуваарилах, гэрээнүүд хийх, зардал урьдчилан шилжүүлэх, гүйцэтгэх ажиллагаа эхлэх 20-40 хоног)
- Шийдвэр гүйцэтгэл ажиллагаа явуулах, албадан худалдах, зээлийн өрийг хаах 3-10 сар

(Мэдэгдэл өгөх, хөрөнгийг битүүмжлэх, хураах, үзлэг нэгжлэг хийх 2-4 сар, албадан худалдах шийдвэр гарах 1-2 сар, албадан худалдаа эхлэх, дуусах 2-4 сар, шинжээч томилох, зээлдэгч үнийн дүнг зөвшөөрөхгүй байвал хугацаа 3-5 сар, ажиллагааг түдгэлзүүлбэл 1 сараас дээш хэчнээн ч хугацаа өнгөрөх боломжтой, мөн зээлдэгч сураггүй алга болвол эрэн сурвалжилж олох хүртэл хүлээгдэнэ).

### **Шүүхийн журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахад гарах зардал**

Шүүхийн журмаар үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээр хангуулахад банкнаас дунджаар 15-50 хувийн зардал гардаг байна. Үүнийг задлан үзүүлбэл:

- Шүүхэд улсын тэмдэгтийн хураамж дунджаар 0.5-4 хувь
- Өмгөөлөгч, гэрээт ажилтны зардал 3-5 хувь
- Нотариатын зардал 1 хувь хүртэл
- Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал 5-10 хувь

- Гүйцэтгэх ажиллагааны зардал 2 хувь хүртэл
- Бусад зардал (унаа, утас гэх мэт) 5 хувь хүртэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой дээрх хүндрэлээс гадна банкууд болон зээлдэгчид үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой дараах бэрхшээлтэй тулгардаг байна. Үүнд:

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэхдээ зөвхөн худалдах-худалдан авах болон бэлэглэлийн гэрээг хүлээн зөвшөөрдөг бөгөөд банк хөрөнгийг өөрийн нэр дээр шилжүүлэх болон буцаан шилжүүлэхэд хүндрэл гардаг.
- Үл хөдлөх хөрөнгийн барьцааг бүртгүүлэхэд барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүнгээс хувьчлан бүртгэлийн шимтгэл авдаг нь хэт өндөр байдаг. Ялангуяа, их дүнтэй зээл авч байгаа, олон барьцаатай, барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүн нь их тохиолдолд зээлдэгч хэт өндөр шимтгэл төлдөг.

Дээрх эрсдэлээс гадна зээлдэгч байхгүй тохиолдолд барьцааны үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж зээлийн өрийг төлүүлэх боломжгүй байдгаас зээлдэгчид хаягаа өөрчлөн сураггүй алга болох, гадаадад удаан хугацаагаар явах зэргээр зээл төлөлтийг хойшлуулан банкинд эрсдэлд учруулдаг. Банкны хувьд эрэн сурвалжлах ажиллагаа хийх журмыг хуульчлаагүй тул цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулдаг нь үр дүн багатай байдаг байна.

#### **4.3 Шударга бус зээлжүүлэлт**

Шударга бус зээлжүүлэлт нь юуны түрүүнд банк санхүүгийн талаар мэдлэг боловсрол нимгэн, зээлийн түүхэндээ сэвтэй, өрөнд унасан, энгийн нөхцөлд зээлд хамрагдах ямар ч боломжгүй тийм хэрэглэгчид рүү чиглэгдэж байдаг бөгөөд зээлийн хүү нь хавьгүй өндөр байдаг байна. Банкны удирдлага энэхүү өндөр хүүгээ зөвтгөхдөө бүрдүүлэх материал цөөн, орлогын эх үүсвэрийг нотлох баримт тэр болгон байдаггүй тул эрсдэлээ бодолцон бодит хүүн дээр эрсдэлийн урамшууллыг нэмэхээс өөр аргагүй хэмээн тайлбар хийдэг байна. Шударга бус зээлжүүлэлтийг албан ёсоор тодорхойлсон хуулийн тодорхойлолт байдаггүй бөгөөд ихэвчлэн ипотекийн зээл олгох явцад үүсдэг ба зээлдүүлэгч нь зээлдэгчийг хохироосон, шударга бус зээлийн нөхцөлийг зээлдэгчид тулган, ятган сэнхрүүлэх замаар өндөр хүү, шимтгэлтэй зээлийг олгодог байна. Мөн бэлэн мөнгөний урьдчилгаа зээл, зээлийн картын зээл, овердрафт болон бусад хэрэглэгчийн зээлүүд нь үндэслэлгүй өндөр хүүтэй тохиолдолд шударга бус зээлжүүлэлтэд хамаардаг. Шударга бус зээлжүүлэлт нь хүн амын бүх давхаргыг хамардаг боловч ихэвчлэн боловсрол нимгэн, хүн амын цөөнх болон өндөр настан зэрэг бүлгүүд энэхүү луйврын зээлжүүлэлтийн золиос болдог байна.

АНУ-ын ипотекийн салбарын хямрал нь дэлхий нийтийн анхаарлыг шударга бус зээлжүүлэлтийн асуудалд дахин хандуулахад хүргэж байна. АНУ-д орлого багатай, зээлийн түүх сайнгүй иргэдийг ипотекийн болон хэрэглээний дахин санхүүжилтийн “субпрайм” зээлд хамруулдаг бүхэл бүтэн банкны систем үүсэн хөгжсөн байна. Ингэснээр тухайлбал, ипотекийн дахин санхүүжилтийн хүү жилийн 30 хувьд хүрэх тохиолдол нийтлэг үзэгдэл болох болжээ. Ингээд зогсохгүй ипотекийн зээлээ даатгуулахыг шаардан даатгалын хураамжийг зээлийн үндсэн төлбөр дээр нэмэх явдал ч элбэг гардаг ажээ. АНУ-ын конгресс шударга бус зээлжүүлэлтийн асуудлаар хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг өрнүүлж, хууль тогтоомжоороо зохих өөрчлөлтийг оруулсаар ирлээ.

ОХУ-ын банкуудын хувьд ч гэсэн зээлжүүлэлтийн энэхүү практик түгээмэл гэдэг нь харагдаж байна. Тухайлбал, Societe General-ийн Орос дахь салбар Русфинанс Банк хүүний орлогын 47 хувийг далд орлогоор бүрдүүлдгээ хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэхүү үзүүлэлт дээд хязгаар биш бөгөөд Оросын нэлээдгүй банкны далд орлогын үзүүлэлт хүүний 60-70 хувийг бүрдүүлдэг хэмээн үзэх мэргэжилтнүүд ч байна.

Монгол улсын ажил хөдөлмөр эрхэлж буй нэг хүнд дунджаар 901.7 орчим мянган төгрөгийн зээл оногдож байна. Гэтэл нэг ажилтны дундаж цалингийн хэмжээ 380 мянган төгрөг юм. Зөвхөн эдгээр тоог харахад л цаашид чанаргүй зээл өсөх бүрэн боломжтой юм. Ялангуяа хөдөө орон нутагт малчид, төрийн албан хаагчид, тэтгэврийн насны иргэдийн дийлэнх нь малчны, цалингийн, тэтгэврийн зээлд хамрагдсан байдал ажиглагддаг. Улирлын орлогыг зохицуулах, аж амьдралаа өөд нь татахад банкуудын үйлчилгээ зохих хувь нэмрээ оруулж байгаа нь дамжиггүй. Гэвч нөгөө талаас цалингийн зээлийг шударга бус зээлжүүлэлтийн сонгодог хэлбэр гэж үздэгийг санавал “зээлийн урхинд” орсон хүмүүсийн эгнээ өдрөөс өдөрт өргөжиж байж болох юм. Цалин тэтгэвэр ямар нэгэн шалтгааны улмаас тасалдсан үед зээл авна, зээлээ хэрэглээнд зарна, эргээд цалин тэтгэврийн мөнгөөр өрөө дарна, дахиад зээл авна – иймэрхүү байдлаар хүмүүс “өрийн цагаригт” орж байна. Сарын 3 хувиар зээл авдаг гэж бодвол зээлийн урхинд орсон хүмүүс жилдээ орлогынхоо 36 хувь буюу 1/3-ийг хүүний төлбөрт өгдөг байж болох юм. Орон нутгийн түвшинд олгосон зээлийн хэмжээ банкны системийн дүнд бага хувь эзэлж байж болох юм. Гэвч ган зуд болж, ноос ноолуурын үнэ огцом унавал маш олон хүн төлбөрийн чадваргүй болж асуудал нийгмийн талаасаа ээдрээтэй болж болох талтай.

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ хурдацтай өсөх нөхцөлд банкууд шинээр зээл гаргах хөшүүрэг дутахын сацуу чанаргүй зээлээс үүдэлтэй алдагдлаа зээлийн өндөр хүүгээр нөхөхөөс өөр сонголтгүй болох юм. Нөгөө талаас банкны зээлийн талаар ойлголт маруухан иргэд шударга бус зээлжүүлэлтэд хамрагдах эрсдэл үлэмж нэмэгдэх бөгөөд ингэснээр зээлийн хүү буурахгүй байх бас нэг хүчин зүйл бүрдэж байна.

Олон улсын туршлагаас харахад шударга бус санхүүжилтийн асуудлыг хуулийн хүрээнд зохицуулах хандлагатай байна. Ингэхдээ хууль тогтоомж нь бодит хүүний түвшинг ил гаргах, нуугдмал бүрэлдэхүүн хэсгүүдийг хүүнд шингээхгүй байхад чиглэгдэх ажээ.

Монгол улс холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ дэлхийн, ялангуяа АНУ-ын туршлагыг сайтар судлах шаардлагатай. Шударга бус зээлжүүлэлттэй тэмцэх үүднээс Холбооны Нөөцийн зөвлөл тусгай Z-журам гаргасан бөгөөд түүний дагуу банкууд олгож буй зээлийн нөхцөл, онцлогийг ил болгохыг шаарддаг байна. Тухайлбал банк тухайн иргэнд кредит карт нээх буюу ипотекийн зээл олгож байгаа бол жилийн хүү хэд байхыг, яагаад ийм хэмжээнд байгааг тов тодорхой тайлбарлах шаардлагатай. Хууль батлагдахаас өмнө банк зээлийн хүүг багаар хэлээд, харин сүүлд нь хүүг 7 хоногоор тооцон хэлснээс биш жилийн илэрхийллээр ийм болно хэмээн луйвардах тохиолдол цөөнгүй байжээ. 1968 онд батлагдсан тус хуулиар “өндөр өртөгтэй” зээлийн ангиллыг тайлбарлахын сацуу хүүг заавал жилийн илэрхийллээр тооцохыг хуульчилжээ. “Өндөр өртөгтэй” зээл олгохыг шууд хорьдоггүй ч тодорхой хязгаарлалттай олгохыг шаарддаг бөгөөд хууль зөрчигдсөн тохиолдолд банк томоохон торгууль хүлээх тухай заасан байдаг.

Манай нөхцөлд ч мөн шударга бус зээлжүүлэлтийн тохиолдол тодорхой хэмжээнд байдаг бөгөөд зээлдэгчид ипотекийн луйвар, шударга бус зээлжүүлэлтийн талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, шударга бус зээлжүүлэлт гэж сэжиглэсэн тохиолдлыг мэдээлж байдаг тогтолцоог бий болгон, үүний дагуу бодлого боловсруулагчид, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд шударга бус, луйврын зээл олгогчдын эсрэг арга хэмжээ авах нь бага орлоготой, өндөр настай иргэд, нийгмийн цөөнх зэрэг шударга бус зээлжүүлэлтэд өртөж болзошгүй эмзэг бүлгийг луйвраас хамгаалахад чухал нөлөөтэй юм.

Манай улсад шударга бус зээлжүүлэлтээс сэргийлэх тухай хууль одоогоор байхгүй ч 2009 онд батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хуулийн 62 дугаар зүйлд зээлдүүлэгч зээл хүсэгчид зээлийн нөхцөл, зээлдэгчид үүсч болзошгүй эрсдэл, барьцааны зүйлийн зохицуулалтын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, мэдээллээр хангах талаар зохицуулалт оруулсан нь хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад, шударга бус зээлжүүлэлтээс сэргийлэхэд чухал алхам болсон билээ. Мөн 2008 онд Монголбанкнаас батлан гаргасан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д зээлдүүлэгчийн үүргийг тусгайлан оруулсан байна. Монголбанкны зүгээс шударга бус зээлжүүлэлт бий болохоос сэргийлэхийн тулд дээрх журмын хэрэгжилтэд сайтар хяналт тавих шаардлагатай юм.

Манай нөхцөлд банкууд шударга бус зээлжүүлэлт буюу зээлдэгчийг хохироосон, шалтгаангүйгээр хэт өндөр хүү, шимтгэл ноогдуулсан тохиолдол байгаа эсэхийг

судалж мэдэх шаардлагатай бөгөөд ингэхийн тулд зээлдэгчдийн дунд санал асуулга явуулах, холбогдох байгууллагад зээлдэгчийн санал, гомдол хүлээн авах ажлын нэгж бий болгох зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй юм.

Үүнээс гадна, зээлдэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг үнэн зөв мэдээллээр хангах нь тэднийг шударга бус зээлжүүлэлтийн золиос болгохгүй байх эхний алхам юм. Зээлдэгчийн идэвхгүй сул дорой байдал, ипотекийн зээлийн талаарх буруу ташаа ойлголт, түр зуурын ашиг хонжоо харах үйлдэл нь шударга бус зээлдүүлэгчид луйвар хийх таатай боломжийг олгодог байна. Бодит амьдрал дээр ипотекийн зээл нь үнэхээр хууль ёсны дагуу байна уу, эсвэл үнэн хэрэгтээ луйврын буюу шударга бус зээлжүүлэлтийн хэлбэр байна уу гэдгийг ялган салгаж ойлгохын тулд энэ талаар байнга мэдээлж байх хэрэгтэй бөгөөд шударга бус зээлжүүлэлтийг хууль ёсны зээлжүүлэлтээс таньж ялгах дараах түгээмэл шинж, хэлбэрүүд байдгийг товчлон танилцуулж байна. Үүнд:

### **Өндөр хүү, шимтгэл**

Зээлдүүлэгч нь зээлийн үнэлгээ хангалтгүй зээлдэгчид зээл олгосноороо илүү их зээлийн эрсдэл хүлээж байгаа тул илүү өндөр хүүтэй зээл олгож, илүү өндөр шимтгэл авдаг. Зээлжих чадвар муутай зээлдэгчид их хэмжээний зээл олгосноор зээлдүүлэгчийн хувьд зээлдэгч төлбөрийн чадваргүй болох эрсдэл нэмэгдэж үүнийг дагаад тэрхүү багцаас олох өгөөжийг нэмэгдүүлж байдаг. Гэтэл өндөр хүү авч байгаа нь үргэлж зээлийн эрсдэлтэй холбоотой байдаггүй. Хэвийн ипотекийн зээлийн шимтгэл нь нийт зээлийн дүнгийн 1 хувиас хэтэрдэггүй бол шударга бус ипотекийн зээлийн шимтгэл нийт зээлийн дүнгийн 5 хувиас ч дээш байх тохиолдол элбэг байдаг байна. Энэхүү илүүдэл зардал нь зээлийн дүнд нэмэгдэж, зээлдэгчийн халааснаас зээлдүүлэгчийн халаас руу урсан ордог.

### **Зээл урьдчилан төлсний торгууль**

Субпрайм (sub-prime) ипотекийн зээлдэгч буюу зээлийн үнэлгээ, зээлийн түүх нь хангалтгүйгээс илүү эрсдэлтэйд тооцогдож хэвийн ипотекийн зээлийн хүүнээс илүү өндөр хүүтэй зээл авсан зээлдэгчид нь аль болох хурдан хугацаанд зээлийн нөхцөлөө сайжруулан дахин санхүүжилт хийх сонирхолтой байдаг. Гэтэл анхны авсан зээлээ хугацаанаас нь өмнө буцаан төлөхөд “урьдчилан төлсний торгууль” маш өндөр байдгаас зээлдэгчийн бий болгосон хөрөнгийг үгүй хийхээс гадна зээлдэгчийг бүр өрөнд оруулдаг байна. Субпрайм ипотекийн зээлийн 80 хүртэл хувь нь урьдчилан төлбөр төлсний торгууль төлдөг бол хэвийн ипотекийн зээлийн зөвхөн 2 орчим хувь нь төлбөр урьдчилан төлсний торгууль төлдөг байна. Тиймээс зээлдэгчид ихэвчлэн өндөр хүүтэй ипотекийн зээлтэйгээ үлдэхээс өөр аргагүй байдалд хүрдэг. Энэ нь шударга бус зээлдүүлэгчдийн ашиг орлого олох бас нэг арга юм.

### **Зээлийн дахин санхүүжилт**

Шударга бус зээлжүүлэлтийн бас нэг хэлбэр бол зээлдүүлэгч зээлдэгчийг өмнөх зээлээ дахин санхүүжүүлэхийг ятган зээлдэгчид ашигтай мэт ойлголт төрүүлдэг. Гэвч зээлдүүлэгчийн гол санаа нь шинэ зээлээс авах шимтгэл, өмнөх зээлээ урьдчилан төлснөөс авах торгууль зэрэг орлогыг бий болгох зорилгоор зээлдэгчийг дахин санхүүжилт хийхийг шахдаг байна. Үнэн хэрэгтээ энэ нь зээлдэгчид маш бага ашигтай эсвэл ямар ч ашиг хонжоогүй үйлдэл байдаг. Одоо байгаа зээлийг дахин санхүүжүүлснээр зээлдэгчийн дансанд их мөнгө хэмнэгдэн орж байгаа мэт боловч энэ нь шинэ ипотекийн зээлийн өндөр хүү, шимтгэл, өмнөх зээлээ урьдчилан төлсний торгууль зэрэгт идэгдэн алга болдог байна. Дахин санхүүжилтийн гол аюултай тал нь хуучин зээлийг баллун зээл болгон өөрчлөхөд үүсдэг. Тухайлбал, өмнөх ипотекийн зээл нь 20 эсвэл 30 жилийн туршид төлөгдөх байсан бол шинэ зээлийн гэрээгээр зээлдэгч 2, 3, эсвэл 5 жилд баллун төлбөр төлөхөөр тохиролцсон байж болно. Хугацааны эцэст зээлдэгч байшингаа дахин санхүүжүүлэх шаардлагатай болох ба эсвэл бүрмөсөн алдахад хүрдэг байна.

### **Даатгал болон бусад шаардлагагүй бүтээгдэхүүн**

Зарим тохиолдолд зээлдэгч шаардлагагүй зүйлд зардал гарган төлбөр төлөх болдог. Учир нь зээлдүүлэгч зээлийн бүтээгдэхүүнтэй хамт зээлдэгчид шаардлагагүй даатгал болон бусад бүтээгдэхүүнийг зарж зээлийн дүнд оруулдаг. Зээлдүүлэгчийн зээлдэгчид худалдан авахыг шаарддаг, зөвлөдөг даатгалд ердийн ипотекийн даатгал, галын болон гэнэтийн ослын даатгал, амь насны даатгал, тахир дутуугийн даатгал, хөрөнгийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэрэг ордог. Зарим тохиолдолд эдгээр даатгалууд нь зөвхөн зээлдэгчийг бус гэр бүлийн гишүүдийг бүхэлд нь хамруулдаг. Эдгээр даатгалын төлбөр нь зээлийн дүнд нэмэгддэг бөгөөд шударга бус зээлдүүлэгч мэдээж энэхүү төлбөрөөс жил бүр хувь хүртэж байдаг.

### **Зээлдэгчийг сонгон удирдан жолоодох**

Шударга бус аргаар зээл олгогчид нь зээлдэгчийг хохироосон олон төрлийн аргыг хэрэглэдэг ба зээлдэгч хэвийн ипотекийн зээлэнд хамрагдаж болохоор байсан ч субпрайм зээлдэгч болгодог байна. Зээлдүүлэгч ихэнхдээ өндөр настай, бага орлоготой иргэд болон нийгмийн цөөнх болсон бүлгийг сонгон зээлийг дахин санхүүжүүлэхийг ятган шахалт үзүүлдэг байна. АНУ-д хийсэн судалгааны үр дүн субпрайм зээлдэгчийн 50 хүртэл хувь нь хэвийн ипотекийн зээлд хамрагдаж болох байсныг харуулсан байна. Энэ нь зээлдэгчийн төлж буй хүү болон шимтгэлийн зардлыг маш ихээр хэмнэнэ гэсэн үг юм.

## Арбитраж

Шударга бус зээлжүүлэлтийн төрөлд багтах бас нэг жишээ бол зээлдүүлэгч өөрийнхөө хууль бус ажиллагааны эсрэг зээлдэгчийг шүүхэд хандах боломжгүй болгосон заалтыг сэм оруулан гарын үсэг зуруулдаг байна. Тиймээс зээлдэгч зээлдүүлэгчийн луйврын болон хууль бус ажиллагааны талаар шүүхэд хандах эрхгүй болдог. Зээлдэгч өөрийн гомдлыг зөвхөн хөндлөнгийн хяналтад тавих л эрхтэй. Харин хөндлөнгийн хяналтын ажиллагаа нь ихэвчлэн зээлдүүлэгчийн талд үйлчилдэг бөгөөд ихэвчлэн нууцаар, зээлдэгчийн төлөөлөлгүйгээр явагддаг. Зээлдэгч хэдийгээр хуулийн зөвлөгч авах боломжтой боловч тэднийг бүрэн төлөөлөх хуульч олж авах нь маш хүндрэлтэй байдаг. Учир нь хуулийн зөвлөхийн хөндлөнгийн хяналттай холбоотой ажлын төлбөр нь баталгаагүй байдаг. Түүнчлэн хөндлөнгийн хяналтын ажиллагаа утсаар явагдах нь элбэг бөгөөд хувь хүний хувьд том компанийн эсрэг гомдол гаргахад процедур нь нууц, нотлох баримтыг бичгээр үйлддэггүй зэрэг нь зээлдэгчийн хувьд үнэхээр сул тал болдог.

Иймээс зээлийн хүү, нөхцөл гэх мэт бүх параметрийг зээлдэгчдэд маш ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарлахыг шаарддаг олон улсын эрх зүйн зохицуулалтыг Монголд нэвтрүүлэх цаг нэгэнт болжээ. Өнөөдөр банкнаас зээл хүсэхдээ чухам ямар нөхцөл, болзол агуулсан гэрээнд гарын үсэг зурж байгаагаа иргэд тэр болгон ухаардаггүй. Шударга бус зээлжүүлэлтийн эсрэг хууль батлагдсанаар зээл авсны дараа гэнэт төрөл бүрийн нуугдмал зардал ил болдог явдлыг таслан зогсоох, зээлдэгчид банкуудыг өөр хооронд нь харьцуулах, эрсдэлээ зөв үнэлж сурахад нь томоохон дэвшил гарах учиртай. Ингэхдээ “бодит хүү” гэсэн нэр томъёог хуулиндаа тусгайлан зааж өгөх шаардлагатай бөгөөд ингэснээр иргэн зээлийн үйлчилгээ авсныхаа төлөө яг хэдий хэмжээний төлбөрийг яагаад төлж байгаагаа бүрэн ойлгож ухамсарласан байх ёстой.

Шударга бус зээлжүүлэлтээс сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авах нь зүйтэй юм.


- Монголбанкны зүгээс шударга бус зээлжүүлэлт бий болохоос сэргийлэхийн тулд “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны” журмын хэрэгжилтэд сайтар хяналт тавих,
- Манай нөхцөлд банкууд шударга бус зээлжүүлэлт буюу зээлдэгчийг хохироосон, шалтгаангүйгээр хэт өндөр хүү, шимтгэл ноогдуулсан тохиолдлыг бүртгэх тогтолцоог бий болгох, холбогдох байгууллагад зээлдэгчийн санал, гомдол хүлээн авах ажлын нэгж бий болгох зэрэг арга хэмжээг авах,
- Шударга бус зээлжүүлэлтээс сэргийлэх зорилгоор зээлдэгчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг үнэн зөв мэдээллээр хангах.

#### 4.4 Зээл олголт ба зээлийн зохицуулалт

Банкны салбар хөлөө олж эхэлсэн 1990-д оны дунд үед банкуудын зээлийн үйл ажиллагаа асар их эрсдэлтэй, маш сул зохицуулалттай байлаа. Монголбанк заавал байлгах нөөц, зээлийн бодлогыг мөрдүүлэх, зээлийг ангилах гэх мэтээр банкуудын төлбөрийн чадварыг тогтвортой байлгах талаар анхаарч ажиллаж ирсэн. Бусад улс орнуудын хяналт шалгалтын байгууллагууд ч хууль, журам, зохицуулалтыг сахиулах, эрсдэлд илүү хянамгай хандахыг банкууддаа анхааруулж ажилладаг.

Банкны хяналт шалгалт сул нөхцөлд банкны салбарын бүтцийн өөрчлөлт удааширч, үр ашиггүй өрсөлдөөнийг сунжруулах, сул банкуудын эрсдэлтэй үйл ажиллагааг хөхүүлэх, чанаргүй зээлийн хувийг нэмэгдүүлэх үндсийг бүрдүүлдэг байна. Сүүлийн жилүүдэд банкуудын зээлийн чанар ямар байгааг доорх зургаар харуулав.

**Зураг 4.2: Банкуудын нийт зээл болон хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**



Эх сурвалж: Монголбанк

2009 оны 5 дугаар сараас өсөж эхэлсэн зээлийн хэмжээ мөн оны эцэст 2.5 их наяд төгрөгт хүрээд байна. Гэвч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ ч эрчимтэй өссөөр байна. Банкуудын зээлийн чанар муудах нь нэг талаас банкуудын эрсдэлээ тооцох, удирдах чадвараас, нөгөө талаас зээл олголттой холбоотой хууль эрх зүйн орчин, зохицуулалт, зээлийн мэдээллийн сан зэргээс шууд хамаардаг. Тухайлбал, зээлдэгч ямар нэгэн байдлаар зээлээ төлж чадахгүйд хүрч, банкны зээлийн чанар муу ангилалд шилжлээ гэхэд барьцаа хөрөнгийн эзэмшигчийн эрхийг шилжүүлэх, улмаар зарж борлуулахад маш их хугацаа алддаг. Банкууд шүүхийн шийдийг хүлээсээр ийн цаг авдаг нь тэдэнд зээлдэгчдэдээ өндөр босго тавихаас аргагүй болгодог. Түүнчлэн банкууд эрсдэлээ хүүндээ шингээдэг учир зээлийн хүү өндөр байхад нөлөөлж буй бас нэг хүчин зүйл болдог байна. Өөрөөр хэлбэл, хүүний түвшинд инфляци

шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх нь ойлгомжтой ч түүнээс гадна хууль эрх зүйн орчин, банкны удирдлагын ур чадвар, Төв банкны хяналт шалгалт зэрэг хүчин зүйлс чухал нөлөөтэй байдаг. Түүнчлэн зээлийн мэдээллийн сан, зээлийн түүх бүрдүүлэх соёл төдийлөн төлөвшөөгүй байгаа нь эрсдэлийг, улмаар зээлийн хүүг нэмэгдүүлэхэд хүргэж байна.

УИХ-аас банкуудын үйл ажиллагааг сайжруулах, Төв банкны хяналт шалгалтын эрх, боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Банкны тухай болон Монголбанкны тухай хуульд өөрчлөлт оруулаад удаагүй байна. Гэхдээ эдгээр хууль шинэчлэгдсэнээр асуудал бүрэн шууд шийдвэрлэгдэнэ гэсэн үг биш юм.

Хөрөнгийн захын хөгжил сул байгаагаас иргэд урт хугацаат санхүүгийн эх үүсвэрийг банкны зээлээр орлуулж байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож чадахгүй иргэд, аж ахуйн нэгжүүд банкны хугацаат зээлээр санхүүжиж, зээлийн хугацаа дуусахад барьцаа хөрөнгийн хязгаарлалтаас болоод илүү өндөр хүүгээр дахин зээлийн хугацааг сунгах тохиолдол их байна. Энэ нь зээлийн эрэлтийг өсгөж, зээлийн хүүг өндрөөр тогтоох шалтгаан болж байна. Тиймээс Засгийн газрын зүгээс урт хугацаат үнэт цаас тогтмол гаргах замаар урт хугацаатай санхүүгийн хэлцлийн захыг хөгжүүлэх шаардлагатай байна.

#### **4.5 Банкны салбар дахь байгууллагын зохистой засаглалыг бэхжүүлэх**

Банкны салбарт үр бүтээлтэй, сайн байгууллагын засаглал нь иргэдийн банкны системд итгэх итгэлийг улам бэхжүүлэхээс гадна, банкны салбарын үйл ажиллагааг зөв, үр ашигтай явуулахад голлох нөлөөтэй байдаг. Харин үүний эсрэгээр байгууллагын засаглал муу байх нь тухайн банкныг дампууралд ч хүргэх, макро эдийн засгийн суурь нөхцөлүүдийг тогтворгүй болгох замаар зах зээлийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Энэ нь банкны салбарын зээлийн хүүг өсгөх сөрөг нөлөөтэй.

Байгууллагын засаглалыг тодорхойлохдоо “компанийн удирдлага, түүний зөвлөл, хувь эзэмшигчид болон бусад хувьцаа эзэмшигчдийн хоорондох харилцааны цогц” гэжээ. Үүнээс гадна байгууллагын засаглал гэдэгт тухайн байгууллагын цогц зорилго болон тус зорилгод хүрэх шаардлага болоод үйл ажиллагааны хяналтын үр дүн зэргийг тусгасан байдаг. Тухайлбал, банкны салбарын хувьд удирдлага болон үйл ажиллагааны бүхий л түвшинд хүн бүр өөрийн байгууллагын үндсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлж, ил тод байдлыг хангаж чадсанаараа хүмүүсийн банкинд итгэх итгэлийг улам бэхжүүлж чаддаг. Банкинд итгэх итгэлийг бий болгоно гэдэг нь цаашлаад тухайн банкны хувьд үйл ажиллагааны болоод санхүүгийн эрсдэлд орох магадлалыг бууруулж байдаг. Гэвч ихэнх бизнесийн байгууллагуудын хувьд бий болдог ажил олгогч-ажилтан хоорондын асуудал (principal-agent problem) нь дээрх сайн засаглалын

үр нөлөөг сулруулж байдаг. Тухайлбал, банкны өмчлөгчид тухайн банкныг удирдах удирдлагыг сонгодог. Өмчлөгчид гүйцэтгэх удирдлагад өөрийн хүсэл сонирхлоо тулгах аваас жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөж, банк нь зөвхөн том өмчлөгчдийн эрх ашгийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад хүрдэг. Энэ үед байгууллагын үндсэн зарчим зөрчигдөж, татан төвлөрүүлсэн хөрөнгө нь өмчлөгчдийн бусад бизнесийг санхүүжүүлэхэд хүрдэг. Харин гүйцэтгэх удирдлагын ашиг сонирхол өмчлөгчдийнхөөс дээгүүр тавигдах тохиолдолд банк ашгийн төлөө ажиллах чадвараа алдаж, үйл ажиллагааны зардлаа өсгөх, мөн гүйцэтгэх удирдлага өөрийн ашиг сонирхлын үүднээс нийгмийн бусад нөлөө бүхий хэсгийг банкны хөрөнгөөр дэмжих, тус дэмжлэгийг санхүүжүүлэхийн тулд хүүг өсгөх зэрэг зохисгүй үйлдэл хийдэг бөгөөд улмаар татан төвлөрүүлсэн хөрөнгө эрсдэлд ороход хүрдэг. Тиймээс байгууллагын засаглалын зохистой байдлыг хангана гэдэг нь дээр дурдагдсан ажил олгогч-ажилтан хоорондын асуудлыг шийдэж, нэгдсэн нэг зорилго, зарчимтай, түүндээ хүрэх тодорхой төлөвлөгөөтэй, түүнийг хянах тогтолцоотой байхыг хэлдэг.

Гадаадын олон улсын байгууллагуудаас хийсэн дүгнэлтээр Монголын банкны системд байгууллагын зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоо муу байгаа нь эрсдэлүүдийг таньж, түүнийг удирдахад саад болж байв. Тухайлбал, хуурамч зээлийн баталгаа гаргах, хамааралтай этгээдүүдэд өгөх зээлд хэт анхаарах, чанаргүй зээлийн ангиллыг хийхдээ журмын дагуу хийхгүй байх зэрэг нийтлэг үйлдлүүд нь арилжааны банкуудын үйл ажиллагааг эрсдэлд оруулж, доголдоход хүргэж байна гэжээ. Энэ байдал сүүлийн 2 жилд эдийн засагт нүүрлэсэн санхүү эдийн засгийн хямралын үеэр илүү тод ажиглагдаж байна. Тухайлбал, Анод болон Зоос банкуудад бий болсон төлбөрийн чадварын хүндрэл, цаашлаад банк дампуурахад хүрсэн гол шалтгаан нь банкны өмчлөгчид болон гүйцэтгэх удирдлагын холбогдох этгээдүүд ихээхэн хэмжээний зээл авсан, зээлийн багцын төвлөрөл хэт өндөр, мөнгөн хөрөнгийн удирдлага сул бөгөөд банкны санхүүгийн үзүүлэлтүүдийг шударга бусаар мэдээлж байсан зэрэг асуудлууд голчилж байв.

Тиймээс цаашид арилжааны банкуудын зохистой засаглалыг бэхжүүлэх, ил тод, нээлттэй, шударга ёсны зарчмуудыг хэрэгжүүлж хэвшүүлэхэд банкинд тавих хяналт шалгалтыг болон хууль эрх зүйн орчинг сайжруулах дараах чиглэлээр бодлогын арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

- Банкуудын өмчлөлийн хэлбэрт стандарт тогтоох. Үүнд, банкуудын өмчлөгчийн тоог өсгөх болон том өмчлөгчийн өмчлөх хэмжээнд хязгаарлалт тогтоох замаар том өмчлөгч, гүйцэтгэх удирдлага хоорондын зөрчлийг бууруулах,
- Банкинд тавих хяналтыг засаглал, эрсдэлийн удирдлагын түвшинд хийж, тухайн чиглэлээр хатуу стандарт тогтоох, тус стандарт нь хэрхэн

- хэрэгжиж байгааг хянах байнгын хяналтын тогтолцоог сайжруулах,
- Арилжааны банкуудын сайн засаглалыг хөгжүүлэхэд олон нийтийн анхаарлыг хандуулж, банкны ил тод, шударга байх зарчмыг хангуулах замаар иргэдээс тавих хяналтын тогтолцоог сайжруулах,
  - “Банкны тухай хууль”-д шинэчилсэн найруулга хийгдсэнтэй холбоотойгоор банкинд тавих нэгдсэн хяналт шалгалтыг хөгжүүлэхэд шаардлагатай холбогдох журам зааврыг шинэчлэх.

Банкны салбарт байгууллагын засаглалыг сайжруулж чадсанаараа банкуудын эрсдэл буурах, үйл ажиллагааг тогтворжуулах нэг алхам болох бөгөөд энэ нь цаашлаад банкуудын ашигт ажиллагаанд эергээр нөлөөлөх боломжтой юм. Мөн илүү эрсдэлгүй үйл ажиллагаа явуулж, олон нийтэд ил тод байж чадсанаараа тухайн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, дан ганц өндөр хүүнд татагдаж эрсдэлтэй банкинд хадгаламж байршуулахаас илүү хүү багатай ч эрсдэл даах чадвар өндөртэй, найдвартай банкинд мөнгө хадгалуулах сонирхол, хэв шинжийг олон нийтэд бүрдүүлэх зэрэг эерэг нөлөөллийг дагуулж байдаг.

## **5. САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**

Санхүүгийн системийн дэд бүтэц сайн хөгжих нь мэдээллийн тэгш байдлыг нэмэгдүүлж, санхүүгийн зуучлал болон үйлчилгээний зардлыг бууруулж, санхүүгийн захын үр ашигтай ажиллагааг нэмэгдүүлдэг. Санхүүгийн захуудын үр ашигтай ажиллагаа нэмэгдэж, санхүүгийн зуучлалын зардал буурснаар зээлийн хүү буурах эдийн засгийн таатай орчин бүрдэнэ. Манай орны хувьд санхүүгийн системийн дэд бүтцийг хөгжүүлэхэд хадгаламжийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх, төлбөр, тооцооны үйлчилгээний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, зээлийн мэдээллийн санг хөгжүүлэх, эх үүсвэрийн зардлыг бууруулах боломжийг нэмэгдүүлэх, банкны ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар харилцагч банкыг мэдэх боломжийг нэмэгдүүлэх болон мөнгөний бодлогод олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг хамруулан энэ хэсэгт авч үзлээ.

### **5.1 Хадгаламжийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх**

#### **Хадгаламжийн даатгал гэж юу вэ?**

Арилжааны банкууд олон улс орны хувьд санхүүгийн системийн цөмийг бүрдүүлсэн хэвээрээ байгаа бөгөөд банкны системийн доголдол нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг алдагдуулан улмаар эдийн засгийн хямралыг өдөөх эрсдэлтэй байдаг билээ. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд банкны хяналт шалгалтыг чангатган сайжруулахын сацуу хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарлаа хандуулдаг ажээ.

Их хямралын үеэр АНУ-д 9 мянга гаруй банк дампуурсан нь 1934 онд Холбооны Хадгаламжийн Даатгалын Корпорацийг байгуулахад хүргэжээ. Энэхүү туршлага амжилттай хэрэгжсэн тул бусад улс орон ч тэр, тухайлбал, Норвеги, Энэтхэг, Канад, Япон зэрэг улс 1960-70-аад онд тус даатгалын тогтолцоог мөн нэвтрүүлжээ. Өнөөдрийн байдлаар хадгаламжаа даатгасан улс орны тоо 95-т хүрээд байна.

Даатгалын тогтолцоо нь эцсийн дүндээ 2 үндсэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг байна. Үүнд:

- Нэгдүгээрт, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг төрөөс хамгаалах, ингэснээр банкны системээс хадгаламж дайжих, зугтаах явдлыг таслан зогсоох.
- Хоёрдугаарт, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах явдал болно.

Хадгаламжийн даатгалын тогтолцоо дээрх зорилтыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг ч банкны эрсдэлтэй үйл ажиллагааг дэвэргэх, хадгаламж эзэмшигчид банкуудыг эрсдэлийн хувьд өөр хооронд нь төдийлөн харьцуулахаа больдог сул талыг мөн агуулж байдаг.

### **Хадгаламжийн даатгалыг нэвтрүүлэх шаардлага, үндэслэл**

Улс орны туршлагаас харахад хадгаламжийн баталгаа нь 2 үндсэн хэлбэртэй байхаар байна. Үүнд төрөөс баталгаа гаргах болон хадгаламжийн даатгал зэргийг дурдаж болно. Төрөөс баталгаа гаргах тохиолдолд зохицуулалтын тодорхой дүрэм байхгүй ч хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах болно гэдгээ Засгийн газар илэрхийлдэг байна. Харин даатгалын тогтолцоотой үед даатгал нь ямар тохиолдолд хэрхэн яаж хэрэгжихийг тов тодорхой тусгасан хууль, эрх зүйн зохицуулалттай байхыг ойлгоно.

Монгол улсын хувьд төрөөс харилцах, хадгаламжид баталгаа гаргадаг тогтолцоог банкны даатгалын системээр өөрчлөн зохион байгуулах цаг болсон байна. Үүнийг хэд хэдэн үндэслэлээр тайлбарлаж болох юм.

Нэгдүгээрт, хэдийгээр төрөөс баталгаа гаргаж буй улс орон цөөнгүй байгаа ч даатгалын тогтолцоо бол дэлхий нийтийн хандлага гэдэг нь сүүлийн 70 гаруй жилийн туршлагаас харагдаж байна. Монгол улсын банкны систем өмнө нь 2 удаагийн хямралд өртөж байсан ч даатгалын тогтолцоог нэвтрүүлээгүй өдий хүрчээ.

Хоёрдугаарт, Анод, Зоос банкны дампуурлыг банкны системийн хямрал гэж үзэх боломжгүй ч үүсэн бий болсон нөхцөл байдал нь зайлшгүй даатгалын системд шилжих шаардлагатайг харууллаа.

Анод, Зоос банкны хадгаламж эзэмшигчдийн мөнгийг тавьж олгох эх үүсвэрийг Монголбанкнаас гаргасан нь Төв банкны тухай хууль тогтоомжтой нийцтэй зүйл биш бөгөөд олон улсын санхүүгийн хямралаас шалтгаалан төсөв алдагдалд орж, улмаар эдийн засаг хямралд орж болзошгүй байсан тул Төв банк Засгийн газрын нэрийн өмнөөс авсан арга хэмжээ юм. Төв банкны эцсийн зээлдүүлэгчийн үүрэг нь төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадвар түр алдагдсан банкинд хамаатай болохоос биш дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсон банкинд хамаарах зүйл биш бөгөөд энэхүү харилцааг анх 1873 онд Англи улсад томьёолсон байдаг. Харин манайд үүссэн нөхцөл байдлыг харахад төсөв, мөнгөний эрх баригчдын хүлээх хариуцлага, зааг ялгаа холилдон маш тодорхойгүй байдал үүссэн нь тодорхой байна.

Гуравдугаарт, “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийг хэрэгжүүлэх явцад маш олон зүйлийг дутуу дулимаг орхисон нь ил болсон билээ. Хамгийн наад зах нь гэхэд хадгаламжийн хүүний төлбөрийг баталгаанд хамруулах эсэх, хэрвээ хамруулахаар бол хүүг хэрхэн тогтоох асуудал тодорхойгүй, харилцах тус баталгаанд хамрагдах эсэх нь ойлгомжгүй байсан нь хүндрэл бэрхшээлийг учруулж байна. Өөрөөр хэлбэл тоглоомын дүрэм өнөөдрийг хүртэл тодорхойгүй байгаа нь холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийг биднээс шаардаж байна.

Дөрөвдүгээрт, татвар төлөгчдийн хөрөнгө санхүүгийн системийг тогтворжуулахад чухал үүрэг гүйцэтгэх ч улс төрийн хувьд шийдвэрлэхэд төвөгтэй, олон нийтийн зүгээс дэмжигдэхээргүй, хүлээн авахгүй байх нийгмийн сэтгэл зүй бүрдэж байгааг анхаарахгүй байж болохгүй. Хэсэг хүмүүс банкаар тоглоод гарсан хохирлыг нь энгийн иргэдэд үүрүүлдэг гэсэн ойлголт олны дунд төрж байна. Цаашид төлбөрийн чадваргүй болсон банк болгоныг улсаас тэтгээд байхгүй, ийм банкиг улс, банкны систем, хадгаламж эзэмшигчдэд хор хохиролгүйгээр түргэн шуурхай зохих хууль тогтоомжийн дагуу дампууруулна гэдгийг олон нийтэд ойлгуулахын тулд хадгаламжийн даатгалын тогтолцоо руу шилжих хэрэгтэй юм.

### **Хадгаламжийн даатгал: олон улсын туршлага**

Хадгаламжийн даатгалын ач холбогдол өдрөөс өдөрт нэмэгдсээр өдгөө дэлхийн 119 гаруй оронд нэгэнт нэвтэрсэн байна. Хөгжингүй улс орны дийлэнх нь сүүлийн 20 жилийн хугацаанд тус тогтолцоог нэвтрүүлсэн нь 80-90-ээд оны банкны системийн хямралтай ч мөн холбоотой байв. Хуучин социалист гэгдэж байсан ихэнх улс орнууд даатгалын тогтолцоонд сүүлийн 10 жилд шилжжээ. Европын холбоо бүх гишүүн орнуудаа хадгаламжийн даатгалын тогтолцоонд нэвтрүүлэхийг шаарддаг байна.

Хүснэгт 5.1-т улс орнуудыг төрөөс баталгаа гаргах болон даатгалын тогтолцоогоор нь ангилан харуулав. Даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн улс орнууд санхүүгийн салбар нь хөгжихийн хэрээр даатгалын системээ ч улам боловсронгуй болгоход анхаарч байдаг байна.

**Хүснэгт 5.1: Хадгаламжийн даатгалын тогтолцоо, улс орноор**

| Даатгалын тогтолцоотой улс орон |                                 | Төрөөс баталгаа гаргасан улс орон |                    |
|---------------------------------|---------------------------------|-----------------------------------|--------------------|
| <b>Африк</b>                    | <b>Европ</b>                    | <b>Африк</b>                      | <b>Европ</b>       |
| Кени                            | Исланд                          | Бенин                             | Эстон              |
| Нигери                          | Итали                           | Буркина Фасо                      | Украин             |
| Танзан                          | Латви                           | Камерун                           | <b>Middle East</b> |
| Уганда                          | Литва                           | Төв Африкийн БНУ                  | Египет             |
| <b>Ази</b>                      | Люксембург                      | Чад                               | Иран               |
| Бангладеш                       | Нидерланд                       | Кот д'Ивуар                       | Ирак               |
| Энэтхэг                         | Польш                           | Экваторын Гвиней                  | Израил             |
| Япон                            | Румын                           | Габон                             | Ливи               |
| Солонгос                        | Словак                          | Гана                              | Саудын Арав        |
| Маршалын арал                   | Испани                          | Гвиней                            | Сири               |
| Филиппин                        | Швед                            | ӨАБНУ                             | АНЭУ               |
| Микронез                        | Швейцари                        | Того                              | <b>Ази</b>         |
| Тайван                          | Турк                            | Заир                              | Австрали           |
| <b>Ойрхи Дорнод</b>             | Англи                           | Замби                             | БНХАУ              |
| Бахрейн                         | Норвеги                         | Зимбабвэ                          | Гонконг            |
| Иордан                          | ОХУ                             | <b>Бөмбөрцгийн баруун хагас</b>   | Индонези           |
| Кувейт                          | <b>Бөмбөрцгийн баруун хагас</b> | <b>Бөмбөрцгийн баруун хагас</b>   | Малайз             |
| Ливан                           | Аргентин                        | Боливи                            | <b>Монгол</b>      |
| Оман                            | Бразил                          | Коста Рико                        | Киргиз             |
| <b>Европ</b>                    | Канад                           | Эквадор                           | Пакистан           |
| Австри                          | Чили                            | Гватемала                         | Сингапур           |
| Бельги                          | Колумби                         | Парагвай                          | Шри Ланка          |
| Болгар                          | Доминикан                       | Кирибати                          | Таиланд            |
| Хорват                          | Сальвадор                       | Уругвай                           | Вьетнам            |
| Чех                             | Гондурас                        |                                   |                    |
| Дани                            | Ямаик                           |                                   |                    |
| Финлянд                         | Мексик                          |                                   |                    |
| Франц                           | Перу                            |                                   |                    |
| Герман                          | Тринидад Тобаго                 |                                   |                    |
| Грек                            | АНУ                             |                                   |                    |
| Унгар                           | Венесуэл                        |                                   |                    |

Эх сурвалж: 1) Deposit Protection Arrangements; Alexander Kyei; IMF, November 1995. 2) Comparative Analysis of Established Deposit Insurance Systems; Gillian Garcia; IMF, September 1998.

Улс орнуудын даатгалын тогтолцооны онцлогийг, тухайлбал нэвтрүүлсэн огноо, даатгал нь сайн дурын эсэх, даатгалд хамрагдах хадгаламжийн төрөл, хэмжээ, санхүүжилт, банкны шимтгэл зэргийг хавсралт хүснэгтээс харж болно. Мэдээж улс орнуудын санхүү, эдийн засгийн хөгжлийн онцлогоос шалтгаалан даатгалын тогтолцоо нь харилцан адилгүй байдаг ч нийтлэг зүйл мөн цөөнгүй байна. Үүнээс зарим нэг нийтлэг зүйлийг тоймлон хүргэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг ихэнх улс оронд төрийн байгууллага хариуцан гүйцэтгэдэг байна. Хувийн хэвшлийнхнээр хариуцуулсан улс орон

маш цөөн байх ажээ. Даатгалын байгууллагын санхүүжилт нь ихэвчлэн банкуудын зүгээс хийгддэг бөгөөд банкуудын шимтгэлийн хувь хэмжээ нь нийт хадгаламжийн 1 хувиас илүү гардаггүй нь харагдаж байна. Цөөн тохиолдолд санхүүжилтэд Төв банк болон Засгийн газар оролцдог байна.

Австри, Канад, Герман, Итали, АНУ-д даатгалын хэд хэдэн тогтолцоо зэрэг үйлчилдэг ч ихэнх улс оронд даатгалын нэгдсэн нэг тогтолцоо хүчин төгөлдөр мөрдөгддөг байна. Даатгалыг заавал хийлгүүлдэг улс орны тоо үнэмлэхүй олонхыг бүрдүүлж байна. Нөгөө талаас сайн дурын үндсэн дээр даатгуулдаг улс орон мөн мэр сэр байх ажээ.

Чухам ямар байгууллагыг даатгалд хамруулах нь өмнөө тавьж буй зорилтоос шууд хамаардаг ч ихэнх тохиолдолд банкууд хамгаалагддаг байна. Хадгаламжийн төрлийн хувьд үндэсний мөнгөн тэмдэгт бүхий хадгаламжийг даатгалд хамруулах нь элбэг байна. Валютын хадгаламж болон банк хоорондын хадгаламж даатгалд ихэвчлэн хамрагддаггүй ажээ.

Ихэнх улс орны хувьд даатгал нь хадгаламжийн үндсэн хэмжээг 100 хувь хамарч байдаг бол цөөн оронд хадгаламжийн үндсэн хэмжээний 80-90 хувийг хамардаг байна. Харин хүүний орлогыг давхар даатгадаг улс орон маш цөөн байдаг нь харагдаж байна.

### **Даатгалын тогтолцоог Монгол улсад нэвтрүүлэх нь**

Хадгаламжийн даатгалын тогтолцоог Монгол улсад нэвтрүүлэх ажил нь үндсэн 3 үе шаттайгаар хэрэгжих ёстой. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх,
2. Төрийн даатгалын агентлагийг бий болгох,
3. Холбогдох журмыг боловсруулах

Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төслийг Монголбанкнаас боловсруулж байна. Тус хууль батлагдсанаар бий болох төрийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны эрх, үүрэг тодорхой болох учиртай.

Дээр авч үзсэн олон улсын туршлагыг харгалзан үзвэл Монгол улсын хадгаламжийн даатгалын тогтолцооны ерөнхий дүр төрх дараах байдалтай байх болов уу. Үүнд:

Даатгалын байгууллага нь төрийн статустай байх бөгөөд түүний үйл ажиллагаанд Монголбанк ямар нэгэн байдлаар оролцохгүй. Үйлчлэх даатгалын тогтолцоо нь зайлшгүй хэлбэртэй байх бөгөөд ингэснээр банкуудын төлөх шимтгэл 0.1-0.25 хувийн хооронд хэлбэлзэх боломжтой. Шаардлагатай тохиолдолд Засгийн газраас санхүүжилт хийгдэж байх зохицуулалтыг мөн

хийх хэрэгтэй. Хадгаламжийн даатгал нь Монгол улсын болон гадаад иргэдийн төгрөгийн хадгаламжийг хамгаалахад чиглэгдэнэ. Ингэхдээ баталгаа нь хадгаламжийн тухайн жилийн гэрээт үндсэн хэмжээг 100 хувь хамрахаас биш хүүний нэмэгдэл орлогыг хамруулахгүй байх нь зүйтэй.

Даатгалын тогтолцоотой улс орнуудад хадгаламжийн хэмжээг бага, дунд, том хэмээн нэгдсэн байдлаар ангилдаг байна. Үүн дээр тулгуурлан даатгалд бүх хадгаламжийг хамруулах уу аль эсвэл тодорхой дүн хүртэл хамруулах уу гэдгээ жич шийдвэрлэдэг байна. Тухайлбал, АНУ-д л гэхэд хадгаламжийн эхний 100 мянга хүртэл ам.долларын хэмжээнд баталгаа гаргаж өгдөг байна. Монгол улсын хувьд хадгаламжийн төвлөрөл маш жигд бус байдаг байна.

#### Хүснэгт 5.2. Банкуудын хадгаламжийн бүлэглэлт

| Хадгаламжийн интервал, төгрөгөөр (\$-ын хадгаламжийг ханшаар нь хөрвүүлэв) | Хадгаламж эзэмшигчдийн тоо | Нийт хадгаламж эзэмшигчдийн тоонд эзлэх хувь | Нийт хадгаламжийн дүнд эзлэх хувь |
|----------------------------------------------------------------------------|----------------------------|----------------------------------------------|-----------------------------------|
| < 0.5 сая                                                                  | 1 206 824                  | 83,0                                         | 5,4                               |
| 0.5-1 сая                                                                  | 101 889                    | 7,0                                          | 2,2                               |
| 1-20 сая                                                                   | 124 573                    | 8,9                                          | 26,0                              |
| 20-50 сая                                                                  | 10 115                     | 0,7                                          | 14,2                              |
| 50-100 сая                                                                 | 2 887                      | 0,2                                          | 9,6                               |
| >100 сая                                                                   | 2 176                      | 0,2                                          | 42,6                              |
| <b>ДҮН</b>                                                                 | <b>1 448 464</b>           | <b>100</b>                                   | <b>100</b>                        |

Эх сурвалж: Монголбанк

Тухайлбал, нийт хадгаламж эзэмшигчдийн 98.9 хувь нь 20 хүртэл сая төгрөгийн хадгаламжтай байна. Харин үлдсэн 1 хувийнх нь хадгаламжийн дүн 20 сая төгрөгийг давдаг ажээ. Нөгөө талаас 20 хүртэл сая төгрөгтэй хадгаламж эзэмшигчдийн мөнгөн дүн нийт хадгаламжийн үлдэгдлийн 5.4 хүрэхгүй хувийг бүрдүүлж байна. Монголбанкнаас явуулсан хадгаламжийн хүүний судалгаанд оролцсон томоохон банкууд 50 сая төгрөг хүртэлх хадгаламжийг жижиг, 50-100 сая төгрөгийн хадгаламжийг дунд, 100 саяас давсан хадгаламжийг том дүнтэй хэмээн ангилдаг байна. Эндээс жижиг (<50 сая) болон дунд (50-100 сая) хэмжээний хадгаламж эзэмшигчдэд буюу 100 сая төгрөг хүртэл хадгаламжтай иргэдийн хувьд даатгалын тогтолцоо бүрэн үйлчилнэ гэхэд нийт хадгаламж эзэмшигчдийн 99.8 хувь нь, хадгаламжийн үлдэгдлийн 57.4 хувь нь бүрэн буюу 100 хувь хамрагдах боломжтой нь харагдаж байна. Харин банк дампуурсан тохиолдолд том буюу 100 саяас дээш төгрөгтэй хадгаламж эзэмшигч эхний 100 сая төгрөгөө баталгаатай эргүүлж авах боломжтой буюу энэ тохиолдолд даатгал нь хадгаламжийн үндсэн дүнгээс доогуур байх болно.

## Даатгалын тогтолцоо ба зээлийн хүү

Даатгалын тогтолцоог сонгодог утгаар нь бүрдүүлснээр зээлийн хүү буурах хэд хэдэн хүчин зүйлс бүрдэнэ гэж үзэж байна. Юуны түрүүнд, банкны системийн тогтвортой байдал хангагдсанаар зээлийн хүү буурах таатай орчин бүрдэх болно. Банк дампуурлаа гэхэд иргэд үймж сандрах шалтаг гарахгүй болно. Ер нь банк дампуурах үзэгдэл бол дэлхийд түгээмэл бөгөөд банкны системийн тогтвортой байдлын үндсэн үзүүлэлт нь дампуурсан банкны тоо бус харин банкны системийн хадгаламжийн дүн байдаг билээ. Өөрөөр хэлбэл, хадгаламж зугтаж эхэлбэл банкны системийн тогтвортой байдал алдагдлаа гэж үздэг байна.

Хоёрдугаарт, даатгалтай улс оронд гадаадын иргэд хадгаламжаа гуйвуулан байршуулах сонирхол өсч байдгийг дэлхийн туршлага харуулж байна. Ингэснээр гадаадын идэвхгүй хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх бөгөөд үүнийгээ дагаад зээлийн хэмжээ ч өсөх боломжтой.

Гуравдугаарт, 100 сая төгрөг хүртэл хадгаламжид бүрэн баталгаа өгснөөр том хадгаламж эзэмшигчид мөнгөн хөрөнгөө аль болох банкуудаар тарааж байршуулах сонирхол нэмэгдэх болно. Тухайлбал 300 сая төгрөгтэй иргэн нэг банкинд хадгаламжийн данс нээлгүүлэх биш, 3 өөр банкинд 100, 100, 100 сая төгрөгийн хадгаламж нээлгүүлэхийг илүүд үзнэ. Ингэснээр том хадгаламж эзэмшигч хадгаламжийн хүүний түвшинг банктai тохирох үед давуу байдлаар нөлөөлөх чадвар буурах болно. Хадгаламжийн хүү буурснаар хүүний зөрүү мөн буурна.

Дөрөвдүгээрт, Засгийн газраас харилцах хадгаламжид албан ёсоор баталгаа гаргасан ч дахиад нэг банк дампуурвал улсын мөнгө хүрэхгүй гэсэн айдас, болгоомжлолыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд иргэдийн дунд дэвэргэсэн хэвээрээ байна. Энэ нь иргэдийн банкинд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, улмаар тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг гар дээр бэлэн байлгах сонирхлыг өөгшүүлж байж болох юм. Хэрвээ байнгын даатгалын тогтолцоог төлөвшүүлэн бүрдүүлж чадвал мөнгөө гар дээр байлгаснаас үүдэлтэй алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх тул банкны хадгаламжийн хэмжээ өсөн нэмэгдэх боломжтой юм.

| Улс орон/<br>Нэвтрүүлсэн огноо | Даатгагдсан<br>хадгаламжийн<br>төрөл | Даатгагдсан<br>хадгалам-<br>жийн хэмжээ | Суурь                 | Төрөл              | Санхүүжил-<br>тийн эх<br>үүсвэр | Банкны<br>шимтгэл           |
|--------------------------------|--------------------------------------|-----------------------------------------|-----------------------|--------------------|---------------------------------|-----------------------------|
| <b>АФРИК</b>                   |                                      |                                         |                       |                    |                                 |                             |
| <b>Кени ©<sup>8</sup> 1985</b> | Бүгд                                 | K Sh 100,000                            | Хадгаламж<br>эзэмшигч | Санхүү-<br>жилттэй | Банк & зээл                     | 0.15%<br>хадгаламжийн       |
| <b>Нигери © 1988/9</b>         | Валютын болон БХ-<br>ынхоос бусад    | N 50,000                                | Хадгаламж<br>эзэмшигч | Санхүү-<br>жилттэй | Банк & зээл                     | 0.937 of 1%<br>хадгаламжийн |
| <b>Танзан © 1995</b>           | Валютын болон БХ-<br>ынхоос бусад    | T Sh 250,000                            | Хадгаламж<br>эзэмшигч | Санхүү-<br>жилттэй | Банкууд & ЗГ                    | 0.1%<br>хадгаламжийн        |
| <b>Уганда (V) 1994</b>         | Валютын болон БХ-<br>ынхоос бусад    | U Sh 3 сая                              | Хадгаламж<br>эзэмшигч | Санхүү-<br>жилттэй | Банкууд & ЗГ                    | 0.2% жилийн<br>хадгаламжийн |

<sup>8</sup> ©- зайлшгүй даатгалтай; (V) –р сайн дурын даатгалтай улс орнууд

## ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

|                               |                                                                        |                                                   |                    |                    |             |                                                              |
|-------------------------------|------------------------------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------|--------------------|-------------|--------------------------------------------------------------|
| <b>АЗИ</b>                    |                                                                        |                                                   |                    |                    |             |                                                              |
| <b>Бангладеш © 1984</b>       | Валютын болон БХ-ынхоос бусад                                          | Tk 60,000                                         | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.4% нийт хадгаламжийн                                       |
| <b>Энэтхэг © 1962</b>         | Банкны болон ЗГ-ын хаас бусад                                          | Re 30,000                                         | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.4% нийт хадгаламжийн                                       |
| <b>Япон © 1971</b>            | Дотоодын мөнгөн тэмдэгтийн хугацаагүй болон хугацаатай хадгаламж       | Y 10 сая                                          | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.12% даатгагдсан хадгаламжийн                               |
| <b>Солонгос © 1996</b>        | Бүгд                                                                   | \$14,600                                          | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.05% нийт хадгаламжийн                                      |
| <b>Маршалын арал (V) 1975</b> | Бүгд                                                                   | US\$100,000                                       | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | Хувьсамтгай                                                  |
| <b>Микронез (V) 1963</b>      | Бүгд                                                                   | US\$100,000                                       | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | Хувьсамтгай                                                  |
| <b>Филиппин © 1963</b>        | БХ-ынхоос бусад бүгд                                                   | P 100,000                                         | Хадгаламжийн хувьд | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.002 хадгаламжийн                                           |
| <b>Тайван (V) 1985</b>        | Чек, хугацаагүй, хугацаагүй, траст сан (валютын болон БХ-ынхоос бусад) | NT \$1 сая                                        | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | US\$100 даатгагдсан хадгаламж тутмаас 1.5 цент               |
| <b>ЕВРОП</b>                  |                                                                        |                                                   |                    |                    |             |                                                              |
| <b>Австри © 1979/96</b>       | ӨАА                                                                    | S 200,000                                         | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилт байхгүй | Банкууд     | N/A                                                          |
| <b>Бельги © 1974/95</b>       | Валютын болон БХ-ынхоос бусад                                          | BF 0.5 сая                                        | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.02% of Санхүүжилттэй пассив                                |
| <b>Болгар © 1995</b>          | ӨАА, БХ-ын болон давуу хүү төлөгддөг хадгаламж орохгүй                 | \$1784                                            | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.5% жилийн шимтгэлийн                                       |
| <b>Хорват © 1997</b>          | ӨАА / Хувийн                                                           | \$15,300                                          | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.8% даатгагдсан хадгаламжийн                                |
| <b>Чех © 1994</b>             | Хувийн хадгаламж                                                       | 100,000 К-ы 80% хүртэл                            | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.5% нийт хадгаламжийн                                       |
| <b>Дани © 1988/98</b>         | Ихэнх нь (валютынх мөн орно)                                           | Dk 250,000                                        | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | Мах. 0.2% хадгаламжийн                                       |
| <b>Франц © 1980/95</b>        | Дотоодын мөнгөн тэмдэгтийн, БХ-ынх мөн хамрагдана                      | F 400,000                                         | Хадгаламжийн хувьд | Санхүүжилт байхгүй | Банкууд     | Хувьсамтгай: алдагдлаас хамаарна                             |
| <b>Финлянд © 69/92/98</b>     | Бүгд                                                                   | 100 percent                                       | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | Нийт активын 0.01%-0.05% хооронд                             |
| <b>Герман © 1966/76/98</b>    | Ихэнх нь (БХ-ынх болон инсайдер хадгаламж орохгүй)                     | 90% хадгаламжийн буюу ECU 20,000                  | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банк & зээл | 0.004% - 0.1% хадгаламжийн                                   |
| <b>Грек © 1993/95</b>         | Ихэнх нь (ЗГ, БХ-ынх болон инсайдер хадгаламж орохгүй)                 | ECU 20,000                                        | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | хадгаламжийн 0.025 хувиас 1.25% хүртэл                       |
| <b>Унгар © 1993</b>           | БХ-ынхоос бусад бүгд                                                   | Ft. 1 сая                                         | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.2% нийт хадгаламжийн                                       |
| <b>Исланд © 1985</b>          | Бүгд                                                                   | Арилжааны банкууд -80%, хадгаламжийн банкууд -67% | Хадгаламж эзэмшигч | Санхүүжилттэй      | Банкууд     | 0.5%-арилжааны банкны хувьд, 0.15%-хадгаламжийн банкны хувьд |

|                        |                                             |                                                                                |                         |                            |                             |                                                                                          |
|------------------------|---------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|-------------------------|----------------------------|-----------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| Ирланд © 1989/95       | Дотоод валютын                              | 80% -эхний<br>L5000, 70%<br>- дараагийн<br>L5000 ба 50%<br>-дараагийн<br>L5000 | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банкууд                     | 0.2%<br>хадгаламжийн;<br>min. of 20,000<br>фунт                                          |
| Итали © 1987/96        | БХ-ынхоос бусад<br>бүгд                     | 100% -эхний<br>200 сая<br>лир, 80%<br>-дараагийн<br>800 сая                    | Хадгалам-<br>жийн хувьд | Санхүү-<br>жилт<br>байхгүй | Банкууд                     | Хадгаламж<br>болон зээл<br>хасах нь<br>өөрийн<br>хөрөнгө болон<br>дахин үнэлгээ          |
| Латви © 1998           | ӨАА / Хувь хүмүүс                           | \$830 2000 он<br>хүртэл                                                        | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банкууд                     | 0.3%<br>даатгагдсан<br>хадгаламжийн                                                      |
| Литва © 1996           | ӨАА / Хувь хүмүүс                           | \$6250                                                                         |                         |                            |                             |                                                                                          |
| Люксембург © 1989      | Хувь хүмүүсийн<br>бүгд (валютынх<br>орно)   | Lux F 500,000                                                                  | Хадгалам-<br>жийн хувьд | Санхүү-<br>жилт<br>байхгүй | Банкууд                     | Алдагдлын<br>зорилттой<br>уялдана                                                        |
| Нидерланд © 1979/95    | Хувь хүмүүсийн<br>бүгд                      | L40,000                                                                        | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилт<br>байхгүй | Банк & зээл                 | N/A                                                                                      |
| Норвеги © 1961         | Бүгд                                        | Хязгааргүй                                                                     | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | 0.015% of total<br>assets                                                                |
| Польш © 1995           | N/A                                         | Max. 90% -<br>ECU 3,000                                                        | N/A                     | N/A                        | N/A                         | N/A                                                                                      |
| Португал © 1992        | Хугацаатай,<br>хугацаагүй, валютын          | Хязгаарлалтын<br>100% хүртэл                                                   | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банкууд                     | 0.2%<br>хадгаламжийн                                                                     |
| Румын © 1996           | ӨАА-н болон БХ-<br>ынхоос бусад ихэнх<br>нь | US\$3,600                                                                      | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | Эрсдэлд<br>суурилсан 0.3%<br>хадгаламжийн<br>(жил болгон<br>инфляциар<br>засварлагдана). |
| Словак © 1996          | ӨАА-н болон БХ-<br>ынхоос бусад ихэнх<br>нь | US\$7,900                                                                      | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | 0.1 – 0.3<br>% банкны<br>хадгаламжийн                                                    |
| Испани © 1977/96       | БХ-ынхоос бусад<br>бүгд                     | Ptas 1.5 сая                                                                   | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банкууд, Төв<br>банк & зээл | 0.15%-0.10%<br>хадгаламжийн                                                              |
| Швед © 1996            | БХ-ынхоос бусад<br>ихэнх нь                 | US\$31,412                                                                     | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | Эрсдэлд суу-<br>рилсан, 0.5%<br>даатгагдсан<br>хадгаламжийн                              |
| Швейцар 1984/93<br>(V) | Зарим                                       | Sw F 30'000                                                                    | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилт<br>байхгүй | Банк & зээл                 | Хувьсамтгай:<br>банкны<br>тайлан тэнцэл,<br>хадгаламжийн<br>нийт дүнгээс<br>хамаарна     |
| Турк © 1983            | ӨАА                                         | TL3сая(3)                                                                      | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | 0.3%<br>хадгаламжийн                                                                     |
| Англи © 1982/95        | БХ-ынхоос бусад<br>дотоод валютын           | L20,000                                                                        | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилттэй         | Банк & зээл                 | not to exceed<br>0.3% of sterling<br>deposits                                            |
| <b>ОЙРХИ ДОРНОД</b>    |                                             |                                                                                |                         |                            |                             |                                                                                          |
| Бахрейн © 1993         | Ихэнх нь (БХ-ын<br>болон ЗГ-ынх<br>орохгүй) | US\$5,640,<br>дараа нь<br>US\$10.4 сая<br>хүртэл давхар<br>даатгал             | Хадгаламж<br>эзэмшигч   | Санхүү-<br>жилт<br>байхгүй | Банкууд                     | Жилийн<br>хязгаар US\$9.4<br>М                                                           |

## ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

|                                     |                                                                  |                                                                       |                                        |                    |                          |                                                                  |
|-------------------------------------|------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|----------------------------------------|--------------------|--------------------------|------------------------------------------------------------------|
| <b>Иордан © 2000</b>                | ЗГ-ын болон БХ-ынхоос бусад дотоод валютын                       | JD 10,000                                                             | Хадгаламж эзэмшигч, байгууллагын хувьд | Санхүүжилттэй      | Гишүүн банкууд           | 0.25% -даатгагдсан жилийн хадгаламжийн                           |
| <b>Кувейт (5)</b>                   | Бүгд                                                             | Хязгааргүй                                                            | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилт байхгүй | Засгийн газар            | Байхгүй                                                          |
| <b>Ливан ©1967</b>                  | Дотоод валютын                                                   | LL 30,000                                                             | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банкууд                  | 0.05-0.02 хадгаламжийн                                           |
| <b>Оман © 1995</b>                  | Ихэнх нь (БХ-ынх орохгүй)                                        | US\$52,000                                                            | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банкууд & Засгийн газар  | 0.2% хадгаламжийн                                                |
| <b>БӨМБӨРЦГИЙН БАРУУН ХЭСЭГ</b>     |                                                                  |                                                                       |                                        |                    |                          |                                                                  |
| <b>Аргентин © 1995</b>              | Валютын болон дотоодын хугацаагүй, хугацаатай бүгд (БХ-ынх орно) | Arg.\$10,000 - 90 хоногийн хадгаламж. Arg.\$20,000 – 90 хоногоос дээш | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк, Төв банкууд & зээл | 0.36 - 0.72% жилийн дундаж хадгаламжийн                          |
| <b>Бразил © 1995</b>                | Ихэнх нь (валютын болон банк хоорондынх орохгүй)                 | US\$17,000                                                            | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.25% хадгаламжийн                                               |
| <b>Канад © 1967</b>                 | Хугацаагүй, хугацаатай, тэтгэврийн (БХ-ынх орохгүй)              | Can.\$60,000                                                          | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.16 of 1% даатгагдсан хадгаламжийн                              |
| <b>Чили © 1986</b>                  | Хугацаатай болон валютын                                         |                                                                       | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилт байхгүй | Засгийн газар            | Байхгүй                                                          |
| <b>Колумби © 1985</b>               | Дотоодын мөнгөн тэмдэгийн                                        | Бүх дүнгийн 25% эсвэл Col.\$10 сая                                    | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банкууд                  | Богино хугацааны пассивын хадгаламж                              |
| <b>Доминикан (V) 1962</b>           | Хугацаатай                                                       | 100%: max. RD8,000                                                    | Хадгаламжийн хувьд                     | Санхүүжилттэй      | Банкууд                  | N/A                                                              |
| <b>Сальвадор 1991</b>               | N/A                                                              | C 30,000                                                              | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилт байхгүй | Засгийн газар            | N/A                                                              |
| <b>Ямайка © 1998</b>                | Бүгд (валютынх орно)                                             | J\$600,000                                                            | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.15% нийт хадгаламжийн                                          |
| <b>Мексик © 1986</b>                | Ихэнх нь                                                         | 100 хувь                                                              | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.3% -даатгагдсан хадгаламжийн, 0.75% - нийт хадгаламжийн        |
| <b>Перу © 1992</b>                  | Дотоодын мөнгөн тэмдэгийн хадгаламж                              | SI. 4600                                                              | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              |                                                                  |
| <b>Тринидад &amp; Тобаго © 1986</b> | Хугацаатай, хугацаагүй                                           | TTS 50,000                                                            | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.2% - хадгаламжийн пассивын дунджаас                            |
| <b>АНУ © 1934/91</b>                | Бүгд                                                             | US\$100,000                                                           | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | Хувьсамтгай: 0.243% - банкуудын хувьд ба 0.248% - thrift-н хувьд |
| <b>Венесуэл © 1985</b>              | Дотоодын мөнгөн тэмдэгийн                                        | Bs. 4 сая                                                             | Хадгаламж эзэмшигч                     | Санхүүжилттэй      | Банк & зээл              | 0.5% нийт хадгаламжийн, 6 сар тутам                              |

Эх сурвалж: 1. Deposit Protection Arrangements; Alexander Kyei; IMF, November 1995, 2. Comparative Analysis of Established Deposit Insurance Systems; Gillian Garcia; IMF, September 1998.

## 5.2 Төлбөр, тооцооны үйлчилгээний үр ашигтай байдал

Аливаа улс орны төлбөр тооцооны үйлчилгээ нь тухайн улсын санхүүгийн зах зээлийн илтгэгч нүүр царай нь болж өгдөг. Төлбөр тооцооны үйлчилгээ нь үр ашигтай байхад банк, санхүүгийн байгууллагын төлбөр тооцооны үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэл, холбогдох зардлыг бууруулснаар зах зээл дээрх хадгаламж, зээлийн хүүг бууруулах нөлөөтэй.

Монгол улсад 1995 онд Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдсанаар бэлэн бус төлбөр тооцоог банкаар дамжуулан хийж байх, бэлэн бус төлбөрийг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт болон төлбөрийн бусад баримтаар гүйцэтгэх эрх зүйн орчныг тодорхойлсон. Түүнчлэн Векселийн тухай хуулийг гаргасан нь бэлэн бус төлбөр тооцооны хамрах хүрээг өргөжүүлж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чухал алхам болсон.

Үүний зэрэгцээ, нэгдсэн цахим сүлжээнд арилжааны банкны төвүүдийг холбож, Монголбанк олон улсын төлбөр тооцооны СВИФТ сүлжээнд холбогдсоноор гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулж, гадаад улс орнуудтай хийх гүйлгээний найдвартай байдал хангагдах болсон.

2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс Монголбанк нь Банк хоорондын их дүнтэй гүйлгээний бодит цагийн горим буюу “Банксүлжээ” системийг нэвтрүүлснээр их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог боловсруулах хугацааг богиносгох, боловсруулалтын бүх шатанд төлбөрийн мэдээллийн бүрэн бүтэн ба аюулгүй байдлыг хангах, харилцах дансны үлдэгдлийн мэдээллийг бодит цагаар хүлээн авах боломжийг оролцогчдод (банкууд болон Сангийн яамны Төрийн сангийн газар) олгосон нь банкуудын эх үүсвэрийн үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангаж өгсөн.

Түүнчлэн тус системээр үнэт цаасны болон валютын арилжааны төлбөр тооцоо хийгдэх боломж бүрдэж, Монгол улсын төлбөр тооцооны систем хөгжлийн шинэ шатанд гарсан юм.

Монгол улсын банкны системд төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад Монголбанк, банкууд болон Сангийн яамны Төрийн сангийн газар орно. 2009 оны эцсийн байдлаар арилжааны 17 банкны 1044 салбар нь иргэд, байгууллагуудад санхүүгийн олон төрлийн үйлчилгээг санал болгож, банк хоорондын төлбөр тооцоог Монголбанкин дахь харилцах дансаар, гадаад валютын төлбөр тооцоог тухайн орны банкин дахь харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байна.

Үүнээс гадна, Төлбөр тооцооны үндэсний зөвлөл нь төлбөр тооцооны системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг цогцоор нь хөгжүүлэх, бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, төлбөрийн системийн эрүүл орчин, жигд ажиллагааг хангахад чиглэсэн бодлогын болон стратегийн баримт бичиг, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж гарган ажилладаг.

Дээрх байгууллагуудаас гадна Монголын банкны холбоо, Санхүүгийн зохицуулах хороо, зарим Банк бус санхүүгийн байгууллага болон Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг байгууллагууд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх эрхтэй байдаг.

Төлбөр тооцооны хэрэгслүүдийн хувьд сүүлийн жилүүдэд нэлээд ахиц гарч одоогоор манай улсад бэлэн бус гуйвуулга, картын төлбөр зэрэг бэлэн бус төлбөрийн төрлийн хэрэгслүүдийг өргөнөөр хэрэглэдэг болсон ба АТМ, ПОС терминал, мобайл банк, телефон банк, интернет банк, мессеж банк зэрэг харьцангуй шинэ хэрэгслүүдийг нэвтрүүлсээр байгаа нь төлбөр тооцооны үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, хүрээг тэлэх, үйл ажиллагааны цагийг багасгах, зардлыг бууруулахад ихээхэн ач холбогдол үзүүлж байна.

Цаашид, төлбөр тооцооны үйл ажиллагааны үр ашигтай байдлыг хангахын тулд:

- Улс даяар бэлэн бус төлбөр тооцооны нэгдсэн системд шилжих, ингэснээр төлбөр тооцоо хийхтэй холбоотой эрсдэл, зардлыг бууруулах
- Зардал багатай, түргэн шуурхай, баталгаатай төлбөр тооцооны хэрэгслүүдийг дэлгэрүүлэх, хэрэгцээтэй үед шинээр хэрэгсэл гаргах
- Үнэт цаасан дээр тулгуурласан хэрэгслүүдийг шинээр гаргах, тэдгээрийг дэлгэрүүлснээр хөрөнгийн зах зээл хөгжих таатай орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

### **5.3 Зээлийн мэдээллийн сан**

Зээлийн мэдээллийн сан нь банк, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-аас зээл авсан зээлдэгчийн тухай ерөнхий мэдээлэл, зээлээ эргэн төлсөн талаарх түүхэн мэдээллийг хадгалах сан бөгөөд тус мэдээллийн сангийн зорилго нь нэг талаас зээлдэгч зээлээ эргэн төлсөн баталгааг гаргаж өгөх, нөгөө талаас банк, ББСБ-ын зээлийн эрсдэл, шинээр зээл олгох үйл ажиллагааны зардлыг бууруулахад оршино.

Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагааны зардлыг бууруулахуйц, түүхэн мэдээлэл агуулсан, боловсронгуй зээлийн мэдээллийн сантай байх нь арилжааны банкныг ирээдүйн чанаргүй зээлийн эрсдэлээс хамгаалах, хадгаламжийн хүүг бууруулж, улмаар энэ нь банкны зээлийн хүүг бууруулах ач холбогдолтой юм.

Зээлийн мэдээллийн сан (ЗМС)-гийн мэдээлэл нь зээлдэгч, баталгаа гаргагч,

аккредитив нээлгэгч, 3 сараас дээш хугацаагаар төлбөрөө гүйцэтгээгүй кредит карт эзэмшигч, зээлээр хийх төлбөр тооцооны эрх бүхий хэрэглэгчийн талаарх банк, ББСБ, Банкны өр барагдуулах газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Эд хөрөнгийн бүртгэлийн алба, Үндэсний татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Санхүүгийн зохицуулах хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хөрөнгийн бирж зэрэг байгууллагаас авсан мэдээлэл болон бусад мэдээллээс бүрддэг.

ЗМС-г шаардлагатай мэдээллээр хангах, баяжуулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалт болон нууцлал, мэдээлэл түгээх үйл ажиллагааг Монголбанкны Хяналт шалгалтын газар эрхлэн гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ, орон нутаг дахь Монголбанкны салбар нь Монголбанкны төв ЗМС-ийн салбарын үйл ажиллагааг эрхэлж тухайн орон нутаг дахь банк, ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн талаар болон зээл төлүүлэх чиглэлээр хийж байгаа ажлын тайланг улирал бүр ЗМС-ийн төвд ирүүлдэг.

Банк, ББСБ нь шинээр зээл олгох, баталгаа гаргах, эх үүсвэргүй аккредитив нээх, кредит карт болон зээлээр хийх төлбөр тооцооны төлбөр хийх хугацаа 3-аас дээш сараар хэтрэх бүрт тус мэдээллийг ЗМС-нд ирүүлэх үүрэгтэй. Түүнчлэн сөрөг мэдээллийн сангийн мэдээллийг банк, ББСБ нь улирал тутамд ЗМС-нд ирүүлнэ. Өнөөгийн байдлаар ЗМС-нд 17 арилжааны банк, 8 ББСБ-аас дээрх мэдээллийг ирүүлж байна.

Нөгөө талаас, ЗМС-аас мэдээлэл авахыг хүссэн банк, ББСБ нь Монголбанктай хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулж зээлдэгчийн талаар дараах мэдээллийг үзэх эрхтэй болно. Үүнд:

- Зээлдэгчийн мэдээлэл
- Зээлийн мэдээ
- Зээлдэгчийн талаарх БӨБГ-ын мэдээлэл
- Барьцаа хөрөнгийн мэдээлэл
- Зээлдэгчийн талаарх ГЕГ-ын мэдээлэл
- Сөрөг мэдээллийн сангийн мэдээлэл
- Зээлдэгчийн талаарх ҮТЕГ-ын мэдээлэл
- Зээлдэгчийн талаарх ИБМУТ-ын мэдээлэл
- Зээлдэгчийн талаарх Хөрөнгийн биржийн мэдээлэл
- Кредит карт эзэмшигчийн тухай мэдээлэл
- Зээлээр хийх төлбөр тооцооны тухай мэдээлэл.

ЗМС-г үр ашигтай, хүүг бууруулах үр нөлөөтэй байлгахын тулд:

- Тус санд агуулагдах зээлдэгчийн тухай мэдээ, мэдээллийн иж бүрэн, түүхэн байдлыг ханган ажиллах нь чухал.

- Зээлдэгчийн өмнө авч байсан зээлийн талаар бодит баримтан дээр тулгуурласан байх.
- Зээлдэгч зээлийг хэрхэн эргэн төлсөн тухай түүхэн баримт бичгийг агуулсан байх. Тухайлбал: хуваарийн дагуу, цаг тухайд нь төлбөрийг шилжүүлж ирсэн эсэх, мөн зээлийг төлөхөд хугацаа хэтрүүлж байсан байдал зэрэг мэдээллийг сөрөг мэдээллийн санд оруулж байх.
- Зээлдэгч өмнө авч байсан зээлээс гадна өөртэй холбоотой бусад төлбөрүүдийг төлсөн байдал. Тухайлбал, олон улсын туршлагаас үзэхэд зээл олгох шийдвэр гаргахад зээлийн хүсэлт гаргагч кредит картын төлбөр, орон сууц, тог цахилгаан, утасны төлбөрөө цаг тухайд нь төлсөн эсэх нь тухайн зээлдэгчийн найдвартай байдлын талаар илтгэх чухал мэдээлэл болж өгдөг.
- Арилжааны банкуудын бүх салбарууд дээр ЗМС-г ашиглах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.
- ЗМС-нд ББСБ-уудыг илүү өргөнөөр хамруулж, эрсдэлийг бууруулснаар зах зээл дээр хадгаламж, зээлийн хүүг хөөрөгдүүлэх аюулаас хамгаалах шаардлагатай байна.


#### **5.4 Эх үүсвэрийн зардал**

Банкны зээлийн хүүг тогтоодог нэг бүрэлдэхүүн хэсэг бол эх үүсвэрийн зардал яах аргагүй мөн байдаг. 2006 онд Монголбанкинд хийгдсэн “Монгол дахь арилжааны банкуудын хүүний зөрүүг судлах нь” судалгаагаар банкуудын үйл ажиллагааны ахиу зардал болон эрсдэлийн зардал буурсан нь зээлийн хүү буурах үндсэн нөхцөл болж байгааг тогтоосон. Харин хадгаламжийн хүү дорвитой буурахгүй байгаа нь банкны салбарын болон банк, хадгаламж зээлийн хоршоод хоорондын эх үүсвэрийн төлөөх үр ашиггүй өрсөлдөөн нөлөөлж байгааг онцолсон байдаг. Өөрөөр хэлбэл, сүүлийн жилүүдийн зээлийн хүүний бууралтын ихэнх нь зээлийн хадгаламжийн хүүний зөрүүгээр тайлбарлагдаж байсан. Тиймээс өнөөгийн нөхцөлд Монголын банкны эх үүсвэрийн зардлыг бууруулах нь эдийн засагт хүү буурах үндсэн нөхцөл болох юм.

Монголын санхүүгийн зах зээл нь банк давамгайлсан хэлбэрээр хөгжиж, банкны салбар нь эх үүсвэрээ харилцах, хадгаламжаар бүрдүүлж ирсэн. Гэвч эдийн засаг хөгжиж, банкны салбарын үйл ажиллагаа тогтворжиж, туршлагажихын хэрээр банкуудын гадаад харилцаа өргөжиж, гадаадаас эх үүсвэр татах, гадны банкуудтай хамтран ажиллах зэргээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх болсон. Энэ нь мөн нөгөө талаас Монголын зах зээлийг гадаадын хөрөнгө оруулагчид сонирхох болсонтой холбоотой юм. Үүнээс гадна дотоодын банк хоорондын зах харьцангуй хөгжиж, банкууд нэгэндээ итгэх итгэл нэмэгдсэнээр банк хоорондын захын арилжаа өсөх хандлагатай болсон нь банкууд эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд

түлхэц болж өгсөн.

Зураг 5.1. Банкуудын эх үүсвэрийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Дээрх зургаас үзэхэд, банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө, эх үүсвэрийн 90-ээд хувь нь дан ганц хадгаламжаас бүрддэг байсан 2003 онтой харьцуулахад 2009 оны байдлаар банк хоорондын зах болон гадаад эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувь хэмжээ нэлээд өссөн болохыг харж болох юм. Гэвч 2009 оны байдлаар нийт эх үүсвэрийн 73 хувийг хадгаламж эзэлж байгаа нь өндөр хүү төлж байгаа манай нөхцөлд эх үүсвэрийн зардал хэт өндөр байх нь ойлгомжтой юм. Үүнээс гадна, хадгаламжийн хүү өндөр хэвээр хадгалагдах болсон өөр нэг шалтгаан нь хадгаламжийн төвлөрөл юм. Өөрөөр хэлбэл, нийт хадгаламж эзэмшигчдийн 0.2 хувь нь буюу 2.2 мянган хүнд нийт банкны системийн хадгаламжийн 43.0 хувь нь байршиж байгаа нь хадгаламжийн хэт төвлөрлийг бий болгож, банкууд том хадгаламж эзэмшигчдийн төлөөх тэмцлийг хүүгээр дамжуулан өрнүүлж байгаа юм.

Зураг 5.2. Хадгаламжид төлсөн хүүний зардал ба хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Зургаас харахад дотоодын банкны салбарт хадгаламжийн хүү хямралын өмнөх үеүдэд харьцангуй бууж ирсэн боловч 2008 оны эхнээс эхлэн эх үүсвэрийн төлөөх тэмцлээс шалтгаалан хадгаламжийн хүү буцаад өсөх хандлагатай болсон. Гэвч банкуудын эх үүсвэрийн байдал 2009 оны эхнээс тогтворжиж ирсэн боловч шинэ зээлийн нийлүүлэлт муу байгаагаас банкуудын зардал өсч, улмаар хадгаламжийн хүүгээ бууруулах сонирхол давамгайлж байна. Харин сүүлийн жилүүдэд банкуудад эх үүсвэрийн зардлаа тогтвортой байлгах боломж олгож байсан гадаад эх үүсвэрийн хувьд дотоод эх үүсвэртэй харьцуулахад зардлын хувьд хямдхан бөгөөд мөн хугацааны хувьд ч урт байдаг. Тухайлбал, гадаадаас эх үүсвэр татах тал дээр хамгийн идэвхтэй ажилладаг Хас банкны хувьд дунджаар жилийн 5-7 хувийн хүүтэй гадаад валютын эх үүсвэрийг ойролцоогоор 3-5 жил, зарим тохиолдолд 10 хүртэлх жилийн хугацаатай татан төвлөрүүлж байна. Мөн ХХБ нь 2007 онд 75 сая ам.долларын бондыг 3 жилийн хугацаатай 8.625 хувийн хүүтэйгээр олон улсын зах дээр арилжаалах замаар эх үүсвэр татсан байна.

Дээр дурдсан мэдээлэлд үндэслэн дүгнэхэд:

- Банкны салбарын эх үүсвэрийн зардлыг бууруулахад бусад төрлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тэр дундаа гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх (мэдээж банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр ханшийн эрсдэл болон түр зуурын ашиг хийх зорилготой мөнгө (hot money) орж ирэх эрсдэлтэй), хөрөнгө оруулалт хийх нааштай орчныг бий болгох
- Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих замаар хямд эх үүсвэрийн боломжийг нэмэгдүүлэх
- Хадгаламжийн хүүг бууруулах чиглэлд хадгаламжийн баталгааны хуулийг даатгалын хууль болгон өөрчлөх, гэхдээ хадгаламжийн хэт төвлөрөл бий болгохгүйн тулд хадгаламж эзэмшигчдийн дийлэнх хувийг эзэлж буй бичил хадгаламж эзэмшигчдийг даатгалд хамруулах боломжийг бий болгох,
- Банкны салбарт үр өгөөжтэй ажиллах орчинг бий болгох, эх үүсвэрийн төлөөх үр ашиггүй өрсөлдөөнийг бий болгохгүйн тулд үр ашиггүй, зардал өндөртэй жижиг банкуудыг нэгтгэх замаар банкны салбарт бүтцийн өөрчлөлтийг хийх зэрэг шаардлагатай байна.

## 5.5 Банкны ил тод байдал

Орчин үеийн банкны үйл ажиллагаа цогц, улам глобал шинж чанартай болсоор байгаа билээ. Олон банк, санхүүгийн байгууллагууд салбар хооронд, улс, үндэстэн дамнан үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ хөрөнгийн болон даатгалын зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон. Энэхүү интеграци нь нөгөө талаар банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдох

үед санхүүгийн системийг савлуулж, улмаар эдийн засгийн хямрал үүсэх эрсдэлийг бий болголоо. Тухайлбал, дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал болон дотоодын банкуудын ил тод байдал, түүн дотроо муу менежмент, муу засаглал (Анод, Зоос)-аас шалтгаалан 2007-2009 онуудад санхүүгийн систем нэлээд савлав. Дээрх байдал нь банкны хяналт шалгалтыг улам сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, засаглалын талаарх хууль эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох шаардлагатайг гэрчлэв.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд нөлөөлөгч нэг гол хүчин зүйл нь банк, санхүүгийн байгууллагын мэдээллийн ил тод байдал юм. Өөрөөр хэлбэл, зах зээлд оролцогчдод пүүсүүд, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн санхүүгийн үзүүлэлтүүдийн хөгжил болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаарх тоон болон чанарын мэдээллийг цаг хугацаанд нь хүргэх явдал юм. **Банкны ил тод байдал гэдэг** нь банкны санхүүгийн нөхцөл байдал, тухайн бизнесийн үйл ажиллагааны онцлог, зах зээлээс хүлээж болзошгүй эрсдэлийн хэмжээ болон эрсдэлээ удирдаж байсан туршлагын талаарх үнэн зөв мэдээллийг тогтмол хугацаанд олон нийтэд хүртээхийг ойлгодог. Банкны үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулснаар санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, зах зээлийн сахилга батыг илүү сайн хадгалах боломж бүрддэг.

Банкны үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал нэмэгдэх нь гүйцэтгэх удирдлага болон өмчлөгч (хөрөнгө оруулагч) хоёрын хоорондох тэгш бус мэдээллийг бууруулж, сайн засаглалыг бий болгосноор үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэж, эх үүсвэрийн зардал буурдаг байна.

Бусад орны туршлагаас харахад банк дараах үндсэн 6 бүлэг мэдээллийг олон нийтэд ил тод болгох ёстой гэж үздэг байна. Үүнд:

- Санхүүгийн үзүүлэлтүүдийн байдал (банкны ашигт ажиллагаа, түүний өнгөрсөн хугацаан дахь гүйцэтгэл, эх үүсвэрийн эргэн төлөлт, хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон өөрийн хөрөнгийн өсөлт).
- Санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой байдал (зохистой харьцааны үзүүлэлтүүд, төлбөрийн чадвар болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд).
- Эрсдэлийн удирдлага болон туршлага (зах зээлийн бүтэц, эрсдэлийг хэмжих, түүнийг удирдах арга, хэрэгсэл болон ирээдүйн хүлээлт).
- Банкны хүлээж болзошгүй алдагдлын хэмжээ (зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл болон хууль эрх зүй, бусад эрсдэлүүд).
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого.
- Үндсэн үйл ажиллагаа, удирдлага болон засаглалын талаарх мэдээлэл (Удирдлагын мэдээлэл, хөрөнгө оруулагчдын танилцуулга, үүрэг хариуцлага, хууль эрх зүй).

Банк, санхүүгийн байгууллагуудын олон нийтэд хүргэж буй дээрх мэдээллүүд нь дараах шинж чанарыг хангасан байх шаардлагатай гэж үздэг. Үүнд:

- Олон талын мэдээллийг агуулсан ба ойлгомжтой байх;
- Мэдээллүүд хоорондоо харилцан хамааралтай бөгөөд цаг хугацааны хувьд хоцрогдолгүй байх;
- Үнэн, зөв байх;
- Бусад санхүүгийн байгууллагын тайлан мэдээтэй харьцуулах боломжтой байх.

Банк дээрх шинж чанарыг хангасан тайлан мэдээг хэрэглэгчдэд хүргэх нь дараах үр ашигтай гэж үздэг. Үүнд:

- Хэрэглэгч банкны санхүүгийн нөхцөл байдлын талаар үнэн, зөв ойлголт авах.
- Хэрэглэгч банкны гаргасан тайлан, мэдээнд итгэх итгэл нь нэмэгдэх.
- Хэрэглэгч банк эрсдэлээ хянах, түүнийг удирдах чадвартай эсэхийг таньж мэдэх (хүлээж болзошгүй эрсдэлийг удирдах, хэмжихтэй холбоотой чанарын болон тоон үзүүлэлтүүд агуулсан мэдээлэл).
- Зах зээлийн тодорхой бус байдал буурах.
- Хөрөнгийн зах зээлээс хямд зардлаар эх үүсвэр татах боломж бүрддэг.
- Хөрөнгө оруулагч өгөөж болон эрсдэлээ илүү нарийн тооцож, улмаар хөрөнгөө үр ашигтай удирдах боломжтой болдог.
- Хувьцаа эзэмшигч нар банкны удирдлагад тавих хяналт нэмэгдэж, удирдлагын үйл ажиллагааны ил тод байдал сайжирдаг.
- Хадгаламж эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагч нар банкны хүлээж болзошгүй эрсдэлийг үнэлж, цаашид түүнийг хазаарлаж чаддаг.
- Зах зээлийн гажуудлыг багасгаж, хэрэглэгч банкны талаарх аливаа сөрөг мэдээлэлд хариу үзүүлэх боломжийг бууруулдаг (Asymmetric information, adverse selection).
- Банк үйл ажиллагаагаа үр ашигтай явуулахын зэрэгцээ эрсдэлээ үр ашигтай удирдах чадвар нь нэмэгддэг.
- Хэрэглэгч болон бодлого боловсруулагчид эрсдэл өндөртэй банкнийг таньж мэдэх боломж нэмэгдсэнээр системийн эрсдэлийг бууруулдаг.
- Ёс суртахууны зөрчлийг бууруулдаг (Moral hazard problem).

**Манай орны хувьд банкны ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлага, үндэслэл**

Бусад улс орнуудын туршлагаас харахад банкны ил тод байдлыг Базелийн хорооноос гаргасан ил тод байдлын үзүүлэлтүүдийг олон нийтэд хүргэснээр хангагдах нөхцөл бүрдэнэ гэж үздэг.


Манай орны хувьд арилжааны банкуудын ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь 2008-2009 оны санхүү, эдийн засгийн хямралаас илүү тодорхой харагдлаа. Тухайлбал:

- Банкууд тайлан мэдээгээ дутуу, дулимаг болон худал гаргасан зөрчил удаа дараалан ажиглагдсаны зэрэгцээ олон нийтэд хугацааны хоцрогдолтой мэдээлдэг.
- Анод, Зоос банкны дампуурал нь банкны засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийг ил тод болгох шаардлага байгааг нотолсон.
- Банкууд харилцах, хадгаламжийн төлөөх өрсөлдөөн их байгаагаас өндөр үнээр хөрөнгө татаж, өөрсдийн танил тал, холбогдох этгээдүүдэд зээл болгон өгч, хажуугаар нь баталгаагүй аккредитив гэсэн хууль бус ажиллагаанд зарим банкууд холбогдсон зэрэг нь банкны засаглалыг ил тод болгох, хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах шаардлага байгааг харуулсан.
- Банкуудын нягтлан бодох бүртгэлийн доголдол, тухайлбал, алдагдалтай холбоотой бүртгэл, санхүүгийн зарим хөрөнгийн талаарх бүрэн бус тодорхойлолттой.
- Чанар нь муудаж буй зээлүүдийг хуримтлуулах сонирхолтой.
- Хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэх сонирхол бага.

### Бусад орны туршлага

Банкны системийн ил тод байдал хэрхэн нэмэгдэж байгааг харуулах зорилгоор Дэлхийн банкнаас 1994 оноос эхлэн 180 гаруй орны 20,000 гаруй банкны мэдээлэл дээр үндэслэн “*Банкны ил тод байдлын индекс (Bank disclosure index)*”-ийг тооцдог болсон билээ.

Зураг 5.3. Банкны ил тод байдлын индекс (2007 он)




Эх сурвалж: Global assessment of bank disclosure practices

Энэхүү индекс нь 0-100 хүртэл утга авах бөгөөд өндөр оноо авах тусам ил тод байдал нэмэгдэж буйг илтгэдэг. Зураг 1-д 2007 оны байдлаар хөгжсөн болон хөгжиж буй орнуудын хувьд “Банкны ил тод байдлын индекс”-ийг харьцуулан харуулав.

Зураг 5.3-ээс улс орон хөгжихийн хэрээр банкны ил тод байдал нь улам нэмэгдэж байгааг харж болно. Мөн хөгжиж байгаа болон хөгжсөн орнуудад банк зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ хэрэглэгчдэд хамгийн бага тайлагнадаг бол орлогын талаарх мэдээллээ хамгийн ихээр тайлагнадаг байна. Тухайлбал, АНУ-ын хувьд банкны ил тод байдлын индекс тооцооны хугацааны туршид маш тогтвортой байгааг зураг 5.4-оос харж болох бөгөөд 2006 оны байдлаар дэлхийн хамгийн ил тод банкны системтэй орон байсан байна.

**Зураг 5.4. Хөгжингүй орнуудын банкны ил тод байдлын индекс**




Эх сурвалж: *Global assessment of bank disclosure practices*

Манай хойд болон өмнөд хөршүүдийн банкны системийн ил тод байдлын индекс сүүлийн жилүүдэд хурдтай өсч байгаа юм. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж буй Бразил, ОХУ, Энэтхэг болон Хятад зэрэг орнуудын банкны ил тод байдлын индексийг зураг 5.6-д харуулав. Дээрх орнуудын эдийн засгийн хурдацтай өсөлтөд банкны салбарын ил тод байдал нэмэгдсэн нь өндөр нөлөө үзүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд Турк улсын банкны ил тод байдлын индекс эрчимтэй нэмэгдэж байгаа нь банкуудын ил тод байдлыг өсгөж, тэдгээр банкуудын зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлсэнд оршиж байна. Мөн үүний зэрэгцээ гадны банкууд дотоодын жижиг банкуудыг өөртөө нэгтгэсэн нь ил тод байдлыг харьцангуй сайжруулсан бөгөөд энэ байдал нь дотоодын бусад банкуудад нөлөөлж чадсан гэж үздэг (spillover effect).


Зураг 5.6. Хөгжингүй орнуудын банкны ил тод байдлын индекс



Эх сурвалж: Global assessment of bank disclosure practices

Манай орны банкны системийн ил тод байдлын индекс 2007 оны байдлаар 47 гарч 177 орноос 132 дугаар байранд орсон үзүүлэлттэй байна. Энэ нь банкны системийн ил тод байдал туйлын хангалтгүй байгааг илтгэж байна. Зураг 5.7–ээс харахад манай арилжааны банкууд бусад эх үүсвэрийн талаарх мэдээллээ олон нийтэд хамгийн өндөр хувьтай хүргэдэг бол зээлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хамгийн хангалтгүй мэдээлдэг байна. Гэхдээ банкны ил тод байдал жил өнгөрөх тутам аажмаар нэмэгдэж байгаа нь сайшаалтай юм.

Зураг 5.7. Ил тод байдлын индекс



Эх сурвалж: Global assessment of bank disclosure practices

**Банкны ил тод байдал болон хүү**

Монгол улсын эдийн засгийн өсөлт байгалийн баялгийн орлогоос шалтгаалан 2009 онд ОУВС-ийн тооцоолсноор 2009-2025 оны хооронд дунджаар 25.5 хувиар өсөхөөр байгаа юм. Гэвч дээрх төсөөллийг одоогийн эдийн засгийн суурь нөхцөлүүд баталж чадахааргүй дүр зураг ажиглагдаж байгаагийн нэг гол хүчин зүйл нь банкны ил тод байдлын асуудал юм. Сүүлийн жилүүдэд арилжааны банкны зээлийн хүү буурч байгаа хэдий ч хадгаламжийн хүү дорвитой буураагүй байгаатай бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, улс төрчид болон олон нийт санал нэгддэг. Өнгөрсөн жилүүдийн зээлийн хүүний бууралтад хадгаламжийн хүүнээс илүүтэй хүүний зөрүү гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Иймд банкны ил тод байдлыг сайжруулж, зээл, хадгаламжийн хүүг бууруулах шаардлагатай юм. Банкны ил тод байдал нэмэгдсэнээр дараах үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- Санхүүгийн зах зээлийн сахилга бат сайжирч, улмаар санхүүгийн тогтвортой байдал хангагдсанаар эх үүсвэрийн зардал буурах нөхцөл бүрдэнэ.
- Хөрөнгө оруулагчдын банкинд итгэх итгэл өсч, хөрөнгийн зах зээл болон бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх боломж нэмэгдсэнээр хадгаламжийн хүү буурах боломжтой.
- Банк ил тод байдлаа нэмэгдүүлснээр банкны удирдлага болон хөрөнгө оруулагчдын хоорондох тэгш бус мэдээлэл (Asymmetric information, agency problem)-ийг бууруулан, ёс суртахууны зөрчил (Moral hazard)-ийг багасгаж, улмаар муу сонголт (Adverse selection)-оос шалтгаалсан эх үүсвэрийн зардлын өсөлтийг хязгаарлана.
- Төв банкнаас банкуудын засаглалд тавих шаардлагыг өндөржүүлэн, хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах, тэдгээрийг ил тод болгох нь эх үүсвэрийн зардал буурахад нөлөөлнө.
- Банк хувьцаа эзэмшигчдийн тоогоо нэмэгдүүлэх, институционал хөрөнгө оруулагчдыг илүү татах болон нэгж хувьцаа эзэмшигчид ногдох өндөр хувийг хязгаарлах бодлого баримтлах нь хадгаламжийн хүү буурах бас нэг нөхцөлийг бүрдүүлдэг.

Дээрх үр дүнд хүрэхийн тулд дараах арга хэмжээг авах хэрэгтэй юм. Үүнд:

- Базелийн хорооноос гаргасан ил тод байдлын үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэд, үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж байх.
- УИХ болон Монголбанкнаас банкны удирдлагад тавигдах мэргэжлийн болон бусад чадварын шаардлагыг өндөржүүлэх, түүнийг хуульчлах шаардлагатай юм.
- Төв банкнаас тавих хяналт шалгалтын үр ашиг нэмэгдэн эрсдэлд суурилсан зохистой харьцааны биелэлтийг бүрэн гүйцэд, үнэн зөв хангуулах нөхцөл бүрдэнэ.

- УИХ болон Монголбанкнаас хувьцаа эзэмшигч, банкны удирдлагатай холбоотой хууль эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох.
- Арилжааны банкууд хувьцаа эзэмшигчдийн тоогоо нэмэгдүүлэх, институционал хөрөнгө оруулагчдыг татах болон нэгж хувьцаа эзэмшигчид ногдох өндөр хувийг хязгаарлах бодлого баримтлах.
- Харилцагчийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх тал дээр банкнаас санаачлагатай ажиллаж, зээлийн мэдээллийн санг бэхжүүлэх шаардлагатай юм.

## 5.6 Мөнгөний бодлогод итгэх итгэлийг сайжруулах

Зээлийн нэрлэсэн хүүний түвшин нь бодит хүү болон инфляцийн хүлээлтээс бүрдэнэ. Харин Төв банкны үйл ажиллагааны үндсэн зорилт нь бага, тогтвортой инфляци байдаг. Иймээс Төв банкнаас олон нийттэй харилцах бодлогын эцсийн зорилго нь инфляцийн хүлээлтийг удирдах чадварт оршиж байдаг. Энэ нь эргээд олон нийтийн зүгээс Төв банкинд итгэх итгэлтэй салшгүй холбоотой. Учир нь олон нийтийн зүгээс итгэл хүлээгээгүй Төв банк мөнгөний бодлогоо үр өгөөжтэй явуулж чадахгүй. Итгэл хүлээхийн тулд Төв банк бие даасан, ил тод, нээлттэй байх ёстой. Төв банк “хэлсэн л бол хийдэг” буюу түүний үг үйлдэл хоёр зөрөх учиргүй. Уламжлалт бус мөнгөний бодлогын үр ашиг өнөөдрийн байдлаар тодорхойгүй байгаа өнөө үед захууд болон олон нийттэй харилцах харилцааны ач холбогдол улам нэмэгдэж байна. Үйлдлээ сайтар тайлбарлах, авсан арга хэмжээ болгоны эерэг болон сөрөг нөлөөг байнга үнэлэх нь юу юунаас илүү чухал юм. Хямралтай үед Төв банк бодлогоо цаг хугацааны хувьд нийцтэй хэрэгжүүлж эс чадваас төв банкны бодлогод итгэх итгэлд сэв сууж эцсийн дүндээ мөнгөний бодлогын үр нөлөө буурна.

Нэн ялангуяа хямралын үеийн Төв банкны бусадтай харилцах харилцаа нь стратегийн ач холбогдолтой асуудал юм. Төв банк олон нийтийг үндсэн бүлгүүдэд ангилж улмаар бүлэг тус бүрийн хувьд харгалзах зорилтуудыг тодорхойлсон байх шаардлагатай. Хэрэгцээ, сонирхол, мөнгөний бодлогыг ойлгох чадвараар нь Төв банк олон нийтийг үндсэн 4 бүлэгт хуваадаг. Үүнд:

- Олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд;
- Засгийн газар болон хууль тогтоох байгууллагууд;
- Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцогсод;
- Төв банкны үйл ажиллагааг ажиглагчид зэрэг орно.

Хэнтэй харилцахаас шалтгаалан арга хэлбэр нь өөр өөр байх боловч нээлттэй, ил тод байх нь нийтлэг зарчим юм. Төв банк хэнтэй, яах гэж, ямар аргаар харилцаж болох талаар Хүснэгт 5.2-д үзүүлэв.

**Хүснэгт 5.2. Төв банкны харилцааны арга хэлбэр, зорилт**

| Бүлгүүд                                             | Зорилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Харилцааны арга хэлбэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-----------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд</b> | <ul style="list-style-type: none"> <li>Мөнгөний бодлогын анхдагч зорилго болох бага инфляцийн тухай ойлголтыг түгээх, дэмжлэг авах;</li> <li>Мөнгөний бодлогын асуудлууд, тэдгээрийн эргэн тойронд гарч буй санал шүүмжлэлийн талаар мэдээлэх;</li> <li>Төв банкны мэргэжлийн ур чадвар, Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх;</li> </ul>                                                                                                                | <ul style="list-style-type: none"> <li>Монголбанкны ерөнхийлөгч нар үг хэлэх, албан бус илтгэл тавих;</li> <li>Инфляцийн хүлээлт бүхий улирлын тайлан гаргах, Захирлуудын Зөвлөлөөс мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрийг сонин хэвлэлд нийтлэх;</li> <li>Хэвлэл мэдээллийн бага хурал, ярилцлага зохион байгуулах;</li> <li>Ерөнхий боловсролын сургуулиудаар брошюр, сургалтын материал тараах;</li> <li>Монголбанкны удирдлага, мөнгөний бодлогын шилжих механизм, бодлогын томъёолол, хэрэгсэл, үйл ажиллагааны тухай мэдээллийг цахим хуудсанд байршуулах;</li> </ul>                                          |
| <b>Засгийн газар, УИХ</b>                           | <ul style="list-style-type: none"> <li>Ил тод байдлаар дамжуулан Төв банкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх;</li> <li>Мөнгөний бодлогын анхдагч зорилго болох бага инфляцийн тухай ойлголтыг түгээх, дэмжлэг авах;</li> <li>Мөнгөний бодлогын асуудлууд, тэдгээрийн эргэн тойронд гарч буй санал шүүмжлэлийн талаар мэдээлэх;</li> </ul>                                                                                                          | <ul style="list-style-type: none"> <li>Монголбанкны ерөнхийлөгч нар үг хэлэх, албан бус илтгэл тавих;</li> <li>Инфляцийн хүлээлт бүхий улирлын тайлан гаргах, Захирлуудын Зөвлөлөөс мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрийг сонин хэвлэлд нийтлэх;</li> <li>УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар улирал бүр мэдээлэл, танилцуулга хийх;</li> <li>Засгийн газар болон УИХ-ын гишүүдэд Монголбанкны бодлого болон үйл ажиллагааны талаар товч мэдээлэл хийх;</li> </ul>                                                                                                           |
| <b>Санхүүгийн захын оролцогсод</b>                  | <ul style="list-style-type: none"> <li>Бодлогын хэрэгсэлд өөрчлөлт гарсан тохиолдолд зах зээлд оролцогсдыг нэгэн зэрэг зохих бүх мэдээллээр хангах;</li> <li>Мөнгөний бодлогын асуудлууд, тэдгээрийн эргэн тойронд гарч буй санал шүүмжлэлийн талаар мэдээлэх;</li> <li>Бодлого боловсруулах, эрсдэлийг үнэлэхэд Төв банкны баримталж буй байр суурийг сурталчилснаар мөнгөний бодлогын хэтийн төлөв, хүлээгдэж буй үр дүнг төсөөлөхүйц болгох;</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Бодлогын шинжтэй мэдэгдлүүдийг танилцуулах хуваарийг урьдчилан мэдэгдэх;</li> <li>Инфляцийн хүлээлт бүхий улирлын тайлан гаргах, Захирлуудын Зөвлөлөөс мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрийг сонин хэвлэлд нийтлэх;</li> <li>Үндсэн бүх мэдэгдлүүд болон бодлогын алхмуудыг ойлгомжтой байдлаар цахим үйлчилгээгээр дамжуулан шуурхай сурталчлах;</li> <li>Олон улсын санхүүгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалт болон валютын менежерүүдэд товч мэдээлэл хийх;</li> <li>Үйл ажиллагааны хэлбэр, түүний боломжтой хувилбарын талаар зөвлөлдөх;</li> </ul> |

|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Төв банкны үйл ажиллагааг ажиглагчид</b> | <ul style="list-style-type: none"> <li>• Мөнгөний бодлогын анхдагч зорилго болох бага инфляцийн тухай ойлголтыг түгээх, дэмжлэг авах;</li> <li>• Бодлого боловсруулах, эрсдэлийг үнэлэхэд Төв банкны баримталж буй байр суурийг сурталчилснаар мөнгөний бодлогын хэтийн төлөв, хүлээгдэж буй үр дүнг төсөөлөхүйц болгох;</li> <li>• Мөнгөний бодлогын асуудлууд, тэдгээрийн эргэн тойронд гарч буй санал шүүмжлэлийн талаар мэдээлэх;</li> <li>• Их сургуулийн түвшний сургалт, судалгааны үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Инфляцийн хүлээлт бүхий улирлын тайлан гаргах, Захирлуудын Зөвлөлөөс мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрийг сонин хэвлэлд нийтлэх;</li> <li>• Монголбанкнаас нийтэлдэг байсан “Судалгааны ажил” товхимолыг сэргээх;</li> <li>• Бодлогын болон техникийн асуудлаар товч мэдээлэл хийх;</li> <li>• Мэдлэг солилцох, судалгааны арга барил хуваалцах үүднээс семинар, хэлэлцүүлэг, конференц зохион байгуулах, гадны Төв банкуудтай сургалт судалгаа хамтран зохион байгуулах;</li> <li>• Монголбанкны удирдлага, мөнгөний бодлогын шилжих механизм, бодлогын томьёолол, хэрэгсэл, үйл ажиллагааны тухай мэдээллийг цахим хуудсанд байршуулах;</li> </ul> |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Дэлхийн Төв банкуудын туршлагаас харахад бусадтай харилцах хамгийн түгээмэл хэлбэрүүдэд Мөнгөний бодлогын зөвлөлөөс (манай тохиолдолд Монголбанкны Захирлуудын Зөвлөл) гарч буй бодлогын шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудаст нийтлэх, хэвлэл мэдээллийн бага хурал зарлах, зөвлөлийн хурлын протоколыг нийтэлж олон нийтийн хүртээл болгох, инфляцийн тайланг нийтлэх зэрэг ордог байна.

Хэвлэл мэдээллийн бага хурал хийлгүүлэх үеэр эдийн засаг, санхүүгийн салбарын үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт хийх, ДНБ болон инфляцийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг зарлах нь нийтлэг байдаг байна. Тухайлбал, Чех улсын Төв банкны зөвлөлөөс гарсан шийдвэрийг тэр даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээхээс гадна мөн өдрийн үдээс хойш хэвлэл мэдээллийн бага хурал зарлан хийлгүүлж илүү дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэдэг байна. Үүнээс гадна 8 өдрийн дараа хурлын протоколыг нийтэлнэ. Улирал болгон Зөвлөлийн зүгээс мөнгө санхүү болон эдийн засгийн үзүүлэлтүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийж Төв банкны цахим хуудсанд байршуулдаг байна. Чехийн Төв банк сар болгон Нөхцөл байдлын тайлан гаргаж зөвлөлөөр хэлэлцүүлдэг байна.

Чили улсын Төв банкны зөвлөл сард нэг удаа мөнгөний бодлогын асуудлыг авч үздэг бөгөөд бодлогын шийдвэрийг албан ёсоор олон нийтэд танилцуулдаг байна. Төв банк нь Мөнгөний бодлогын тайланг жилд 3 удаа гаргах бөгөөд түүндээ эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв байдал, богино болон дунд хугацааны таамаглалыг тусгадаг байна.

Бразил улсын Төв банкны Мөнгөний бодлогын хороо сар тутам 2 өдөр хуралдаж хүүний түвшинд орж буй өөрчлөлтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зарладаг байна. Үүнээс хойш 8 өдрийн дараа хурлын протоколыг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийн хүртээл болгодог байна. Нээлттэй байдлыг улам баталгаажуулах үүднээс хурлын явцад гарсан үзэл бодлын зөрүүтэй байдлыг протоколд тусгадаг байна. Улирлын эцэст Төв банкны Инфляцийн тайлан гардаг бөгөөд түүндээ эдийн засгийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн сацуу инфляцийн таамаглалыг мөн багтаадаг байна.

Финлянд улсын хувьд зөвлөл хуралдсаны дараа Төв банкны Ерөнхийлөгч нь хэвлэл мэдээллийн бага хурал хийж хүүний өөрчлөлтийн шийдвэрийг сурвалжлагчдад танилцуулдаг байна. Ингэхдээ эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийж, төсвийн бодлогод үнэлгээ өгдөг байна. Бага хурлын эцэст сурвалжлагчдын асуултад хариулт өгдөг ажээ.

Английн Төв банк нь мөнгөний бодлогын хорооноос тогтоосон хүүний түвшинг олон нийтэд зарладаг бөгөөд хурлаас хойш 2 долоо хоногийн дараа протоколыг бүрэн эхээр нь нийтэлдэг байна. Протоколд хэлэлцүүлгийн явц, үзэл бодлын зөрүү тусгалаа олохоос гадна тухайн асуудлаар гишүүний өгсөн саналын байдлыг мөн харуулдаг байна. Гишүүд гаргасан шийдвэрээ парламентад мөн тайлбарладаг байна. Үүнээс гадна орон нутагт томилолтоор ажиллах явцдаа бодлогын шийдвэрийг түгээн танилцуулахаас гадна олон нийтийн санал бодлыг газар дээр нь сонсохыг урьтал болгодог байна. Английн Төв банкнаас улирал болгон Инфляцийн тайланг гаргаж түүндээ эдийн засаг болон бодлогын шийдвэр гаргахад нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ, инфляци болон ДНБ-ний хүлээгдэж буй гүйцэтгэлийн үзүүлэлтийг нийтэлдэг ажээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.1-т “Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын зорилго, хэрэгжих хэлбэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хүлээгдэх үр дүнгийн талаар олон нийтэд тайлбарлан таниулах замаар олон нийтийн мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлнэ” хэмээн тусгагджээ. Монголбанк энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд мөнгөний бодлоготой холбоотой гарсан шийдвэр болгоноо өдөр тутмын томоохон сонин хэвлэл болон Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тайлбарладаг байх шаардлагатай. Онцгой тохиолдолд хэвлэл мэдээллийн бага хурал зарлан холбогдох тайлбарыг хүргүүлж байх хэрэгтэй.